**Энэхүү тайлан болон хавсралтууд нь санаачлагын зорилгын үүднээс МОҮИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн оролцогч талуудын хэрэгцээнд зориулсан болно.**

## АГУУЛГА

Товчлолууд ба тодорхойлолтууд ..... 1
1. ОРШИЛ ..... 4
1.1 Зорилго ..... 4
1.2 ОУИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд ..... 4
1.3 Тайлангийн бүтэц ..... 5
1.4 Талархал ..... 5
2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ ..... 6
2.1 Танилцуулга ..... 6
2.2 2011 оны урсгал ..... 6
2.3 Нэгтгэлийн гол зүйлс ..... 6
2.4 Нэгтгэл ажлын процесс ..... 7
2.5 Бусад судалгаанууд ..... 7
2.6 Зөвлөмж ..... 8
3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР ..... 9
4. ХАНДЛАГА ..... 13
4.1. Тайлан нэгтгэлийн хамрах хүрээ ..... 13
4.2. Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал ..... 13
4.3. Оролцогч талууд ..... 13
4.4. Материаллаг байдал ..... 13
4.5. Нэгтгэлийн хандлага ба арга аргачлал ..... 14
4.6. Зөрүүг тодорхойлох ажлын чиглэл, хоорондын уялдаа ..... 14
4.7. Аргачлал ..... 15
4.8. Талуудын оролцооны схем ..... 16
4.9 Хамрагдсан компаниуд ..... 18
4.10 Компаниудын уул уурхайн байршил ..... 18
4.11 Компаниудаас 2011 онд улсын төсөвт төвлөрүүлсэн орлого ..... 19
4.12 Хамгийн их орлого төвлөрүүлсэн компаниуд ..... 19
4.13 Компаниудаас Төр, засгийн багууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг ..... 20
5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ ..... 22
5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал ..... 22
5.2 Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал ..... 22
5.3 Бүх тохируулга хийгдсэний дараах санхүүгийн нийт урсгал ..... 23
6. ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД ..... 24
6.1 Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн шинжилгээ ..... 24
6.2 Татвар, төлбөр, бусад ..... 25
6.2.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ..... 26
6.2.2 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар ..... 26
6.2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр ..... 26
6.2.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ..... 27
6.2.5 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар ..... 27
6.3 Төлбөр ..... 28
6.3.1 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр ..... 28
6.3.2 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр ..... 29
6.3.3 Агаарын бохирдлын төлбөр ..... 29
6.3.4 Газрын төлбөр ..... 30
6.3.5 Ус, рашаан ашигласны төлбөр ..... 30
6.3.6 Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл ..... 31
6.4 Хураамж, үйлчилгээний хөлс ..... 31
6.5 Торгууль ..... 33
6.5.1 Улсын төсөвт төлсөн торгууль ..... 33
6.5.2 Орон нутгийн төсөвт төлсөн торгууль ..... 33
6.6 Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа ..... 34
6.6.1 Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн ..... 34
6.7 Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг ..... 34
6.7.1 Яам, агентлагт өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг ..... 35
6.7.2 Аймаг, нийслэлд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг ..... 35
6.7.3 Сум, дүүрэгт өгсөн мөнгөн болон мөнгө бус хандив, дэмжлэг ..... 36
7. АЖЛЫН ДААЛГАВАРТ ШААРДСАН НЭМЭЛТ СУДАЛГААНУУД ..... 37
7.1 Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлт ..... 37
7.2 СТОУС-ын мөрдөлтийн талаар хийсэн судалгаа ..... 37
7.3 Компаниудаас удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн байдал ..... 38
7.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ ..... 39
7.5 Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа ..... 41
7.6 Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн ..... 43

7.7 Ашиглалтын болон хайгуулын хамгийн олон лиценз эзэмшигч ..... 43
7.8 Гэрээний биелэлтийн судалгааны талаар ..... 44
7.9 Мэдээ тайлангийн чанар ..... 44
7.10 Засгийн газар болон компаниудын оролцоо ..... 45
7.11 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг ..... 48
7.12 Нэгтгэл тайлангийн зөрүүний талаархи судалгаа ..... 51
7.13 Орон нутагт төлсөн татвар, төлбөр, хураамж, хандив дэмжлэгийг аймаг бүрээр нь гаргасан судалгаа ..... 51
8. Асуудал ба зөвлөмжүүд ..... 52
8.1 ОУИТБС-ын нэгтгэл ажлын техник зөвлөмж ..... 54
8.1.1 Анхны зөрүүгийн шалтгаан ..... 54
8.1.2 Орхигдсон орлого/төлбөр ..... 55
8.1.3 Нэгтгэл тайланд хамрагдах компанийг сонгох талаар ..... 56
8.1.4 Тодорхой бус тайлагналаас үүдэлтэй шийдвэрлэгдээгүй зөрүүнүүд ..... 56
8.1.5 Ханшийн зөрүүний асуудлаас үүдэлтэй шийдвэрлэгдээгүй зөрүү ..... 56
8.1.7 ОУИТБС-ын тайлангийн маягтны үзүүлэлтийн талаар ..... 56
8.1.8 Хандив, тусламжийг бүртгэх бодлого, журмын мөрдөлт ..... 57
8.1.9 АМГ-ийн лизензийн мэдээлэл дэх алдаатай байдал ..... 57
8.1.10 Нэгтгэл ажлын хүрээнд гэрээлэгчдийг оролцуулах ..... 57
8.2 Нэгтгэл ажлын удирдлагыг сайжруулах зөвлөмжүүд ..... 58
8.2.1 ОУИТБС-ын тайлагналын урсгалын шаардлага ..... 58
8.2.2 ОУИТБС-ын тайлагналд хойрго ханддаг байдал ..... 58
8.2.3 Компаниудын санал гомдлын талаар ..... 59
8.2.4 Нэгтгэл тайлангийн ажил цаг үеэ олоогүй талаар ..... 59
8.2.5 Компаниуд мэдээллийг буруу бэлтгэдэг талаар ..... 59
8.2.6 ОУИТБС-ын оролцооны үнэлгээ ..... 60
8.2.7 ОУИТБС-ын тайланг нийтлэх ажлыг боловсронгуй болгох талаар ..... 60
8.2.8 АМГ-ын мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах талаар ..... 60
8.3 Олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиглагдсан бусад асуудлууд ..... 60
8.3.1 Байгаль орчны нөхөн сэргээлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох ..... 60
8.3.2 Уул уурхайн НББ-тэй холбоотой санхүүгийн хариуцлагыг сайжруулах ..... 60
8.3.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сайжруулах талаар ..... 61
8.3.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар ..... 61
8.3.5 Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн гэрээг тодорхой болгох талаар ..... 61
Хавсралт А. Нэгтгэлийн дүнд үүссэн тохируулгууд (1)–санхүүгийн урсгалаар ..... 62
Хавсралт Б. Хамрагдсан компаниудын жагсаалт ..... 89
Хавсралт В (а). Шийдэгдээгүй зөрүүнүүд-(Яам, агентлаг, орон нутгийн байгууллага, компаниар, санхүүгийн урсгалаар) ..... 92
Хавсралт В (б). Шийдэгдээгүй зөрүүний тайлбар-*(компаниар, санхүүгийн урсгалаар)* ..... 95
Хавсралт Г. Анхны нэгтгэлийн зөрүүнүүд (ЗГ-ын байгууллагаар, компаниар, санхүүгийн урсгалаар) ..... 114
Хавсралт Д (а). Яам, агентлагийн мэдээлэл ..... 129
Хавсралт Д (б). Яам, агентлаг, төсвийн байгууллагын мэдээлэл ..... 130
Хавсралт Е. Орон нутгийн захиргааны байгууллагын мэдээлэл ..... 133
Хавсралт Ё. Компаниудын мэдээлэл ..... 134
Хавсралт Ж (а). Сангийн сайдын 45 тоот тушаалын хэрэгжилт - Төр, Засгийн байгууллага ..... 147
Хавсралт Ж (б). Сангийн сайдын 45 тоот тушаалын хэрэгжилт - *Орон нутгийн байгууллага* ..... 148
Хавсралт З. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын хэрэглээ ..... 153
Хавсралт И. Удирдлагын хариуцлагын захидал ..... 161
Хавсралт Й (а). Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ ..... 164
Хавсралт Й (б). Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн орлого ..... 167
Хавсралт К. Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа ..... 171
Хавсралт Л (а). Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээ ..... 180
Хавсралт Л (б). 2011 оны байдлаар нийт ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшигчдийн жагсаалт ..... 188
Хавсралт М. Орон нутгийн захиргааны байгууллагатай хийсэн гэрээний судалгаа ..... 204
Хавсралт Н. Төрийн байгууллагуудын оролцооны үнэлгээ ..... 208
Хавсралт О. Орон нутгийн захиргааны байгууллагын оролцооны үнэлгээ ..... 208
Хавсралт Ө. Компаниудын оролцооны үнэлгээ ..... 209
Хавсралт П. Компаниудаас үзүүлсэн хандив, дэмжлэг ..... 215
Хавсралт Р. Хандив, дэмжлэг болон бусад санхүүгийн урсгал -(аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр) ..... 243
Хавсралт С. Мэдээллийн эх сурвалжууд-Засгийн газрын байгууллагууд ..... 364
Хавсралт Т. Байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмын жагсаалт ..... 366

**Товчлолууд ба Тодорхойлолтууд**

| | |
|---|---|
| АМГ | Ашигт малтмалын газар |
| АХ | Ажлын хэсэг (ОҮИТБС) |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| АТӨЯХАТ | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| АТГ | Авто тээврийн газар |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр |
| Ам.доллар | Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар) |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| АМГГУУКХ | Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс |
| АМГУУСХ | Ашигт малтмалын газрын уул уурхай судалгааны хэлтэс |
| БОАЖГ | Байгаль орчин, аялал жуулчлалын газар (аймгийн) |
| БГД | Баянгол дүүрэг |
| БОА | Байгаль Орчны Алба |
| БО | Байгаль орчин |
| БОНС барьцаа | Байгаль орчин нөхөн сэргээх барьцаа |
| БХБЯССХОЗА | Барилга хот байгуулалтын яамны сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба |
| БОХНЯ | Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам |
| БТСХ | Биеийн тамир спортын хороо |
| БНГ | Байгалийн нөөцийн газар |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БХГ | Бүтээгдэхүүн хуваах гэрээ |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар |
| ГТГ | Газрын тосны газар |
| ГХБГЗЗГ | Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар |
| ГИХАЭГ | Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ЕТГ | Ерөнхийлөгчийн тамгын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар (нийслэл, аймаг, дүүрэг сум) |
| ЗД | Засаг дарга |
| ЗБҮӨАТ | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар |
| ЗГ | Монголын засгийн газар |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| ММНБИ | Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт |
| МОҮИТБС | Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга |
| МҮГХ | Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбоо |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз |
| МУУҮА | Монголын уул уурхайн үндэсний ассоциаци |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар (аймгийн) |
| МБСГ | Мэргэжлийн боловсрол, сургалтын газар |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| НБОУХ | Нягтлан бодогчдын Олон Улсын Холбоо |

| | |
|---|---|
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ОҮИТБС | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга |
| ОНЗЗ | Орон нутгийн засаг захиргаа |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| УУЯ | Уул уурхайн яам |
| УНДЕГ | Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар |
| УТОХГ | Улсын төсвийн орлого хяналтын газар |
| УДЭТ | Улсын драмын эрдмийн театр |
| ҮЗ | Үндэсний зөвлөл |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ҮХЭХАТ | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар |
| СЭЗБЗГ | Санхүү, эдийн засгийн бодолго зохицуулалтын газар |
| СХЗГ | Стандартчилал, хэмжил зүйн газар |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СХД ЭМНэгдэл | Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл |
| СЯ | Монгол улсын Сангийн яам |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СЭЗХ | Санхүү, эдийн засгийн хэлтэс |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ТАН | Төлсөн авсанаа нийтэл |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| ТӨХ | Төрийн өмчийн хороо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЗА | Тээвэр зохицуулалтын алба |
| ТЗГБ | Төр, Засгийн газрын байгууллага |
| Төг. | Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт (төгрөг) |
| ХБХМ | Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| ХҮХ | Халамж үйлчилгээний хэлтэс |
| ХЦА | Хилийн цэргийн анги |
| ХХЕГ | Хил хамгаалах ерөнхий газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХҮГ | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХК | Хувьцаат компани |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ЦЭГ | Цөмийн энергийн газар |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ШШҮТ | Шүүхийн шинжилгээний үндэсний төв |
| ЭБЭХЯ | Эрдэс баялаг эрчим хүчний яам |
| ЭНЭШТөв | Эх нялхсын эрдэм шинжилгээний төв |
| ЭСЯ | Элчин сайдын яам |
| ЭЦГ | Эрүүгийн цагдаагийн газар |

***“Харт Нойрс” Лтд***
***Мэргэшсэн Нягтлан бодогчид***

89 High StreetThame, Oxfordshire
3EH England

Tel: 44 01844 21 88 36

Website: www.hart-nurse.co.uk

***“Улаанбаатар Аудит***
***Корпораци” ХХК***

“Маргад Центр” Төвийн 4-р давхар,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Их тойруу, Улаанбаатар хот
Монгол улс

Утас: 976-11-321844, 329430, 70110744
Факс: 976-11-321844
Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод**
**Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг**
МОҮИТБСАА
Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,
Туушин компаний байр, 306 тоот

2012 оны 11 сарын 28-ны өдөр

Англи улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консерциум нь Монголын ОҮИТБСАА-ны зүгээс МОҮИТБС-ын 6 дугаар тайлан буюу 2011 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон гэрээ байгуулсан билээ.

Энэхүү гэрээт ажил нь АОУС буюу тохиролцсон горимын дагуу гүйцэтгэх ажилтай уялдан Холбогдох үйлчилгээний стандартын дагуу хийгдсэн болно. Гэрээт ажлын горимууд нь тайлан болон түүний хавсралтууд нь Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу гүйцэтгэгдсэн.

Бид олж илрүүлсэн зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнаж байна. Учир нь гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Ажлын хэсгийн оролцогч талууд болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

**“Харт Нойрс” Лтд**
**Мэргэшсэн Нягтлан бодогчид**

**“Улаанбаатар Аудит**
**Корпораци” ХХК**

# 1. ОРШИЛ

Энэхүү тайлан нь Монголын ОҮИТБС-ын зургаадугаар тайлан буюу 2011 оны Нэгтгэлийн гэрээт ажлын тайлан юм.

2010 оны 10 дугаар сарын 19-ны өдөр ОҮИТБС-ын Олон улсын удирдах хороо Монгол Улсыг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын шаардлагыг хангасан орноор зарлан, хүлээн зөвшөөрсөн байна.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Ажлын хэсэг болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Тайлан нь доорхи 3 ботиос бүрдэнэ:

Боть I – Үндсэн тайлан болон гол хавсралтууд
Боть II – Хавсралтууд (200 компанийн тохируулгын хүснэгт ба тайлбарууд)
Боть III – Хавсралтууд (Тайлантай холбоотой бусад)

Үндсэн тайлан болон гол хавсралтуудыг хэвлэмэл байдлаар бэлтгэж, Боть II болон Боть III-г CD-нд хуулж, Боть I-д хавсаргасан болно.

### 1.1 Зорилго

Энэхүү Гэрээт ажлын зорилго нь ОҮИТБС-ын Дүрэм (2011)-н дагуу Монгол Улсын уул уурхайн болон газрын тосны салбарын компаниуд болон Засгийн газар хоорондын төлбөр болон орлогыг олон нийтэд ил тод, найдвартай байдлыг тодорхойлоход оршино. Энэхүү гэрээт ажил нь уул уурхайн болон газрын тосны салбарын 2011 онд хийгдсэн материаллаг төлөлтүүд болон орлогуудын нэгтгэл, дүн шинжилгээ болон олборлох үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн зарим нэг онцгой нөлөөллүүдийн нэмэлт тайлагнал зэргийг багтаасан.

### 1.2 ОҮИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд

#### 1.2.1 Засгийн газар

Сангийн Яам нь Засгийн газрын яам, агентлагуудаас ирүүлсэн мэдээллийг ОҮИТБС-ын маягтын дагуу бэлтгэн гаргаж өгсөн. МОҮИТБС-ын 6 дугаар тайлан буюу 2011 оны Нэгтгэлд оролцсон Засгийн газрын яам, агентлагуудын нэрсийг дор харуулав. Үүнд:

- Сангийн Яам
- Татварын ерөнхий газар
- Байгаль Орчин, Ногоон хөгжлийн Яам
- Ашигт малтмалын газар
- Газрын тосны газар
- Гаалийн ерөнхий газар
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
- Цөмийн энергийн газар
- Төрийн өмчийн хороо

Нэгтгэл тайлангийн явцад анхны зөрүүний шалтгааныг тодруулах зорилгоор дээрхи байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн. Уг албан бичигт, хариу мэдээллийг албан бичиг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан ирүүлэх талаар дурьдсан. Хариу ирүүлсэн байдал болон нэгтгэл тайлангийн явцад харилцаж ажилласан албан тушаалтны мэдээллийг Хавсралт “Д-ийн а,б”-д харуулсан болно.

Түүнчлэн орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүнг тодруулах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газруудад албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авч ажилласан. Хамрагдсан байгууллагуудын нэрсийн жагсаалтыг Хавсралт “Е”-д харуулсан болно.

#### 1.2.2 Компаниуд

Энэхүү нэгтгэлд Сангийн яамнаас тодорхойлсон улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээрээ 40 сая төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамжийг төлсөн олборлох үйлдвэрлэл эрхэлдэг 200 компани хамрагдсан.

Хамрагдсан компаниудын нэрсийн жагсаалтыг Хавсралт “Б”-д, компаниудын мэдээллийг Хавсралт “Ё”-д харуулсан болно.

**1.3 Тайлангийн бүтэц**

Энэхүү тайлан нь дараахи бүтэцтэй:

а. Гүйцэтгэлийн хураангуй

б. Монголын олборлох үйлдвэрлэлийн талаар

в. Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ашигласан бидний арга хандлага

г. Тайлагнан ирүүлсэн мөнгөн болон мөнгөн бус урсгалын (төлбөрүүд болон орлого) нийт дүн

i. МОҮИТБСАА-д анхлан ирүүлсэн дүн
ii. Анхны зөрүүнүүдийг нэгтгэсний дараахи байдлаархи дүн. Үүнийг хамрагдсан компаниудаас ирүүлсэн мэдээлэл болон тайлбарууд дээр суурилан хийх боломжтой байсны дагуу хийсэн.

д. Шийдэгдээгүй зөрүүнүүдийн дүнг төлбөр, орлогын төрөл тэдгээрийн тухай мэдээлэл болон тайлагнасан дүнгүүд нь нэгтгэгдэн шийдэгдээгүй үлдсэн компаниудын нэрсийн хамт харуулсан байдал

е. Гэрээт ажлын явцад ажиглагдсан асуудлуудын нэгтгэл

ё. ОҮИТБС-ын процесс болон ил тод байдлын үйл ажиллагааг сайжруулахад зориулан өгч буй зөвлөмжүүд

ж. Анхны зөрүүнүүд, хийгдсэн залруулгууд болон шийдэгдээгүй зөрүүнүүдийн дэлгэрэнгүйг компани болон санхүүгийн урсгалын төрлөөр нь шинжилсэн ба эдгээрийг Хавсралтууд болон холбогдох анхан шатны баримтуудын хамт харуулсан.

**1.4 Талархал**

Засгийн газрын харьяа байгууллагуудын болон уул, уурхайн компаниудын гол албан тушаалтнуудтай уулзах, тэдэнтэй холбоо тогтоох, холбогдох газруудад захидал явуулах, хүлээн авах зэрэгт дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын ОҮИТБСАА-ны Ш. Цолмон тэргүүтэй хамт олонд, “Харт Нойрс” Лтд болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн хамтарсан консерциумын хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлье.

# 2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

## 2.1 Танилцуулга

“Харт Нойрс” Лтд болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн хамтарсан консерциум нь Монголын ОУИТБС-ын зургаадугаар буюу 2011 оны нэгтгэл тайлангийн ажлыг 2012 оны 8 дугаар сарын 6-наас 11 дүгээр сарын 12-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Нэгтгэлийн ажлын явцад Ажлын хэсгийн хуралдаанд 2 удаа танилцуулсан.

## 2.2 2011 оны урсгал

Засгийн газрын хүлээн авсан нийт санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ нь энэхүү нэгтгэлийн явцад баталгаажуулснаар анхны зөрүүгийн хамт нийтдээ 2,150,734 сая төгрөг байгааг дараах хүснэгтэд үзүүллээ. Нэгтгэлийн ажлын явцад ЗГ-ын талд 330.2 тэрбум төгрөгийн нэмэгдэх залруулга, компанийн талд 807.9 тэрбум төгрөгийн нэмэгдэх залруулга хийсэн нь Засгийн газар болон компаниудаас анхлан ирүүлсэн мэдээлэл материаллаг хэмжээний алдаатай, эдгээр алдаануудыг засах шаардлагатай нь нэгтгэлийн үр дүнгээс харагдаж байна.

**(сая төгрөгөөр)**

| | Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр | | Анхны нэгтгэл | | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Тохируулгын дараа | | Шийдэг дээгүй зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газар | Компанийн дүн | | Засгийн газар | Компани | Засгийн газар | Компани | |
| **1** | Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг | | **1,757,684** | **1,260,098** | **497,586** | **298,423** | **795,859** | **2,056,106** | **2,055,957** | **150** |
| **1.1** | Татвар, хураамж | | 1,501,661 | 970,963 | 530,698 | (168,719) | 361,935 | 1,332,942 | 1,332,897 | 45 |
| **1.2** | Төлбөр | | 35,163 | 19,961 | 15,202 | 1,809 | 17,135 | 36,972 | 37,096 | (124) |
| **1.3** | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл | | 64,030 | 51,917 | 12,113 | 1,982 | 13,926 | 66,012 | 65,842 | 170 |
| **1.4** | Хураамж үйлчилгээний хөлс | | 31,868 | 22,525 | 9,343 | 1,264 | 10,561 | 33,132 | 33,086 | 46 |
| **1.5** | Төрийн өмчийн ногдол ашиг | | 45,144 | 45,102 | 42 | 0 | 42 | 45,144 | 45,144 | - |
| **1.6** | Засгийн газрын орлого ба бусад орлого | | 78,352 | 23,761 | 54,591 | 461,469 | 516,060 | 539,821 | 539,821 | - |
| **1.7** | Торгууль | | 1,466 | 125,870 | (124,404) | 618 | (123,799) | 2,085 | 2,071 | 14 |
| **2** | **Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | **56,043** | **56,590** | **(547)** | **10,521** | **10,056** | **66,564** | **66,646** | **(82)** |
| **2.1** | Татвар | | 4,712 | 26,452 | (21,740) | 138 | (21,588) | 4,850 | 4,864 | (14) |
| **2.2** | Төлбөр | | 16,306 | 27,396 | (11,089) | 9,866 | (1,177) | 26,172 | 26,219 | (47) |
| **2.3** | Хураамж, үйлчилгээний хөлс | | 49 | 356 | (307) | 398 | 106 | 448 | 463 | (15) |
| **2.4** | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | | 34,917 | 2,116 | 32,802 | 2 | 32,804 | 34,919 | 34,919 | - |
| **2.5** | Торгууль | | 58 | 270 | (212) | 117 | (88) | 176 | 182 | (7) |
| **3** | **Бусад төлбөр ба зардал** | | **6,747** | **26,232** | **(19,485)** | **21,317** | **1,973** | **28,064** | **28,206** | **(142)** |
| 3.1 | Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа | | 999 | 1,679 | (680) | 257 | (419) | 1,256 | 1,261 | (4) |
| 3.2 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | | 5,748 | 24,553 | **(18,805)** | 21,059 | 2,392 | **26,807** | 26,945 | (138) |
| 3.2.1 | Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг | Мөнгөн хандив, дэмжлэг | 5,266 | 15,032 | (9,766) | 15,187 | 5,517 | 20,453 | 20,549 | (96) |
| 3.2.2 | | Мөнгөн бус хандив, дэмжлэг | 482 | 9,521 | (9,039) | 5,873 | (3,125) | 6,355 | 6,396 | (42) |
| **Нийт дүн** | | | **1,820,474** | **1,342,920** | **477,553** | **330,261** | **807,888** | **2,150,734** | **2,150,809** | **(75)** |

## 2.3 Нэгтгэлийн гол зүйлс

Энэ удаагийн нэгтгэлийн томоохон дүн бүхий зөрүүнүүд дараах асуудлуудаас шалтгаалан үүссэн байна. Үүнд:

- “Хүний хөгжлийн сангийн тухай” хуулийн 3.2.4-д “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсэг...” нь сангийн орлогын эх үүсвэр болно гэж заасан. Дээрх хуулийн дагуу ЗГ нь 2011 онд ”Оюу толгой” ХХК-иас хөрөнгө оруулалтын гэрээнд заасан үүргийн дагуу төлөхөөр тохиролцсон урьдчилгаа төлбөр болох 125.4 тэрбум төгрөг, “Эрдэнэс таван толгой” ХК-иас 336.1 тэрбум төгрөгийг Хүний хөгжил санд

хүлээн авсан. ЗГ нь хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүдийг ОҮИТБС-ын тайландаа огт тусгаагүйн улмаас их хэмжээний зөрүү үүссэн.

- “Оюу толгой” ХХК нь ЗГ-т төлсөн 125.4 тэрбум төгрөгийг “торгууль” гэсэн ангилалд тайлагнасан байна. “Эрдэнэс таван толгой” ХК анхны тайландаа ЗГ-т төлсөн 336.1 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг огт тусгаагүй орхигдуулсан. Иймд эдгээр дүнгүүдийг ОҮИТБС-ын дүрэмд заасны дагуу ЗГ-т төлсөн санхүүгийн урсгал гэж үзэн нэгтгэлийн тайланд нэмж тохируулан, нийт санхүүгийн урсгалын дүнд оруулсан.
- ЗГ-ын байгууллагууд болон компаниуд ОҮИТБС-ын тайлангийн маягтаа үнэн зөв бөглөж ирүүлдэггүйгээс их хэмжээний зөрүү үүсч байна.
- Хувь хүний орлогын албан татвар нь ОҮИТБС-ын тайлангийн маягтад тусгагдах санхүүгийн урсгал биш юм. Гэтэл ЗГ 4.2 сая төгрөг, компаниуд 22,300 сая төгрөгийн ХХОАТ-ыг тайландаа тусгасан нь 22,296 сая төгрөгийн зөрүүг үүсгэсэн.
- ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөр, хураамж, төсвийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнг бүрэн хамруулж, нэгтгэж чадаагүйгүйгээс их хэмжээний анхны зөрүү үүссэн.
- Энэхүү нэгтгэл тайланд хамрагдаж буй 200 компанид ЗГ-ын тайланд хамрагдаагүй 18 компани, ОҮИТБС-ын тайлангаа ажлын албанд ирүүлээгүй 58 компани орсон нь анхны зөрүү үүсэхэд материаллаг хэмжээгээр нөлөөлсөн ба нэгтгэлийн явцад ЗГ-ын холбогдох байгууллагууд болон тайлангаа гаргаж өгөөгүй компаниуд руу хандаж нөхөн тайлан болон нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулах замаар томоохон хэмжээний анхны зөрүүг шийдвэрлэсэн.

### 2.4 Нэгтгэл ажлын процесс

Дараах асуудлууд нь нэгтгэх ажлын үйл явцад ихээхэн хүндрэл учруулж байсан. **Үүнд:**

1. ОҮИТБС-ын Ажлын алба болон СЯ харилцан зөвшилцөж, ОҮИТБС-ын нэгтгэлд хамрагдах 200 компанийн жагсаалтыг гаргасан.

   Уг жагсаалтанд лицензээ бусдад шилжүүлсэн “Синчи Ойл” ХХК (шатахуун түгээх компани) болон “Ээрмэл” ХХК (нэхмэл эдлэлийн компани) компаниудыг хамруулсан мөртлөө “Баярконстракшн” ХХК, “Ди Би Эи Экс” ХХК, “Никуайро” ХХК, “Ричфлүйрт” ХХК болон Сэлэнгэминералс зэрэг тус бүр 10 гаруй лиценз эзэмшдэг, 98-130 сая төгрөгийн хооронд татвар болон төлбөр төлсөн компаниудыг уг жагсаалтанд хамруулаагүй байна.

   Ажлын хэсгийн зүгээс нэгтгэл хамрагдах компаниудын жагсаалтыг гаргадаг процедур нь тодорхойгүй байна. Тухайлбал, Үндэсний зөвлөл нь 40 сая төгрөгөөс дээш төлбөр төлсөн компаниудыг нэгтгэл тайланд хамруулахаар шийдвэрлэсэн. Сангийн яамнаас 518 компанийн жагсаалтыг гаргасан боловч хэрхэн 200 компанийг сонгосон нь тодорхой бус байна.

### 2.5 Бусад судалгаанууд

1. Монгол Улсын Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаал хэрэгжээгүй гэдгийг тайлан нэгтгэлийн ажлын явц харуулж байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Ж-ийн а,б” ба тайлангийн 7.1-ээс үзнэ үү)
2. Нэгтгэлд хамрагдсан компаниудын Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын хэрэгжилтийн талаар хийсэн судалгаанаас үзэхэд компаниудын зөвхөн 12.5 % нь л бүх СТОУС-уудыг дагаж мөрддөг гэсэн хариу ирүүлсэн. (Дэлгэрэнгүйг Хавсралт “З” ба тайлангийн 7.2-оос үзнэ үү)
3. Нэгтгэлд хамрагдсан компаниудын 74.5 хувь буюу 149 компани “Удирдлагын хариуцлагын захидал”-ын хариуг ирүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “И” ба тайлангийн 7.3-аас үзнэ үү)
4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг 83 компанийн мэдээллийг нэгтгэн харуулсан. Үүнээс 6 компани нь л байгаль хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба дунджаар төлөвлөснөөс давсан байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Й-ийн а,б” ба тайлангийн 7.4-өөс үзнэ үү)
5. Уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх судалгааг 128 компанийн мэдээллийг АМГ гаргаж ирүүлсэн. Энэ нь уг төлөвлөгөөнүүд дунджаар хэсэгчилэн биелэгдсэн гэж харагдаж байна. Хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг 45 компани, газрын тосны 13 компани байсан. (Дэлгэрэнгүйг Хавсралт “К” ба тайлангийн 7.5-аас үзнэ үү)
6. Ашиглалтын болон хайгуулын лицензийн судалгааг АМГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хийсэн. 2011 оны эцсийн байдлаар, 398 ашиглалтын лиценз, 545 хайгуулын лицензийг нэгтгэл тайланд хамрагдсан 187 компани эзэмшиж байна. 13 компани нь газрын тосны үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд байсан. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Л-ийн а,б” ба тайлангийн 7.6-р зүйлээс харна уу)
7. Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниас хамгийн олон лиценз эзэмшиж буй 20 компанийн 10 нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Л-ийн а,б” ба тайлангийн 7.7-оосүзнэ үү)
8. Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниас орон нутгийн засаг захиргаатай хийсэн гэрээний судалгааг 21 компани буюу дөнгөж 10 хувь нь хариу ирүүлсэн. (Дэлгэрэнгүйг Хавсралт “М” ба тайлангийн 7.8-аас үзнэ үү)
9. Компаниудын гаргаж ирүүлж байгаа мэдээ тайлангийн чанар маш доогуур, мэдээ тайлангийн үнэн зөв бэлтгэхэд хандаж буй хандлага сул зөвхөн нэр төдий байдлаар тайланг бөглөж ирүүлэх байдал ажиглагдаж байна. (Дэлгэрэнгүйг тайлангийн 7.9-өөс үзнэ үү)

10. Нэгтгэлийн явцад үүссэн зөрүүний шалтгааныг тодорхойлж, тохируулгыг хийхдээ холбогдох яам, агентлаг, Төр, төсөв, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас мэдээллийг авч ажилласан. (Дэлгэрэнгүйг Хавсралт "С"-ээс үзнэ үү).

**2.6 Зөвлөмж**

Цаашид нэгтгэх ажлыг сайжруулах зорилгоор бид дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

Бид нэгтгэл ажлын явцад үүссэн асуудлууд болон асуудал тус бүр дээр зөвлөмжүүдийг бэлтгэсэн. Өмнөх жилүүдэд өгч байсан хэд хэдэн зөвлөмжүүд хэрэгжээгүй байгаа нь ажиглагдсан.

Бид зөвлөмжөө дараах байдлаар ангилан харуулав. Үүнд:

- Нэгтгэл ажлын талаарх техник зөвлөмжүүд (8.1)
- Нэгтгэл ажлын удирдлагыг сайжруулах зөвлөмжүүд (8.2)
- Олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиглагдсан асуудлууд (8.3)

Нэгтгэл ажлын тухайд, сүүлийн зургаан жилийн хугацаанд Засгийн газар болон компаниуд өмнөх алдаанаасаа суралцаагүй, хүлээж байсан өөрчлөлт, дэвшил гараагүйгээс анхны зөрүү (Засгийн газрын тайлан болон компанийн бэлтгэсэн тайланг харьцуулсанаас үүссэн)-нд дорвитой өөрчлөлт гараагүйг цохон тэмдэглэмээр байна. Бид анхны зөрүү үүссэн шалтгаанууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар анхаарлаа хандуулсан. (8.1.1)

Засгийн газар нь анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг нэгтгэдэггүй байна. Иймээс аймаг, сумдаас тайлан хүлээж авах, тэдгээрийг төвлөрүүлж нэгтгэх систем нь тохиромжтой биш, шинэ систем нэвтрүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Тайлагнах маягтын загвараас үүдэн ердийн бус шинжтэй томоохон гүйлгээнүүдийг хамруулж чаддаггүй. Тухайлбал, "Оюу Толгой" ХХК-иас хөрөнгө оруулалтын гэрээний дагуу өгсөн урьдчилгаа төлбөр байна. Энэ нь тайлангийн маягтанд тохиромжтой нэрээр тусгагдаагүй байна. Иймэрхүү төрлийн ажил гүйлгээг урьдчилан таамаглах боломжгүй учир маягтанд шинэ мөрүүд нэмж оруулах хэрэгтэй. (8.1.2)

Нэгтгэл ажлыг хамгийн материаллаг дүн бүхий төлбөрүүдэд хандуулахыг зөвлөж байна. Үндэсний зөвлөл нь 2010 онд 10,000 төгрөг (7 ам.доллар)–с дээших дүн бүхий гүйлгээ бүрийг нэгтгэлд хамруулна гэж шийдвэрлэсэн. Ингэснээр нийт орлого эсвэл нэгтгэлийн зөрүүний ойлголтонд ихээр нөлөөлөхөөргүй бага дүн бүхий маш их хэмжээний гүйлгээ нэгтгэлд хамрагдаж байгаа юм. Үндэсний зөвлөл нь уг хязгаарыг нэмэгдүүлэх талаар дахин бодолцож үзэхийг санал болгож байна. Хандив зэрэг зарим төрлийн санхүүгийн урсгалыг анхааралдаа авбал материаллаг байдлын түвшинг санхүүгийн урсгалын ангилал бүрд нь өөр байдлаар тогтоож болох юм.

Ямар нэгэн уул уурхайн лиценз байхгүй гэсэн 2 компани нэгтгэлийн жагсаалтад багтсан байсан. Тэд 2011 оноос өмнө өөрсдийн лицензийг бусдад шилжүүлсэн гэж тайлбарласан. Хэрэв нэгтгэлд орох компаниудын жагсаалтыг АМГ-ын мэдээллийн бааз үндэслэн гаргадаг нь зөв бол тэд хэрхэн жагсаалтад орсон тухай асуудал үүсч байна. Иймд АМГ-ын мэдээллийн баазад бүртгэлийн үнэн зөв байдал болон лицензийн шилжүүлэгтэй холбоотой асуудлыг шалгаж үзэх нь зүйтэй байна. (8.1.9)

2012 оны ОУИТБС-ын тайланд туслан гүйцэтгэгч компаниудыг (дэд гэрээлэгч) оруулах шийдвэр гарсаныг бид мэдэж байна. Хэрэв энэ үйл ажиллагааг аажмаар явуулвал Ажлын хэсэг бидний жагсаалтаар гаргасан хэд хэдэн практик асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай болно. (8.1.4 болон 8.1.10)

Засгийн газрын хүлээн авсан хандив тусламжийг бүртгэх асуудал бэрхшээлтэй байсаар байна. Мөнгөн бус хандив, тусламжийн үнэлгээг тохиролцоход компаниуд болон Засгийн газарт сайн журам шаардлагатай байна. Төрийн байгууллагууд нь Сангийн Сайдын 45-р тушаалаар батлагдсан "Хандив тусламжийг бүртгэх" журмыг зөрчин, мөнгөн хандивыг бүртгэдэггүй байдал түгээмэл байна. (8.1.8)

Анхны зөрүү болон шийдэгдээгүй үлдсэн зөрүүний үүссэн гол шалтгаан бол ажил гүйлгээг бүрэн, үнэн зөв тайлагнах компаниудын болон Засгийн газрын байгууллагуудын хариуцлага дутагдсанаас үүдэлтэй. 2011 онд энэ байдал илүү ажиглагдаж байна. Өнгөрсөн саруудад нэгтгэл тайлангийн ажлын явцад төрийн байгууллагын ажиллагсад сонгуулийн ажил гээд, компанийн ажиллагсад талбарын хайгуулын болон олборлолтын ажил хийгээд завгүй байсан. Жишээ нь: Засгийн газрын байгууллагууд бидний хүсэлтэд тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн оронд задаргаагүй, бөөн дүнгээр мэдээллийг гаргаж өгч байсан.

ОУИТБС-ын тайланг бэлтгэх систем Засгийн газар болон олон компаниудад хэрэгжихгүй байгаа нь тодорхой байна. Энэ үйл явц чиглэлээ олоогүй байна. Системийн дутагдалтай байдал нь өөр зорилго бүхий системээс авсан мэдээллийг учрыг олоход жил бүр онцгой арга хэрэглэх шаардлагыг бий болгож байна. Энэ нь хүнд ажил төдийгүй гаргаж өгч байгаа мэдээ тайлангийн чанар нь түүнийг бэлтгэж байгаа хувь хүнээс ихээхэн хамааралтай байгаа ба их дүнгээр зөрж байгаа мэдээллийн үнэн зөв байдалд байнга хяналт хийх шаардлагатай.

Засгийн газар тайландаа тусгаагүйн улмаас шалгах шаардлагатай гүйлгээний хувьд нэмэлт мэдээлэл шаардах, баримтжуулахад төвөгшөөдөг асуудал байсаар байна. Энэ нь босгыг бага тогтоосонтой холбоотой юм.

## 3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР

Монгол улс нь байгалийн баялгийн хувьд ихээхэн нөөцтэй ба ялангуяа, алт, зэсний ордын нөөцөөрөө дэлхийд томоохонд тооцогддог. Монгол улс нийт 1,3 триллион ам.долларын нөөцтэй гэж тооцоологдсон бөгөөд өнөөдрийн байдлаар 1,170 ашигт малтмалын орд, 7,654 илэрц тэмдэглэгдсэн байдаг байна. Эдгээр илэрцэд зэс, алт, нүүрс, молибдени, төмрийн хүдэр, уран, цагаан тугалга, вольфрам, мөнгө, цайр, хайлуур жонш зэрэг 60 гаруй төрлийн ашигт малтмал багтаж байна.

2011 онд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт:

- нүүрс олборлолт (22.6%),
- газрын тос, шатдаг хий олборлолт (16.8%),
- Металлын хүдэр олборлолт (4.1%),
- бусад ашигт малтмал олборлолт (-14%),

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт:

- төмрийн үйлдвэрлэл (-9.2%),
- кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл (34.1%) зэрэг дэд салбаруудын үйлдвэрлэлд өөрчлөлт орсон байна.

2009-2011 онд үйлдвэрлэсэн уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дараах байдалтай байна.

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|
| Нүүрс | мян.тн | 14 442.1 | 25 161.9 | 32 029.7 |
| Газрын тос | мян.бар | 1 870.0 | 2 181.4 | 2 548.9 |
| Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр | мян.тн | 370.9 | 357.1 | 347.4 |
| Молибдений баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлснээр | тн | 5 125.0 | 4 677.1 | 4 163.1 |
| Алт | кг | 9 803.3 | 6 037.1 | 5 702.6 |
| Хайлуур жонш | мян.тн | 628.8 | 727.0 | 658.7 |
| Хайлуур жоншны баяжмал | мян.тн | 115.3 | 140.7 | 116.4 |
| Төмрийн хүдэр | мян.тн | 1 379.0 | 3 203.2 | 5 678.3 |
| Цайрын баяжмал | мян.тн | 141.5 | 112.6 | 104.7 |
| Гянт болдын баяжмал | Тн | 38.6 | 19.9 | 12.6 |
| Давс олборлолт | Тн | 5.0 | - | - |

*Эх сурвалж: Монгол улсын Үндэсний статистикийн хороо*

2009-2011 онд экспортлосон гол нэрийн бараа дараах байдалтай байна.

| Гол нэр төрлийн бараа | Хэмжих нэгж | 2009 | | 2010 | | 2011 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Дүн | Тоо хэмжээ | Дүн | Тоо хэмжээ | Дүн |
| Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт | тн | 11 | 308,473 | 5 | 178,339 | 3 | 113,047 |
| Зэсийн баяжмал | мян.тн | 587 | 501,924 | 569 | 770,594 | 573 | 963,596 |
| Молибденийн хүдэр ба баяжмал | мян.тн | 7 | 50,309 | 5 | 51,989 | 4 | 46,394 |
| Жоншны хүдэр ба баяжмал | мян.тн | 314 | 48,224 | 406 | 68,825 | 404 | 94,877 |
| Тунгаасан зэс ба хайлш | тн | 2,321 | 11,850 | 2,800 | 20,357 | 2,361 | 21,028 |
| Төмрийн хүдэр | мян.тн | 1,598 | 88,770 | 3,564 | 253,825 | 5,753 | 437,328 |
| Нүүрс | мян.тн | 7,113 | 306,301 | 16,726 | 881,998 | 21,106 | 2,250,046 |
| Боловсруулаагүй нефть | мян.бар | 1,939 | 115,633 | 2,071 | 154,386 | 2,541 | 252,192 |
| Цайрын хүдэр баяжмал | мян.тн | 151 | 122,494 | 120 | 134,135 | 121 | 142,678 |
| | | | **1,553,977** | | **2,514,449** | | **4,321,186** |

*Эх сурвалж: Монгол улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яам*

**Нүүрс**

Монгол улс 2011 онд нийт 30.9 сая тонн нүүрс олборлож, үүний 21.1 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна. Улсын экспортын 40 гаруй хувийг нүүрсний салбар бүрдүүлж байна. Монгол улсын нийт экспорт 4.8 тэрбум ам.долларт хүрсэний 2.25 тэрбумыг нь нүүрсний экспорт эзэлж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгойн нүүрсний орд газарт “Эрдэнэс-Тавантолгой”ХК, “Энержи Ресурс”ХХК, “Тавантолгой”ХК (Хувьцааны 51 хувь нь орон нутгийн өмч), Гурвантэс сумын Нарийн сухайтын нүүрсний ордод “Монголын алт”(МАК) ХХК, “Чинхуа-МАК-Нарийнсухайт”ХХК, “Саусгоби сэндс”ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж нүүрс экспортод гаргасан мэдээг дараах байдлаар үзүүлж байна.

**Нүүрсний экспортын мэдээ**

**мян.тн**

| д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Экспортын гүйцэтгэл | | | Урьд оноос өссөн |
|---|---|---|---|---|---|
| | | 2009 | 2010 | 2011 | |
| 1 | Энержи ресурс ХХК | 1,400.0 | 4,100.0 | 4,633.9 | 533.9 |
| 2 | Таван толгой ХК | 2,800.0 | 4,000.0 | 6,064.7 | 2,064.7 |
| 3 | Эрдэнэс-Таван толгой ХК | | | 280.8 | 280.8 |
| 4 | Монголын алт МАК ХХК | 1,371.9 | 5,200.0 | 5,285.0 | 85.0 |
| 5 | Чинхуа МАК нарийн сухайт ХХК | 740.9 | 1,820.0 | 1,775.6 | (44.4) |
| 6 | Саус гоби сэндс ХХК | 1,327.4 | 2,500.0 | 3,088.4 | 588.4 |
| | **Нийт** | **7,640.2** | **17,620.0** | **21,128.4** | **3,508.4** |

**Зэс**

Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь Монголын хамгийн том зэсийн үйлдвэрлэлийг явуулж байна. Уг үйлдвэр нь дэлхийн хамгийн том 10 зэс-молибденийн порфир эрдэсжилтийн талбай бүхий ордын нэг бөгөөд 2010 онд л гэхэд дангаараа ДНБ-ий 12 орчим хувийг эзэлж, бүх зэсийн хүдэр болон баяжмалын үйлдвэрлэлтийг бүрдүүлж байна.

Оюу толгой нь дэлхийд зэс, алтны хамгийн том ашиглалтанд ороогүй орд бөгөөд Эрдэнэт үйлдвэрээс 3 дахин том гэж тооцогдож байна. Оюу Толгой нь Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз болон Рио Тинто группын хамтарсан компани юм. Энэхүү төслийг Рио Тинто 2010 оны 10 дугаар сараас удирдаж эхэлсэн бөгөөд тус компани нь Айвенхоу Майнзын хувьцааны 48,5%-ийг эзэмшдэг.

2011 онд дэлхийн эдийн засгийн тогтвортой байдлаас шалтгаалан 1 тонн зэсийн үнэ дунджаар 8885.1 ам.долларт хэлбэлзэж, төлөвлөсөн үнээс 2902.0 ам.доллараар нэмэгдсэн, 1 унци алтны дундаж үнэ 1573.18 ам.доллар болсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах боломж бүрдсэн байна.

2011 онд Төсвийн тогтворжуулалтын санд 241.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсний 81.5 хувийг зэсийн баяжмал экспортолж буй Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” ХХК төвлөрүүлжээ.

Лондонгийн металлын биржийн 2011 оны зэсийн үнийн графикийг харуулбал:



**Алт**

Монгол улс 2009 онд 9.8 тн, 2010 онд 6 тн, 2011 онд 5.7 тн орчим алт олборлосон байна. 2010 онд Монгол улс 6 тн алт олборлосон нь дэлхий нийтийн алт олборлолтын 0,2%-г эзэлж байна. Энэ үзүүлэлт 2008 онд 0,6%, 2009 онд 0,4% байсан.

2011 оны 01 сарын 01-ний байдлаар Монгол улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд давхардсан тоогоор 540 алтны шороон орд нийт 206,25 тн нөөцтөйгээр, 50 алтны үндсэн орд нийт 1278,2 тн нөөцтөйгээр бүртгэгдсэн байна.

Лондонгийн металлын биржийн 2011 оны алтны үнийн графикийг харуулбал:




Оюу толгой төслийн үйл ажиллагаа нь эхлэхээр жилд 544,000 тн зэс, 650,000 унци алт, 3 сая унци мөнгө олборлох ба энэ үед алтны олборлолтын хэмжээ нэмэгдэнэ гэж тооцож байна.

**Газрын тос**

Монгол Улсад газрын тосны олборлолтын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу явуулж байна.

БХГ-ний үндсэн зарчим нь Гэрээлэгч компаниуд газрын тосны үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө оруулалтаа өөрсдөө 100 % гаргаж, эрсдэлээ бүрэн хариуцдаг ба хэрэв тос олж, олборлосон тохиолдолд байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялаг ашигласны төлбөр (роялти) Монгол Улсын Засгийн газарт төлдөг. Үлдсэн тосны 40 хүртлэх хувийг Гэрээлэгч хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлаа нөхөх, түүнээс үлдсэн тосыг МУ-ын Засгийн газартай БХГ-нд тохирсон нөхцлөөр хоногийн олборлолтын хэмжээнээс хамааруулж хуваах авдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт 1990-1992 онд газрын тосны 22, 2001 онд газрын тосны 2, 2005 онд нүүрсний давхаргын метан хийн 1, 2007 онд газрын тосны 3, нийт хайгуулын 28 талбай ялгасан бөгөөд Төхөм X талбайг (хойд) ба (урд) гэж 2 хуваах, Цагаан-элс XIII ба Зүүнбаян XIV талбайн зарим хэсэгт “1997БХГ” байгуулсан тул хайгуулын талбай 30 болсон байна. Эдгээрээс газрын тосны хайгуулын 18 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу 14 гэрээлэгч компани газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулж байна.

**Уран**

Монголд ураны 30-62 мянган тоннын нөөц бий гэсэн тооцоо байдаг. Өнөөгийн байдлаар Монгол улс нь ураныг экспортлоогүй байна.

“Хан Ресорсиз” нь Монголын Дорнод аймагт ураны хайгуулын 2 лиценз эзэмшдэг. Гол ордыг 1988-1995 онуудад үе үе олборлож байсан. Гэвч 1995 оноос хойш эдгээр газруудад ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй байна.

Дорнод ураны орд газар нь 15 үндэсний “стратегийн орд газар” –ын жагсаалтанд багтсан байгаа бөгөөд түүний хэрэгжилтийг дор харуулласан.

**Стратегийн ач холбогдол**

Ашигт малтмалын тухай хуулийн (2006)-д зааснаар ордыг дараах нөхцөлд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үзнэ. Үүнд:
- Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний,
- Олон улсын хэрэгцээ шаардлага бүхий байгалийн баялагийг агуулсан ордыг,
- Жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг тооцно.

Хэрэв тухайн орд газар нь стратегийн ач холбогдолтой гэж тогтоогдон, хайгуулын ажил нь цэвэр хувийн санхүүжилтээр хийгдсэн, 50 хүртэл хувийг эзэмших эрхтэй бол эсвэл хайгуулын ажлыг улсаас хэсэгчилэн санхүүжүүлсэн бол лиценз эзэмшигчээс эзэмшилийн эрхийн 34%-г Засгийн газар авч болно.

### Стратегийн ач холбогдол бүхий ордууд




*Эх сурвалж: Монголын Ашигт малтмалын газар*

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг харуулбал:

| Ордын нэр | Ашигт малтмалын төрөл | Нөөц (1000 тонн) | Агууламж |
|---|---|---|---|
| Нарийн Сухайт | Чулуужсан нүүрс | 126,000 | |
| Багануур | Хүрэн нүүрс | 600,000 | |
| Эрдэнэт | Зэс, молибдени | 1,200,000 | 0.51% Cu and 0.012 Mo |
| Гурван Булаг | Уран | 0.0161 | |
| Оюу Толгой | Зэс, молибден | 26,300 (Cu) 0.019 (Ag) | |
| Таван Толгой | Чулуужсан нүүрс | 6,400,000 | |
| Шивээ Овоо | Хүрэн нүүрс | 646,000 | |
| Мардай | Уран | 0.0011 | |
| Дорнод | Уран | 0.0289 | |
| Төмөртэй | Төмөр | 229,000 | 51.15 Fe |
| Цагаан суварга | Зэс, молибдени | 10,600 | 0.42% Cu and 0.011 Mo |
| Бүрэнхаан | Фосфор | 192,000 | 21.1 фосфор |
| Төмөртэй Овоо | Цайр | 7,700 | 11.5% Zn |
| Асгат | Мөнгө | 6,400 | 351.08g/tonne Ag |
| Бороо | Алт | 0.025 | 1.6g/tonne Au |

*Эх сурвалж: Монголын Ашигт малтмалын газар*

# 4. ХАНДЛАГА

### 4.1. Тайлан нэгтгэлийн хамрах хүрээ

“Харт Нойрс” Лтд ба “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн (“Зөвлөхүүд”) консерциум нь Гэрээт ажлын даалгаварт тусгагдсан ажил үүргүүдийг хийж гүйцэтгэхээр сонгогдсон.

### 4.2. Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал

Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол, нэгтгэл нь бэлэн мөнгө болон бэлэн бусаар хийгдсэн төлбөрүүдийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу хийгдсэн.

Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ бид оролцогч талуудаас ирүүлсэн мэдээ мэдээлэл, тайлбарууд дээр тулгуурласан. Эдгээр мэдээллүүдийн үнэн зөв болон бүрэн гүйцэд байдалд аливаа нэгэн нотолгоо хийгдээгүй болно.

Аливаа материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь тайлангийн маягтанд бүртгэгдэлгүй орхигдсон тохиолдолд бидний ажил үүрэг тэднийг олж илрүүлэхэд хангалтгүй юм. Тиймээс аливаа орхигдсон материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь манай тайланд хамрагдахгүй болно.

Энэхүү тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн. Англи, Монгол хувиудын хооронд зөрүүтэй эсвэл зөрчилтэй зүйл гарсан тохиолдолд Англи хувийг баримтлана.

Энэхүү тайланд 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд хүлээн авсан мэдээллүүдийг нэгтгэн оруулсан болно. Энэ өдрөөс хойш хүлээн авсан мэдээллүүдийг энэхүү тайланд оруулаагүй болно.

### 4.3. Оролцогч талууд

**А. Компаниуд**

2011 оны нэгтгэл ажлын хувьд МОУИТБС-ын ажлын хэсэг нь нэгтгэлийн зорилгоор 301 компанийн бөглөсөн маягтыг аудитын консерциумд ирүүлсэн.

СЯ нь ОУИТБС 2011 оны нэгтгэл ажилд зориулж 518 оролцогч компаниудаас төлсөн Засгийн газрын орлогыг ОУИТБС-ын Ажлын хэсгийн батласан маягтуудын дагуу нэгтгэж гаргасан.

ОУИТБС-ын Дүрэм (Шаардлага 18(б)ii)-д заасны дагуу ОУИТБС-ын нэгтгэл ажилд олборлох үйлдвэрлэлийн салбарт хамрагдах бүх лицензтэй эсвэл бүртгэлтэй компаниудыг хамруулах бөгөөд ОУИТБС тайлагналын процесст оролцсон компаниудыг тэмдэглэх ёстой. Засгийн газар нь өөр өөр жагсаалтыг тухайн зорилгодоо нийцүүлэн бэлтгэдэг. Тухайлбал АМГ нь лиценз эзэмшиж буй компаниудын жагсаалтыг бэлтгэдэг бол Сангийн яам нь татварын зорилгоор тусдаа компаниудын жагсаалтыг бэлтгэдэг. Эдгээр жагсаалтуудыг өөр өөр зорилгоор бэлтгэсэн учир хооронд нь харьцуулах боломжгүй. СЯ-ны жагсаалтыг нэгтгэл тайланд хамрагдсан компаниудыг тодорхойлох зорилгоор ашигласан. Уг хоёр жагсаалтыг хоёуланг уг тайланд хамруулсан болно. МОУИТБС-ын ажлын алба нь эдгээр жагсаалтын хоорондын зөрүүг тодорхойлох, дараа дараагийн жилүүдэд уг нэгтгэлд оролцуулах шаардлагатай нэмэлт компаниудыг тодорхойлох арга хэмжээ авч байгаа.

**Б. Засгийн газрын оролцогч байгууллагууд**

Энэхүү тайланд хамрагдсан бүхий л байгууллагууд, аймгууд болон сумд, Засгийн газрын яам, агентлагууд болон бусад байгууллагуудыг “Засгийн газрын байгууллагууд” гэсэн тодотголтойгоор нэрлэсэн.

### 4.4. Материаллаг байдал

Үндэсний зөвлөл нь компаниудын тайлагнавал зохих материаллаг урсгалыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн МОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн 7 дугаар хуралдааны шийдвэрээр материаллаг төлбөрийн тайлагнах доод хэмжээ татвар, төлбөр, хураамж, бусад орлогын нэр төрөл бүр дээр 10,000 төгрөг (Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.8, 13.1-д аж ахуй нэгжийг бүртгэх, гэрчилгээ олгох төлбөр 10,000 төгрөг)-өөс дээш хэмжээний татвар төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, хандив дэмжлэгийг ОУИТБС-ын тайланд заавал хамруулахаар заасан. Иймд маш бага үнийн дүн бүхий их хэмжээний гүйлгээ энэхүү тайланд орсон.

2012 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн МОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр төлбөрийн материаллаг байдал буюу татвар төлбөрийн нийлбэр дүнгээр 40 сая төгрөгнөөс дээш материаллаг орлого бүхий аж ахуй нэгжийг олон улсын хөндлөнгийн аудитад хамруулахаар шийдвэр гарсаны дагуу 2011 оны нэгтгэл тайланд дээрхи тоон мэдээллээс үндэслэж 200 компанийг хамруулахаар сонгосон байна.

Нийт төлбөр болон орлогын хооронд үүсэх зөрүүг хянан үзэх материаллаг байдал дээр Ажлын Хэсгийн зүгээс ямар нэгэн заавар удирдамж гаргаж өгөөгүй.

### 4.5. Нэгтгэлийн хандлага ба арга аргачлал

Бидний энэхүү нэгтгэлийн ажилд хэрэглэсэн арга хандлагын талаар товч дурьдвал:

- Монголын ОҮИБСАА-тай нягт харилцан ярилцаж, Монголын ОҮИБС-ын заавар, журмуудтай танилцан, бүрэн гүйцэд ойлголт авч, холбогдох бичиг баримтуудыг үзэх, ялангуяа, тайлагнах маягтуудад зориулан боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, аргачлал хандлагууд зэрэгтэй танилцсан.
- МОҮИТБС-ын ажлын албанаас анхны тайлангуудыг олж авсан.
- Компани болон Засгийн газрын дүнг харьцуулж, анхны зөрүүг гаргасан.
- Хамрагдсан компаниудын маягтуудын мэдээллийг нэгтгэн хүснэгтлэх, эдгээр маягтуудад буруу зөрүү (шаардлагын дагуу мянгачлагдаагүй дүн) бөглөгдсөн зүйлсийг хасан (хувь хүний орлогын албан татвар гэх мэт) зохих тохируулгыг хийсэн. Тайлагнагдсан дүнг аль болох зөрүүгүй шийдвэрлэх зорилгын үүднээс нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн.
- Зөрүүнүүдийг шийдвэрлэхийн тулд компаниуд болон Засгийн газрын байгууллагуудтай хамтран ажилласан.
- Нэгтгэлийн явцад хийгдсэн бүхий л тохируулгуудыг тайлбарлаж, баримтжуулсан.
- Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү бүхний шалтгааныг тайлбарлаж, зохих зөвлөмжүүдийг өгсөн.

### 4.6. Зөрүүг тодорхойлох ажлын чиглэл, хоорондын уялдаа



### 4.7. Аргачлал

Уул уурхайн компаниудын өгөгдлүүд буюу тоон үзүүлэлтүүд нь Монголын ОУИТБСАА-аас гаргасан Маягт №1 дээр тайлагнагдсан.

Маягт №1 нь дараахи үндсэн 2 бүлэгтэй:

Хүрээ 1: Хүрээ 1 нь үндсэн 2 хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын дүнг биет нэгж болон мөнгөн дүнгээр илэрхийлсэн байна. Хоёр дахь хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын Засгийн газарт төлсөн татварууд, төлбөрүүд, төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг, хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд, Засгийн газрын лөрүүлсэн дүнбайгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгүүд болон байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн дүнгүүдийг илэрхийлдэг.

Хүрээ 2: Орлогууд ба орлогын урсгалууд (сайн дурын үндсэн дээр)

Уул уурхайн компани тус бүрийн Маягт №1, 2, 3 дээрх үзүүлэлт бүрээр тайлагнасан төрийн болон орон нутгийн төсөвт төлсөн татварууд болон төлбөрүүдийг компьютерийн “ЭКСЕЛ” программын хүснэгтүүдийг ашиглан Засгийн газрын байгууллагуудын бэлтгэсэн тайлантай (Монголын ОУИБС-ын ажлын албанаас гаргасан Маягт № 6) компани тус бүрээр тулгасан болно.

Ийнхүү тулгах явцад үүссэн бүхий л зөрүүнүүдийг тогтоосон шалгуурын дагуу ач холбогдолтой буюу ач холбогдолгүй гэж ангилан хүснэгтэлсэн.

Үүссэн ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд МОУИТБСАА-аас гаргасан Маягт №1,2,3 дээрх нэгтгэсэн дүнгүүдийг ЗГ-ын байгууллагууд болон ТЕГ-аас Монголын ОУИБСАА-аас гаргасан Маягт №6-ын дагуу ирүүлсэн мэдээллүүдээс шалгасан.

Ач холбогдолтой зөрүү бүрийн хувьд дараахи зүйлсийг тодорхойлно.

- Холбогдох ЗГ-ын байгууллагууд ба татварын албадаас (Маягт №6 дээрх дүнг харуулах үүднээс хүлээн авсан дүн буюу орлого хийгдсэн он, сар, өдөр, дүнгүүдийн дэлгэрэнгүй) дэлгэрэнгүйг авсан. Энэхүү дэлгэрэнгүйг уул уурхайн компаниудын төлсөн төлбөрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй тулган шалгахад ашигласнаар зөрүүнүүдийн боломжит тайлбаруудыг олж авсан.

- Уул уурхайн компаниудын бэлтгэсэн Маягт №1,2,3 нь тус компанийнхаа аудитороор хянагдсан эсэхийг мэдсэний үндсэн дээр тухайн компанийн хувьд үүссэн зөрүүнүүдийн тоо хэмжээ, төрөл (үзүүлэлт) болон бусад холбогдох хүчин зүйлсийн талаар бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмж шүүмжлэлийг ашиглан дараахи байдлаар шийдвэр гаргасан. Үүнд:

  - Монголын ОУИТБСА-аас гаргасан Маягт №1 дээрх өгөгдлүүдийн үнэлгээний байдлыг хянаж үзсэн ба зөрүү үүсгэж байгаа зүйлсийг тодорхойлсон.. Үүний тулд гүйцэтгэсэн горимууд нь үзүүлэлт бүрийн шинж чанараас хамаарч болно, түүнчлэн өөр бусад төрлийн эх сурвалж болох баримт бичгүүдийг ашиглах, дүн шинжилгээний хяналт, тоонуудыг батлан нотлохын тулд хийгдэх хараат бус тулган баталгаажуулалт зэргээс бүрдсэн. Хандлагын хувьд зөвхөн тодорхойлогдсон ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд ч бус зарим тохиолдолд компанийн тайлагнасан бүхий л болон хэсэг өгөгдлүүдийг ч хамран хийгдэх шаардлага гарч байсан.

  - Монголын ОУИТБСА-аас гаргасан Маягт №1,2,3-аар ирүүлсэн тоонуудын тооцооллыг харж шалгахын тулд холбогдох компаниудын зүгээс тэдний тайланд тусгагдсан дүнгийн дэлгэрэнгүй задаргааг (төлбөр хийгдсэн он, сар, өдөр болон дүнгүүд) авах хүсэлтийг гаргасан.

  - ЗГ-ын байгууллага болон компаниудаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэл нь зөрүүтэйн улмаас зөрүүг тохируулах боломжгүй болсон тухайгаа компани болон санхүүгийн урсгал тус бүрээр шалтгааныг тайлбарласан.

- Хэрвээ дээрх үйл явцын хүрээнд зөрүүнүүд нь шийдвэрлэгдэх боломжгүй гэж тооцогдвол холбогдох ЗГ-ын байгууллагууд болон тухайн компанийн хүмүүстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж, Ажлын хэсгээс дэмжлэг болон нэмэлт удирдамж аван тодорхой зөрүүг бууруулах арга хэмжээг авч ажилласан.

- Тулган шалгах явцад тодорхойлогдсон зөрүүнүүдийг ангилж, зөрүүний шалтгааныг (эсвэл шаардлагатай бол шийдэгдээгүй байдлаар нь үлдээх) тайлбарласан. Энэ нь Маягтуудыг бэлтгэх явцад голлон үүсдэг асуудлууд болон ОУИТБСАА-ны ажлын явцыг тодорхойлоход чиглэгдсэн зөвлөмжүүдийг өгсөн.

**4.8. Талуудын оролцооны схем**




Компаниуд
Татвар, хураамж
Үйлчилгээний хөлс, хураамж
Бусад
Төлбөр
Хандив
Торгууль
Ногдол ашиг
Зардал
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар
Агаарын бохирдлын төлбөр
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
Нэмэгдсэн өртгийн албан татвар
Газалийн албан татвар
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар
Автобензин, дизелийн түлшний албан татвар
Газалийн үйлчилгээний хураамж
Цэмийн тэсэрэмж бархи, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж
Цэмийн бодис зээмших, ашиглах, худалдах, импортлох,экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж
Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж
Цацрагийн үүсгүүрийг зээмших, ашиглах, худалдах, үгүсгэх, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булах, идэвхийг сулруулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж
Аж ахуйн нэгжээс төлөвлөгөөт ажиллагдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
Улсын тэсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний үйлчилгээний хураамж
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсаны урамшуулал
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсэнний урамшуулал
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлөөгүйлсэн сургалтын урамшуулал
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөгүйлсэн талбайн данчин
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөгүйлсэн захиргааны үйлчилгээний шимтгэл
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагаат дэмжсэн төлбөр
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого
Засгийн газрын бонд
Газрын төлбөр
Ус, рашаан ашигласны төлбөр
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан дэмжлэг
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн хураамж
Орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж
Нутгийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс
Төр, засгийн газрын байгууллагуудад өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив
Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг
Орон нутгийн төсөвт шилжүүлсэн торгууль
Улсын төсөвт шилжүүлсэн торгууль
Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж
Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс
Төрийн өмчийн ногдол ашиг
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн
ТЕГ
ТЕГ, ОНӨӨ
ТЕГ, ГЕГ
ГЕГ
ЦЕГ
УНДЕГ
АМГ
ХХҮГ
ГТГ
СЯ
ОНӨӨ
ТЗГБ
ТӨХ
БОАЖЯ

### 4.9 Хамрагдсан компаниуд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд орж байгаа нийт 200 компанийг эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл дараах байдалтай байна.




### 4.10 Компаниудын уул уурхайн байршил

Ашигт малтмалын нөөц аль орон нутагт илүү их зонхилж байгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд орсон 200 компаниудын мэдээлэлд үндэслэн гаргахад дараах байдалтай байна.



### 4.11 Компаниудаас 2011 онд улсын төсөвт төвлөрүүлсэн орлого

2011 оны татварын жилд Монгол улсын ЗГ-т төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамж, хандив тусламжийн хэмжээг нэгтгэлд хамрагдсан 200 компанийг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэглэн авч үзвэл дараах байдалтай байна.

(сая төгрөгөөр)




### 4.12 Хамгийн их орлого төвлөрүүлсэн компаниуд

Компаниудын 2011 онд улсад төлсөн татварын дүнг хувийн жингээр нь нь харуулбал:




Дээрх диаграмаас харахад “Эрдэнэт Үйлдвэр” ХХК нь хамгийн өндөр орлогыг төвлөрүүлсэн байна.

### 4.13 Компаниудаас Төр, засгийн багууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг

Компаниудаас 2011 онд Төрийн байгууллагад өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив дэмжлэгийн дүнг хувийн жингээр нь харуулбал:




### 4.14 ЗГ-аас хамааралтай үүссэн анхны зөрүүгийн шинжилгээ

Анхны нэгтгэлээр ЗГ-ын тайлагнасан дүн нь бага, компаниудын тайлагнасан дүн нь их байсны улмаас хасах **(-)** 121.5 тэрбум төгрөгийн зөрүү үүссэн. ЗГ-ын анхны нэгтгэлд 18 компанийн тайланг нэгтгэгдээгүйн улмаас 9.3 тэрбум төгрөгийн зөрүү үүсч, уг зөрүү нь 121.5 тэрбум төгрөгийн зөрүүнд мэдэгдэхүйц нөлөөлсөн. Дараах диаграмаар ЗГ-ын анхны нэгтгэлд нэгтгэгдээгүй 18 компанийн зөрүүг оруулахгүйгээр хамгийн их анхны зөрүү үүсгэсэн Засгийн газрын байгууллагуудыг харуулбал дараах байдалтай байна.



### 4.15 Компаниудаас хамааралтай үүссэн анхны зөрүүгийн шинжилгээ

Анхны нэгтгэлээр ЗГ-ын тайлагнасан дүн нь их, компаниудын тайлагнасан дүн нь бага байсны улмаас нэмэх **(+)** 599.1 тэрбум төгрөгийн зөрүү үүссэн. Нэгтгэлд хамрагдсан 200 компаниас 58 компани нь ОУИТБС-ын ажлын албанд 2011 оны тайлангаа гаргаж өгөөгүйн улмаас 433.5 тэрбум төгрөгийн зөрүү үүсч, уг зөрүү нь 599.1 тэрбум төгрөгийн зөрүүнд нөлөөлсөн. Дараах диаграмаар ОУИТБС-ын ажлын албанд 2011 оны тайлангаа гаргаж өгөөгүй 58 компанийн зөрүүг оруулахгүйгээр хамгийн их анхны зөрүү үүсгэсэн компаниудыг харуулбал дараах байдалтай байна.



# 5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ

## 5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал

| № | Êî ì ï àí èàñ óëñûí áî ëîí î ðî í óòãàëûí ðº ñº âòðº ëñº í òàòâàð, ðº ëáº ð | | Анхны тайлагнасан байдал | | Анхны нэгтгэлийн зөрүүнүүд |
|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын байгууллагууд | Компаниуд | |
| **1** | **Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | 1,757,683,505 | 1,260,097,840 | 497,585,666 |
| **1.1** | Татвар, хураамж | | 1,501,660,865 | 970,962,587 | 530,698,277 |
| **1.2** | Төлбөр | | 35,163,114 | 19,961,093 | 15,202,021 |
| **1.3** | Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж | | 64,030,002 | 51,916,544 | 12,113,459 |
| **1.4** | Хураамж үйлчилгээний хөлс | | 31,867,934 | 22,524,951 | 9,342,983 |
| **1.5** | Төрийн өмчийн ногдол ашиг | | 45,143,511 | 45,101,583 | 41,928 |
| **1.6** | Засгийн газрын орлого ба бусад орлого | | 78,351,725 | 23,761,048 | 54,590,678 |
| **1.7** | Торгууль | | 1,466,355 | 125,870,035 | (124,403,679) |
| **2** | **Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | 56,042,949 | 56,589,954 | (547,005) |
| **2.1** | Татвар | | 4,711,863 | 26,452,001 | (21,740,138) |
| **2.2** | Төлбөр | | 16,306,405 | 27,395,781 | (11,089,377) |
| **2.3** | Хураамж, үйлчилгээний хөлс | | 49,261 | 356,283 | (307,021) |
| **2.4** | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | | 34,917,093 | 2,115,535 | 32,801,558 |
| **2.5** | Торгууль | | 58,327 | 270,354 | (212,027) |
| **3** | **Бусад төлбөр ба зардал** | | 6,747,100 | 26,232,466 | (19,485,366) |
| 3.1 | Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа | | 999,194 | 1,679,307 | (680,113) |
| 3.2 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | | 5,747,906 | 24,553,159 | (18,805,254) |
| 3.2.1 | Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг | Мөнгөн хандив, дэмжлэг | 5,265,894 | 15,031,892 | (9,765,998) |
| 3.2.2 | | Мөнгөн бус хандив, дэмжлэг | 482,011 | 9,521,267 | (9,039,256) |
| **Нийт дүн** | | | **1,820,473,554** | **1,342,920,260** | **477,553,294** |

**Анхны нэгтгэлийн зөрүү дараахь шалтгааны улмаас үүссэн байна. Үүнд:**

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүй 58 компанийн 433.5 тэрбум төгрөгийн зөрүү нь анхны зөрүү үүсэхэд хамгийн их нөлөөлсөн.
- ЗГ нь анхны тайландаа “Оюу толгой” ХХК-иас хүлээн авсан хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хүлээн авсан урьдчилгаа төлбөр 100 сая ам.доллар буюу 125.4 тэрбум төгрөгийг тайландаа тусгаагүйгээс зөрүү үүссэн.
- Тайлангийн нэгтгэлд хамрагдаагүй 18 компанийн 9.3 тэрбум төгрөгийн зөрүү нь анхны зөрүү үүсэхэд нөлөөлсөн.
- Компаниуд төлөлтөөрөө биш ногдуулалтаараа (мөнгөн биш аккруэл сууриар) тайланд тусгасан.
- ОҮИТБС-ын тайлангийн маягтад тусгагдах санхүүгийн урсгал биш Хувь хүний орлогын албан татварын дүнг хоёр тал тусгаж иргүүлсэнээс ЗГ талд 4.2 сая төгрөг, компани талд 22,300 сая төгрөг тусгагдаж ирсэнээс 22,296 сая төгрөгийн тайлагнагдахгүй санхүүгийн урсгалыг ОҮИТБС-ын тайланд тусгасан.
- Засгийн газар анхны тайландаа орон нутгийн төсвийн орлогыг тусгаагүй.
- Зарим татвар, төлбөр, хураамжийн дүнг илүү болон дутуу тусгасан.
- Гаальтай холбоотой бүх төрлийн татвар, хураамж, үйлчилгээний дүнг компаниуд салгаж тусгалгүй бөөн дүнгээр тайланд тусгасан.
- Ихэнх компаниуд оны эцэст татварын үлдэгдлээ төсөвт тушаадаг ба шилжүүлэг нь он дамжиж төсвийн дансанд ордог учраас ЗГ-ын тайланд тухайн оны нэгтгэлд тусгадаггүй.

## 5.2 Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал

Бид Монголын ОҮИТБС-ын зургаадугаар буюу 2011 оны нэгтгэл тайлангийн ажлыг 2012 оны 8 дугаар сарын 6-наас эхлэн гүйцэтгэж эхэлсэн ба 2012 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ажлын хэсгийн хуралдаанд нэгтгэлийн ажлын үр дүнг анхлан танилцуулсан. Энэ хугацаанд анхны зөрүү болох 832.0 тэрбум төгрөгийг 66.4 тэрбум төгрөг хүртэл бууруулан ажилласан ба Ажлын хэсгийн анхны хуралдаанаар цаашид шийдэгдээгүй зөрүүг улам бууруулах, компаниудын орон нутагт төлсөн татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийг аймаг бүрээр гаргаж тайланд хавсралтаар оруулахыг үүрэг болгосон.

Ажлын хэсгийн анхны хуралдаанаас хойш сар гаруй хугацаанд ажилласаны үр дүнд 11-р сарын 09-ний өдөр Ажлын хэсгийн хуралдаанд 2 дахь удаагаа танилцуулсан. Энэ хугацаанд шийдэгдээгүй зөрүү 66.4 тэрбум

төгрөгийг 712.2 сая төгрөг хүртэл бууруулан ажилласан. Ажлын хэсгийн 2 дахь хуралдаанаас тайланг эцсийн байдлаар хэвлэн Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах шийдвэр гаргасан.

### 5.3 Бүх тохируулга хийгдсэний дараах санхүүгийн нийт урсгал

Ажлын хэсгийн 2 дахь хуралдаанаас хойш тайланг эцсийн байдлаар бэлтгэх хүртэл оролцогч талуудаас хариу ирүүлсээр байсан ба материаллаг дүн бүхий зөрүүнүүдийн тохируулгуудыг нэмж хийснээр нийт шийдэгдээгүй зөрүү 622.4 сая төгрөг болсныг эцсийн байдлаар танилцуулж байна.

**(мянган төгрөгөөр)**

| № | Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр | | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Тохируулгын дараа | | Шийдэгдэ эгүй зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газар | Компани | Засгийн газар | Компани | |
| **1** | **Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | **497,585,666** | **298,422,773** | **795,858,736** | **2,056,106,278** | **2,055,956,576** | **149,702** |
| **1.1** | Татвар, хураамж | | 530,698,277 | (168,718,691) | 361,934,693 | 1,332,942,174 | 1,332,897,281 | 44,893 |
| **1.2** | Төлбөр | | 15,202,021 | 1,808,597 | 17,134,798 | 36,971,710 | 37,095,891 | (124,180) |
| **1.3** | Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж | | 12,113,459 | 1,981,964 | 13,925,799 | 66,011,967 | 65,842,343 | 169,623 |
| **1.4** | Хураамж үйлчилгээний хөлс | | 9,342,983 | 1,263,580 | 10,560,809 | 33,131,513 | 33,085,759 | 45,754 |
| **1.5** | Төрийн өмчийн ногдол ашиг | | 41,928 | 20 | 41,948 | 45,143,531 | 45,143,531 | - |
| **1.6** | Засгийн газрын орлого ба бусад орлого | | 54,590,678 | 461,469,015 | 516,059,693 | 539,820,740 | 539,820,740 | - |
| **1.7** | Торгууль | | (124,403,679) | 618,288 | (123,799,004) | 2,084,643 | 2,071,031 | 13,612 |
| **2** | **Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | **(547,005)** | **10,521,114** | **10,056,343** | **66,564,064** | **66,646,297** | **(82,234)** |
| **2.1** | Татвар | | (21,740,138) | 137,745 | (21,588,383) | 4,849,608 | 4,863,619 | (14,010) |
| **2.2** | Төлбөр | | (11,089,377) | 9,865,698 | (1,177,065) | 26,172,103 | 26,218,716 | (46,613) |
| **2.3** | Хураамж, үйлчилгээний хөлс | | (307,021) | 398,299 | 106,228 | 447,561 | 462,511 | (14,950) |
| **2.4** | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | | 32,801,558 | 2,116 | 32,803,674 | 34,919,209 | 34,919,209 | - |
| **2.5** | Торгууль | | (212,027) | 117,256 | (88,111) | 175,583 | 182,243 | (6,660) |
| **3** | **Бусад төлбөр ба зардал** | | **(19,485,366)** | **21,316,625** | **1,973,378** | **28,063,725** | **28,205,844** | **(142,118)** |
| **3.1** | Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа | | (680,113) | 257,210 | (418,603) | 1,256,404 | 1,260,704 | (4,300) |
| **3.2** | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | | **(18,805,254)** | **21,059,415** | **2,391,980** | **26,807,321** | **26,945,140** | **(137,818)** |
| **3.2.1** | Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг | Мөнгөн хандив, дэмжлэг | (9,765,998) | 15,186,703 | 5,516,806 | 20,452,597 | 20,548,698 | (96,101) |
| **3.2.2** | | Мөнгөн бус хандив, дэмжлэг | (9,039,256) | 5,872,712 | (3,124,826) | 6,354,724 | 6,396,442 | (41,718) |
| **Нийт дүн** | | | **477,553,294** | **330,260,512** | **807,888,457** | **2,150,734,067** | **2,150,808,717** | **(74,650)** |

Доорх хүснэгтэнд нийт санхүүгийн урсгалуудаас үүссэн цэвэр болон нийт зөрүүг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

**(мян.төг)**

| | Анхны нэгтгэлийн зөрүү | Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан байдал | | Шийдээгүй зөрүү (эцсийн байдлаар) |
|---|---|---|---|---|
| | | 2012.10.12 | 2012.11.09 | |
| ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их | 654,790,903 | 30,988,704 | 186,250 | 273,883[1] |
| Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их | (177,237,609 | (35,372,316) | (525,935) | (348,533)[2] |
| **Цэвэр зөрүү** | **477,553,294** | **(4,383,612)** | **(339,685)** | **(74,650)**[3] |
| **Нийт зөрүү** | **832,028,512** | **66,361,020** | **712,185** | **622,415**[4] |

[1]Анхны нэгтгэл болон нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас холбогдох мэдээллийг авч тохируулгыг хийсэн боловч ЗГ нь хүлээн авсан харин компани нь төлсөн дүнгээ тодорхойлж чадаагүйн улмаас шийдвэрлэгдээгүй үлдэж буй зөрүү юм.

[2]Анхны нэгтгэл болон нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас холбогдох мэдээллийг авч тохируулгыг хийсэн боловч компани нь төлсөн харин ЗГ нь хүлээн авсан эсэхээ нотолж чадахгүйн улмаас шийдвэрлэгдээгүй үлдэж буй зөрүү юм.

[3]ЗГ-ын хүлээн авсан дүн болон компаниудын төлсөн дүнгийн ялгавар буюу цэвэр зөрүү

[4]ЗГ-ын талд үүссэн зөрүүнүүд болон компанийн талд үүссэн зөрүүнүүдийн нийлбэр буюу нийт зөрүү

# 6. ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД

### 6.1 Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн шинжилгээ

### 6.1.1 Компаниудтай холбоотой шийдэгдээгүй үлдсэн зөрүү

(мян.төг)

| | Êî ì ï àí èàñ óëñû í áî ëî í î ðî í óòãûí ðº ñº âò ðº ëñº í òàòâàð, ðº ëá° ð | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү | Нийт зөрүүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газар | Компани | | |
| **1** | Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг | **482,383,645** | **296,614,176** | **778,723,938** | **273,883** | **100** |
| **1.1** | Татвар, төлбөр | 530,698,277 | (168,718,691) | 361,934,693 | 44,893 | 16 |
| **1.3** | Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж | 12,113,459 | 1,981,964 | 13,925,799 | 169,623 | 62 |
| **1.4** | Хураамж үйлчилгээний хөлс | 9,342,983 | 1,263,580 | 10,560,809 | 45,754 | 17 |
| **1.5** | Төрийн өмчийн ногдол ашиг | 41,928 | 20 | 41,948 | - | - |
| **1.6** | Засгийн газрын орлого ба бусад орлого | 54,590,678 | 461,469,015 | 516,059,693 | - | - |
| **1.7** | Торгууль | (124,403,679) | 618,288 | (123,799,004) | 13,612 | 5 |
| **Нийт дүн** | | **482,383,645** | **296,614,176** | **778,723,938** | **273,883** | **100** |

Хүснэгтээс харахад шийдэгдээгүй үлдсэн зөрүүний хамгийн их буюу 62 хувийг компаниудын төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хураамж, 16 хувийг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр эзэлж байна. Компаниуд нь эдгээр зөрүүнүүдийг төлсөн эсэхээ нотолж чадаагүй тул шийдэгдээгүй үлдсэн.

### 6.1.2 ЗГ-тай холбоотой шийдэгдээгүй үлдсэн зөрүү

(мян.төг)

| | Êî ì ï àí èàñ óëñû í áî ëî í î ðî í óòãûí ðº ñº âò ðº ëñº í òàòâàð, ðº ëá° ð | | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү | Нийт зөрүүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газар | Компани | | |
| **1** | **Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | **15,202,021** | **1,808,597** | **17,134,798** | **(124,180)** | **36** |
| **1.2** | Төлбөр | | 15,202,021 | 1,808,597 | 17,134,798 | (124,180) | 36 |
| **2** | **Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг** | | **(547,005)** | **10,521,114** | **10,056,343** | **(82,234)** | **24** |
| **2.1** | Татвар | | (21,740,138) | 137,745 | (21,588,383) | (14,010) | 4 |
| **2.2** | Төлбөр | | (11,089,377) | 9,865,698 | (1,177,065) | (46,613) | 13 |
| **2.3** | Хураамж, үйлчилгээний хөлс | | (307,021) | 398,299 | 106,228 | (14,950) | 4 |
| **2.4** | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | | 32,801,558 | 2,116 | 32,803,674 | - | - |
| **2.5** | Торгууль | | (212,027) | 117,256 | (88,111) | (6,660) | 2 |
| **3** | **Бусад төлбөр ба зардал** | | **(19,485,366)** | **21,316,625** | **1,973,378** | **(142,118)** | **41** |
| 3.1 | Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа | | (680,113) | 257,210 | (418,603) | (4,300) | 1 |
| 3.2 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | | **(18,805,254)** | **21,059,415** | **2,391,980** | **(137,818)** | **40** |
| 3.2.1 | Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг | Мөнгөн хандив, дэмжлэг | (9,765,998) | 15,186,703 | 5,516,806 | (96,101) | 28 |
| 3.2.2 | | Мөнгөн бус хандив, дэмжлэг | (9,039,256) | 5,872,712 | (3,124,826) | (41,718) | 12 |
| **Нийт дүн** | | | **(4,830,351)** | **33,646,336** | **29,164,518** | **(348,533)** | **100** |

Дээрх хүснэгтээс харахад нийт зөрүүний 36 хувийг ХХҮГ-ийн хүлээн авсан гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр, 40 хувийг Төр, засгийн байгууллагууд болон орон нутгийн засаг захиргааны

байгууллагуудын хүлээн авсан хандив, дэмжлэг эзэлж байгаа ба ЗГ хүлээн авсан эдгээр төлбөрүүдийг нотолж чадаагүй тул шийдэгдээгүй үлдсэн.

Шийдэгдээгүй үддсэн 74.6 сая төгрөгийн цэвэр зөрүүг компани тус бүрээр задлан харуулбал дараах бүтэцтэй байна.

(мян.төг)

| Компаниуд | Шийдэгдээгүй зөрүүнүүд |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Баян эрч ХХК | (115,860) |
| Бороо гоулд ХХК | (37,362) |
| Шинь Шинь ХХК | (34,394) |
| Эм Си Ти Ти ХХК | (26,454) |
| Гоби коул энд энержи ХХК | (18,563) |
| Хотгор шанага ХХК | (12,102) |
| Чинхуа МАК нарийн сухайт ХХК | (11,631) |
| Лутчулуу ХХК | (9,605) |
| Болд төмөр ерөө гол ХХК | (9,243) |
| Сод газар ХХК | (9,041) |
| Эрдэнэ жас ХХК | (8,256) |
| Бусад | (90,113) |
| **Бүгд** | **(382,624)** |
| ***ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Гацуурт ХХК | 145,852 |
| Гүнбилэг трейд ХХК | 57,518 |
| Гүнбилэг гоулд ХХК | 21,880 |
| Эф Эм Ай ХХК | 11,850 |
| Монгол ураниум ресурс ХХК | 11,848 |
| Эрэл ХХК | 11,221 |
| Монголчехметалл ХХК | 9,243 |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | 8,366 |
| Нордвинд ХХК | 5,652 |
| Бусад | 24,546 |
| **Бүгд** | **307,974** |
| **Цэвэр зөрүү** | **(74,650)** |

### 6.2 Татвар, төлбөр, бусад

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 78,050,048 | 2,753,617 | 80,802,900 | 765 |
| Гаалийн албан татвар | 112,099,345 | (60,946,219) | 51,153,126 | - |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 222,394,475 | (125,866,209) | 96,528,266 | - |
| Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 10,909,524 | (1,501,448) | 9,405,301 | 2,775 |
| Автобензин, дизелийн түлшний албан татвар | 2,133,199 | (653) | 2,132,546 | - |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | 123,105,212 | 12,776,722 | 135,881,934 | - |
| Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | (19,185,508) | 4,066,187 | (15,160,675) | 41,354 |
| Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 1,191,983 | (687) | 1,191,296 | - |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 245,079 | 130,903 | 383,926 | (7,945) |
| Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 267,499 | 499 | 274,064 | (6,065) |
| Бусад | (22,252,716) | 6,343 | (22,246,373) | - |
| **Дүн** | **508,958,139** | **(168,580,945)** | **340,346,310** | **30,883** |

### 6.2.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Гүнбилэг гоулд ХХК | 15 |
| Гүнбилэг трейд ХХК | 750 |
| **Дүн** | **765** |
| **Цэвэр зөрүү** | **765** |

**Шийдэгдээгүй үлдсэн зөрүүний шалтгааныг тодруулахад дараахь байдалтай байна. Үүнд:**

ААНОАТ-ын 765.0 мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Гүнбилэг гоулд”, “Гүнбилэг трейд” компаниуд дээр үүссэн.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ-ын анхны тайланд тусгагдаж ирсэн боловч компанийн тайланд тусгагдаагүй.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулж авахаар албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авахад уг татварын дүнг тодорхойлж өгч чадаагүй.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Компаниудын нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эсэх нь тодорхойгүй, компанийн нягтлан бодогч уг татварыг төлсөн анхан шатны баримтаа хувилж өгөөгүй учраас зөрүүг шийдвэрлэх боломжгүй болсон.

### 6.2.2 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Очир ундраа ХХК | 2,775 |
| **Дүн** | **2,775** |
| **Цэвэр зөрүү** | **2,775** |

***Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын*** *2,775* мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Очир ундраа” ХХК дээр үүссэн.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ-ын анхны тайланд тусгагдсан боловч компанийн тайланд тусгагдаагүй.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулж авахаар албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авахад уг татварын дүнг тодорхойлж өгч чадаагүй. Дахин компанид ГЕГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэхэд уг татварт төлсөн дүнг тодорхойлж өгч чадаагүй.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Компани нь “манай компаниас төлсөн татварын дүн биш” гэсэн хариу өгсөн. Дахин ГЕГ-т хандахад шалтгаан тодорхойлогдоогүй.

### 6.2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| “Гүнбилэг трейд” ХХК | 28,761 |
| “Монгол ураниум ресурс” ХХК | 11,848 |
| “Шарын гол” ХК | 1,041 |
| **Дүн** | **41,650** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| “Гүнбилэг гоулд” ХХК | (296) |
| **Дүн** | **(296)** |
| **Цэвэр зөрүү** | **41,354** |

***Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 41,354*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Гүнбилэг трейд”, “Монгол ураниум ресурс” , “Шарын гол”, “Гүнбилэг гоул” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** “Гүнбилэг трейд”, “Монгол ураниум ресурс” , “Шарын гол” зэрэг компаниуд нь ажлын албанд гаргаж өгсөн тайландаа дутуу тусгаж өгсөн, “Гүнбилэг гоулд” ХХК нь илүү тусгасан байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулж авахаар албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авахад уг төлбөрийг тодорхойлж өгч чадаагүй. Дахин компаниуд руу АМГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлсэн ч өөрийн компаниас төлсөн төлөлтийн дүнг нягтлан бодох бүртгэлээсээ хайгаад олоогүй.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Компаниуд нь тухайн жилийн санхүүгийн тайланд хамрагдсан анхан шатны баримтаасаа хайгаад олохгүй, мөн өмнөх удирдлага болон нягтлан бодогчийн хийсэн гүйлгээ учраас одоогийн нягтлан бодогч мэдэхгүй байгаа зэрэг шалтгааны улмаас компани талд үүссэн зөрүү шийдвэрлэгдэхгүй байна. Уг төлбөрийг төлсөн тухайн албан тушаалтан анхан шатны баримтаа санхүүдээ өгч нягтлан бодох бүртгэлд тусгуулдаггүйгээс баримт нь олдохгүй зөрүү үүсгэх нэг шалтгаан болж байна.

### 6.2.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| “Монголболгаргео” ХХК | (7,945) |
| **Дүн** | **(7,945)** |
| **Цэвэр зөрүү** | **(7,945)** |

***Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын*** **(7,945)** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Монголболгаргео” ХХК дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн дүнг тусгаагүй байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Нийслэлийн татварын газарт албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авсан боловч тус компанийн харъяалагддаг дүүргийн татварын хэлтсээс тодруулах тухай хариу өгсөн.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар***
Баянгол дүүргийн татварын хэлтэст хандсан боловч уг төлөлт байхгүй байна гэсэн хариу өгсөн. Дахин компанид хандахад кассын тайланд уг татварыг төлсөн гэсэн гүйлгээ байгаа боловч анхан шатны баримт нь олдохгүй байна гэсэн хариу өгсөн. Уг зөрүү нь хоёр талын мэдээллээр нотлогдохгүй байгаа учраас шийдвэрлэж чадаагүй.

### 6.2.5 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| “Тэн хун” ХХК | 285 |
| “Эс Би Эф” ХХК | 114 |
| “Очир-Ундраа” ХХК | 26 |
| **Дүн** | **425** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| “Дадизи юиан” ХХК | (5,112) |
| “Баян эрч” ХХК | (1,216) |
| “Оюут улаан” ХХК | (147) |
| “Гүнбилэг трейд” ХХК | (15) |
| **Дүн** | **(6,490)** |
| **Цэвэр зөрүү** | **(6,065)** |

**Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын (6,065)** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Дадизи юиан”, “Баян эрч”, “Оюут улаан”, “Гүнбилэг трейд”, “Очир-Ундраа”, “Тэн хун”, “Эс Би Эф” зэрг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа тусгаагүй, мөн зарим компаниуд нь анхны тайландаа илүү, дутуу дүнгээр тусгасан зэрэг шалтгааны улмаас анхны зөрүү үүссэн байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн холбогдох харъяа сум, дүүргийн татварын хэлтэст хандаж, хариу мэдээлэл авсан. Мөн компаниудаас анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** “Дадизи юиан” ХХК-иас төлсөн 5,112 мянган төгрөгийн татвар нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн дансанд ороогүй гэсэн хариуг тус дүүргийн татварын хэлтсээс өгсөн. Компаниас ирүүлсэн анхан шатны баримтаа явуулахад тус дүүргийн татварын хэлтэс нь АТӨЯХАТ-ын данс мөн байна гэсэн. Баянгол дүүргийн татварын хэлтсийн тухайн байцаагч дахин сайн нягталж үзсэн боловч тус компанийн татварын төлөлт тодорхойлогдоогүй учраас зөрүү шийдвэрлэгдээгүй.

Уг татварын хувьд компани дээрээ бүртгэлгүй тээврийн хэрэгслийн татварыг компанийнхаа нэрээр төлдөгөөс, мөн компанийн бүртгэлтэй тээврийн хэрэгслийн татварыг эзэмшигч өөрийнхөө нэрээр төлдөгөөс шалтгаалаад хоёр талд илүү, дутуу төлөлт гарч, зөрүү шийдвэрлэгдэхгүйд хүрч байна.

### 6.3 Төлбөр

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 328,583 | (7,433) | 299,141 | 22,009 |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 3,592,072 | 1,052,893 | 4,790,175 | (145,211) |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсаны урамшуулал | (287,535) | 273,650 | (13,884) | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсэний урамшуулал | - | - | - | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төвлөрүүлсэн сургалтын урамшуулал | 284,175 | 183,896 | 468,070 | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн талбайн дэнчин | 491,487 | (125,856) | 365,631 | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн захиргааны үйлчилгээний шимтгэл | (249,070) | 249,070 | - | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр | 157,433 | 76,146 | 233,578 | - |
| Агаарын бохирдлын төлбөр | 10,884,877 | 106,231 | 10,992,086 | (978) |
| Газрын төлбөр | (2,002,665) | 2,457,980 | 497,785 | (42,469) |
| Ус, рашаан ашигласны төлбөр | 25,066 | 290,819 | 320,029 | (4,144) |
| Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр | (48,232) | (413) | (48,645) | - |
| Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | (45,577) | 167,372 | 121,795 | - |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | (8,568,398) | 6,514,716 | (2,053,682) | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан дэмжлэг | (446,871) | 435,051 | (11,820) | - |
| Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн хураамж | (2,700) | 173 | (2,527) | - |
| **Дүн** | **4,112,644** | **11,674,295** | **15,957,732** | **(170,793)** |

### 6.3.1 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| “Гүнбилэг гоулд” ХХК | 22,009 |
| **Дүн** | **22,009** |
| **Цэвэр зөрүү** | **22,009** |

***Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн 22,009*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь "Гүнбилэг голд" ХХК дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа уг төлбөрийг тусгаж, харин компани нь ажлын албанд гаргаж өгсөн тайландаа ч, мөн нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ ч тусгаж өгөөгүй байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан боловч уг төлбөрийн дүнг тодорхойлж өгч чадаагүй. АМГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу төлөлтийг тулгаад компаниас төлсөн төлөлтийг тодруулаад өгнө үү гэж олон дахин хандсан боловч, хариу өгөхгүй, утсаа авахгүй, компанид очихоор эзгүй байсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Компани хариу мэдээлэл өгөхгүй байгаа учраас зөрүү шийдвэрлэгдээгүй.

### 6.3.2 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Алтайн хүдэр ХХК | 7,146 |
| Гацуурт ХХК | 3,586 |
| **Дүн** | **10,732** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Баян эрч ХХК | (115,278) |
| Эм Си Ти Ти ХХК | (26,525) |
| Хотгор шанага ХХК | (11,332) |
| Бэрх ресорсиз ХХК | (2,808) |
| **Дүн** | **(155,943)** |
| **Цэвэр зөрүү** | **(145,211)** |

***Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр (145,211)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь "Алтайн хүдэр", "Гацуурт", "Баян эрч", "Эм Си Ти Ти", "Хотгор шанага, "Бэрх ресорсиз" зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа тусгаагүй, дутуу тусгасан, мөн компаниуд нь илүү, дутуу тусгасан зэрэг шалтгааны улмаас зөрүү үүссэн.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, уг мэдээлэлд үндэслэн ХХҮГ-т 8 дугаар сарын 20, 9 дүгээр сарын 26-нд тус тус албан бичиг хүргүүлж, хариу мэдээлэл авч ажилласан. ХХҮГ нь бүтцийн өөрчлөлтөд орсонтой холбогдуулан нэгтгэл тайлангийн ажлыг цалгардуулж, мэдээлэл гаргаж өгөхдөө хойрго хандаж, эдгээр компаниудын мэдээллийг бүрэн хэмжээнд тодорхойлж чадаагүй.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** ХХҮГ бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалаад уг мэдээллийг гаргаж өгөх албан тушаалтан тодорхойгүй байсан нь нилээд их цаг хугацаа алдсан. ХХҮГ болон компаниуд руу олон удаа хандаж, мэдээлэл авсан хэдий ч өмнөх дүнгээ дахин ирүүлж байгаа нь зөрүүг шийдвэрлэхэд хангалттай мэдээлэл болж чадахгүй байна. ХХҮГ нь өөрийн программаас шүүгээд ч олохгүй байна, баримтаас үзэж өгье гэсэн хариу өгсөөр байтал тайлангийн нэгтгэлийн хугацаа дууссан. Тус газарт ажлын багийн гишүүдээс очиж ажиллаж тодорхой мэдээлэл авсан ч зөрүүг шийдвэрлэж чадсангүй.

### 6.3.3 Агаарын бохирдлын төлбөр

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Олон овоот голд ХХК | (452) |
| Эрэл ХХК | (355) |
| Шар нарст ХХК | (171) |
| **Дүн** | **(978)** |
| **Цэвэр зөрүү** | **(978)** |

***Агаарын бохирдлын төлбөрийн (978)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Олон овоот гоулд”, “Эрэл”, “Шар нарст” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа тусгаагүй, дутуу тусгасан, мөн компаниуд нь илүү тусгасан зэрэг шалтгааны улмаас зөрүү үүссэн.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, уг мэдээлэлд үндэслэн холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтэст хандсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтсээс тухайн төлбөр нь манай дансанд ороогүй байна гэсэн хариу өгсөн. Тухайлбал: Өмнөговь аймаг, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсээс манай дансанд ороогүй гэсэн хариуг өгсөн.

### 6.3.4 Газрын төлбөр

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Баян эрч ХХК | 260 |
| **Дүн** | **260** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Гацуурт ХХК | (33,897) |
| Эрдэс холдинг ХХК | (3,795) |
| Коммод ХХК | (2,451) |
| Алтай хангай бүрд ХХК | (1,893) |
| Алтайн хүдэр ХХК | (602) |
| Сод газар ХХК | (91) |
| **Дүн** | **(42,729)** |
| **Цэвэр зөрүү** | **(42,469)** |

***Газрын төлбөрийн (42,469)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Гацуурт”, “Эрдэс холдинг”, “Коммод”, “Алтай хангай бүрд”, “Алтайн хүдэр”, “Сод газар”, “Баян эрч” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийн дүнг тусгаагүй байсан.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, уг мэдээлэлд үндэслэн холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтэст хандсан. Компаниудаас анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтсээс тухайн төлбөр нь манай дансанд ороогүй байна гэсэн хариу өгсөн. Тухайлбал: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Хэнтий аймаг, Сэлэнгэ аймгийн татварын хэлтсээс манай дансанд ороогүй гэсэн хариуг өгсөн. Компани төлсөн тухайгаа дэлгэрэнгүй мэдээлэл болон анхан шатны баримтаараа нотлоод байдаг, орон нутгийн байгууллагаас аваагүй гэсэн хариу ирүүлээд байгаа учраас зөрүү шийдвэрлэгдэхгүйд хүрсэн.

### 6.3.5 Ус, рашаан ашигласны төлбөр

(мян.төг)

| Компаний нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Эрдэс холдинг ХХК | (2,737) |
| Геомин ХХК | (600) |
| Биг Могул Коул энд Энержи ХХК | (506) |
| Оюут улаан ХХК | (300) |
| **Дүн** | **(4,144)** |
| **Цэвэр зөрүү** | **(4,144)** |

***Ус, рашаан ашигласны төлбөр (4,144)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь "Эрдэс холдинг", "Геомин", "Биг Могул Коул энд Энержи", "Оюут улаан" зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийн дүнг тусгаагүй, мөн дутуу тусгасан байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, уг мэдээлэлд үндэслэн холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтэст хандсан. Компаниудаас анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Холбогдох харъяа аймаг, сум, дүүргийн татварын хэлтсээс тухайн төлбөр нь манай дансанд ороогүй байна гэсэн хариу өгсөн. Тухайлбал: Дундговь аймгийн Баянжаргалан сумаас дутуу, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Баян-Өлгий аймгийн татварын хэлтсээс манай дансанд ороогүй гэсэн хариуг өгсөн. Компани төлсөн тухайгаа дэлгэрэнгүй мэдээлэл болон анхан шатны баримтаараа нотлоод байдаг, орон нутгийн байгууллагаас аваагүй гэсэн хариу ирүүлээд байгаа учраас зөрүү шийдвэрлэгдэхгүйд хүрсэн.

### 6.3.6 Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл

(мян.төг)

| Бүлэг | | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|---|
| | | | ЗГ | Компани | |
| 1.1.13 | Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 12,113,459 | 1,981,964 | 13,925,799 | 169,623 |

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Гацуурт ХХК | 168,044 |
| Монгол метал майнинг ХХК | 1,580 |
| **Дүн** | **169,623** |
| **Цэвэр зөрүү** | **(169,623)** |

***Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж 169,623*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь "Гацуурт", "Монгол металл майнинг" зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** Компаниуд нь анхны тайландаа уг шимтгэлийг төлсөн дүнгээ дутуу тусгаж ирүүлсэн.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан боловч энэ мэдээлэлд нэмж тусгаж ирүүлээгүй. Компанид дахин хандаж НДЕГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлтэй тулган шалгахыг хүссэн боловч төлөлтийг тодорхойлж чадаагүй.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** "Монгол металл майнинг" ХХК нь анхны тайланд тусгасан дүнгээ ирүүлээд, манай төлөлт энэ л дүн, НДЕГ-аас гаргаж өгсөн дүнг мэдэхгүй гэсэн тайлбар өгсөн. "Гацуурт" ХХК нь НДЕГ-ын мэдээлэлтэй өөрийн төлөлтийг тулгаад манай төлөлт биш гээд сүүлдээ тайлбар өгөхгүй, утсаа ч авахгүй болсон.

### 6.4 Хураамж, үйлчилгээний хөлс

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Гаалийн үйлчилгээний хураамж | 11,612,415 | (222,738) | 11,389,677 | - |
| Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж | (492,874) | 232,327 | (247,831) | (12,715) |
| Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс | (1,776,559) | 1,253,991 | (581,037) | 58,469 |
| Орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж | (324,924) | 338,322 | 16,179 | (2,780) |
| Нутгийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс | 17,903 | 59,977 | 90,050 | (12,170) |
| **Дүн** | **9,035,962** | **1,661,879** | **10,667,037** | **30,804** |

***Хураамж, үйлчилгээний хөлсний (30,804)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь доор дурьдсан компаниуд дээр үүссэн байна.

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Гүнбилэг трейд ХХК | 20,862 |
| Эрэл ХХК | 15,430 |
| Эф Эм Ай ХХК | 12,550 |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | 8,366 |
| Гацуурт ХХК | 8,119 |
| Нордвинд ХХК | 5,652 |
| Монгол-Алт ХХК | 4,710 |
| Эм Ар Си Эм Жи Эл ХХК | 4,650 |
| Хангад эксплорэшн ХХК | 4,204 |
| Шинэ Илион Нэн Юань ХХК | 3,838 |
| Шинь Шинь ХХК | 3,661 |
| Шарын гол ХК | 3,550 |
| Эрдэнэ жас ХХК | 2,744 |
| Эс Би Эф ХХК | 1,992 |
| Энержи ресурс ХХК | 1,468 |
| Алтайн хүдэр ХХК | 1,414 |
| Бусад | 2,064 |
| **Дүн** | **105,274** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Шинь Шинь ХХК | (17,406) |
| Чинхуа МАК нарийн сухайт ХХК | (10,664) |
| Лутчулуу ХХК | (9,605) |
| Болд төмөр ерөө гол ХХК | (9,243) |
| Энержи ресурс ХХК | (5,764) |
| Цайртминерал ХХК | (5,652) |
| Эрэл ХХК | (3,250) |
| Эрвэн хүдэр ХХК | (2,401) |
| Гүнбилэг гоулд ХХК | (1,800) |
| Цайртминерал ХХК | (1,271) |
| Азиагоулд монголиа ХХК | (1,036) |
| Чинхуа МАК нарийн сухайт ХХК | (967) |
| Шинь Шинь ХХК | (951) |
| Бусад | (4.460) |
| **Дүн** | **(74,470)** |
| **Цэвэр зөрүү** | **(30,804)** |

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа нэгтгээгүй, компаниуд нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ анх тусгасан дүнгээсээ илүү дүнгээр тусгаж ирүүлсэн.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, уг мэдээлэлд үндэслэн Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Гадаад харилцааны яам, ГИХАЭГ, АМГ, ХХҮГ, Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн газар, Усны газар, СХЗГ, Сорьцын улсын хяналтын газар, Геологийн төв лаборатори, Авто тээврийн газар, Төмөр зам зэрэг байгууллагуудад албан бичиг илгээж, холбогдох хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийсэн.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Хураамж үйлчилгээний хөлс, шимтгэлийн дүн ЗГ-ын тайланд бүрэн тусгагдахгүй, мэдээлэл нэгтгэгдэхгүй, мэдээлэлийг нэгтгэх тайлагнах механизм нь тодорхойгүй байгаа нь үүссэн зөрүүг шийдвэрлэх боломжгүй болгож байна.

### 6.5 Торгууль

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Улсын төсөвт төлсөн торгууль | (124,403,679) | 618,288 | (123,799,004) | 13,612 |
| Орон нутгийн төсөвт төлсөн торгууль | (212,027) | 117,256 | (88,111) | (6,660) |
| **Дүн** | **(124,615,706)** | **735,544** | **(123,887,114)** | **6,952** |

### 6.5.1 Улсын төсөвт төлсөн торгууль

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***ЗГ-ийн хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их*** | |
| Монголчехметалл ХХК | 9,982 |
| Гүнбилэг трейд ХХК | 7,159 |
| Гүнбилэг голд ХХК | 1,000 |
| Баян эрч ХХК | 162 |
| **Дүн** | **18,302** |
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Шинэ Илион Нэн Юань ХХК | (4,690) |
| | |
| **Дүн** | **(4,690)** |
| **Цэвэр зөрүү** | **13,612** |

***Улсын төсөвт төлсөн торгуулийн 12,612*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Монголчехметалл”, “Гүнбилэг трейд”, “Гүнбилэг голд”, “Баян эрч”, “Шинэ Илион Нэн Юань” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ болон компаниуд нь анхны тайландаа илүү, дутуу дүнгээр тусгасан байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан боловч компаниуд нь анхны тайланд тусгасан дүнгээр хариу ирүүлсэн тул, торгууль хүлээн авсан байгууллагын мэдээллийн дагуу дахин хандсан ч зөрүүг тодорхойлж чадахгүй байна.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** “Шинэ Илион Нэн Юань” ХХК руу хандахад 7,026.1 мянган төгрөгийн торгууль төлсөн гэж торгуулийн актыг ирүүлсэн боловч ТЕГ-ийн мэдээлэлд 2,335.8 мянган төгрөгийн торгууль төлсөн гэсэн ба хоёр талын мэдээлэл зөрсөн тул шийдвэрлэгдээгүй. Бусад компаниудын хувьд аливаа нэгэн хяналт шалгалтаар тавигдсан нөхөн төлбөрийг хүү торгуулийн дүнгээс салгаж ирүүлэхгүй бөөн дүнгээр нь ирүүлсэн байна.

### 6.5.2 Орон нутгийн төсөвт төлсөн торгууль

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Шинь Шинь ХХК | (4,540) |
| Алтайн хүдэр ХХК | (1,131) |
| Монголчехметалл ХХК | (739) |
| Хотгор шанага ХХК | (250) |
| **Дүн** | **(6,660)** |
| **Цэвэр зөрүү** | **(6,660)** |

***Орон нутгийн төсөвт төлсөн торгуулийн* (6,660)** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Шинь Шинь”, “Алтайн хүдэр”, “Монголчехметалл”, “Хотгор шанага” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа тусгаагүй, компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад нэмж үнэн зөв мэдээлэл ирүүлсэн.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан. Компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ орон нутгийн төсөвт төлсөн усны торгууль, аудитын хяналт шалгалтын торгууль, автомашины аливаа нэгэн зөрчлийн торгууль, мэргэжлийн хяналтын газар төлсөн торгуулиуд гэж тусгаж өгсөний дагуу Дорнод аймаг, Говь-Алтай аймгийн ЗДТГ-т албан бичиг илгээсэн.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Тус аймгуудын ЗДТГ-аас хариу ирэхдээ Дорнод аймгийн ЗДТГ-аас дутуу, Говь-Алтай аймгийн төсвийн орлогын дансанд холбогдох торгууль ороогүй байна гэсэн хариуг өгсөн тул зөрүү шийдвэрлэгдээгүй.

### 6.6 Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | (680,113) | 257,210 | (418,603) | (4,300) |

### 6.6.1 Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Чингисийн хар алт ХХК | (2,750) |
| Эф Эм Ай ХХК | (700) |
| Бэрх ресорсиз ХХК | (450) |
| Их монгол майнинг ХХК | (400) |
| **Дүн** | **(4,300)** |
| **Цэвэр зөрүү** | **(4,300)** |

***Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүнгийн (4,300)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Чингисийн хар алт”, “Эф Эм Ай”, “Бэрх ресорсиз”, “Их монгол майнинг” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа “Х” лиценз эзэмшдэг хайгуулын компаниудаас орон нутгийн ЗДТГ-ын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх барьцаа хөрөнгийг нэгтгээгүйгээс зөрүү үүссэн.
***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан. Компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ, Дорноговь, Сүхбаатар, Увс, Өмнөговь, Дундговь, Ховд зэрэг аймгийн ЗДТГ-т төвлөрүүлсэн гэж ирүүлсэний дагуу тус аймгуудын ЗДТГ-т 9 дүгээр сарын 26-нд 2/53 тоот албан бичгийг илгээж хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийсэн.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Тус аймгуудын ЗДТГ-аас хариу ирэхдээ Булган, Баян-Өлгий аймгуудаас дутуу, мөн “Их монгол майнинг” ХХК-иас Баян-өлгийн аймгийн ЗДТГ-т 150.0 мянган төгрөгийн барьцаа ороогүй, Өмгөговь аймгийн Гурван тэс, Ханбогд сумдаас төвлөрүүлсэн дүн дутуу ирсэн тул зөрүүг шийвдэрлэх боломжгүй болсон.

### 6.7 Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Яам, агентлагт өгсөн мөнгөн болон мөнгөн бусхандив, дэмжлэг | (10,294,719) | 10,980,174 | 697,483 | (12,028) |
| Аймаг, нийслэлд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг | (4,866,982) | 5,103,117 | 319,937 | (83,802) |
| Сум, дүүрэгт өгсөн мөнгөн болон мөнгө бус | (2,376,606) | 4,502,120 | 2,167,502 | (41,989) |

(мян.төг)

| Бүлэг | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| хандив, дэмжлэг | | | | |
| Бусад байгууллагад өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг | (1,266,947) | 474,005 | (792,942) | - |
| **Дүн** | **(18,805,254)** | **21,059,415** | **2,391,980** | **(137,818)** |

### 6.7.1 Яам, агентлагт өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Шинь Шинь ХХК | (9,528) |
| Мо Эн Ко ХХК | (2,000) |
| АУМ ХХК | (500) |
| **Дүн** | **(12,028)** |
| **Цэвэр зөрүү** | **(12,028)** |

***Яам, агентлагт өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийн (12,028)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Шинь Шинь”, “Мо Эн Ко”, “АУМ” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа компаниудаас Төр, засгийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнг нэгтгээгүйгээс зөрүү үүссэн байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан. Компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ Нийслэлийн автотээврийн газар, ЭБЭХЯам, ГИХАЭГ зэрэг байгууллагуудад өгсөн хандив дэмжлэг байна гэж ирүүлсний дагуу тус байгууллагуудад 9 дүгээр сарын 26-нд 2/53 тоот албан бичгийг илгээж хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийсэн. Компаниудаас хандив, дэмжлэгийн анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Нийслэлийн автотээврийн газар нь “АУМ” ХХК-иас хандив, дэмжлэг аваагүй, ЭБЭХЯ нь “Мо Эн Ко” ХХК-иас 2,000.0 мянган төгрөгийн мөнгөн хандив авсан, түүнээс ном хэвлүүлэхэд зориулж 2,000.0 мянган төгрөгийн хандив аваагүй, ГИХАЭГ нь “Шинь Шинь” ХХК-иас хандив, дэмжлэг авсан талаар ирүүлсэн мэдээлэлдээ дурьдаагүй байсан тул зөрүүг компанийн мэдээлэлд үндэслэн шийдвэрдлэх боломжгүй болсон.

### 6.7.2 Аймаг, нийслэлд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэг

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Бороо гоулд ХХК | (37,362) |
| Гоби коул энд энержи ХХК | (15,000) |
| Сод газар ХХК | (8,950) |
| Саусгоби сэндс ХХК | (5,938) |
| Мо Эн Ко ХХК | (4,618) |
| Рэдхил Монголиа ХХК | (4,353) |
| Оюу толгой ХХК | (2,700) |
| Шинь Шинь ХХК | (2,180) |
| Казмон контакт ХХК | (1,200) |
| Монголросцветмет ХХК | (1,000) |
| Эрэл ХХК | (500) |
| **Дүн** | **(83,802)** |
| **Цэвэр зөрүү** | **(83,802)** |

***Аймаг, нийслэлд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийн (83,802)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Бороо гоулд”, “Гоби коул энд энержи”, “Сод газар”, “Мо Эн Ко”, “Рэдхил

Монголиа”, “Оюу толгой”, “Шинь Шинь”, “Казмонконтакт”, “Монголросцветмет”, “Эрэл” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа компаниудаас Төр, засгийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан. Компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ Баянхонгор, Дундговь, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Өмнөговь, Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул зэрэг аймгуудын мөн Нийслэлийн ЗДТГ-т өгсөн хандив дэмжлэг байна гэж ирүүлсэний дагуу тус байгууллагуудад 9 дүгээр сарын 26-нд 2/53 тоот албан бичгийг илгээж хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийсэн. Компаниудаас хандив, дэмжлэгийн анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Өмнөговь аймгийн ЗДТГ нь “Оюу толгой” ХХК-иас 2,700.0 мянган төгрөг, Сэлэнгэ аймгийн ЗДТГ нь “Бороо гоулд” ХХК-иас 37,362.0 мянган төгрөг, "Редхил Монголиа" ХХК-иас 4,353.0 мянган төгрөг, Нийслэлийн ЗДТГ нь “Сод газар” ХХК-иас 8,950.0 мянган төгрөг, Дорнод аймгийн ЗДТГ нь “Шинь Шинь” ХХК-иас 2,180.0 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн ЗДТГ нь “Эрэл” ХХК-иас 500.0 мянган төгрөг, Өмнөговь аймаг дахь Шивээ хүрэнгийн гаалийн газар нь “Саусгоби сэндс” ХХК-иас 5,938.0 мянган төгрөгийн мөнгөн бус хандивыг, Ховд аймгийн Цагдаагийн хэлтэс нь Мо Эн Ко ХХК-иас 630.0 мянган төгрөг, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг нь “Мо Эн Ко” ХХК-иас 3,988.0 мянган төгрөг, Баян-Өлгий аймгийн ЗДТГ нь “Казмонконтакт” ХХК-иас 1,200.0 мянган төгрөг, Дундговь аймгийн ЗДТГ нь “Монголросцветмет” ХХК-ийн дүнг 1,000.0 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ЗДТГ нь “Гоби коул энд энержи” ХХК-иас 15,000.0 мянган төгрөгийн хандив, дэмжлэгийг тус тус аваагүй гэсэн хариу мэдээлэл өгсөн тул зөрүүг компанийн мэдээлэлд үндэслэн шийдвэрдлэх боломжгүй болсон.

**6.7.3 Сум, дүүрэгт өгсөн мөнгөн болон мөнгө бус хандив, дэмжлэг**

(мян.төг)

| Компанийн нэр | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|
| ***Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их*** | |
| Эрдэнэ жас ХХК | (11,000) |
| Хангад эксплорэшн ХХК | (10,167) |
| Мөнх ноён суварга ХХК | (6,412) |
| Шинь Шинь ХХК | (3,300) |
| Гоби коул энд энержи ХХК | (3,223) |
| Төгрөг нуурын энержи ХХК | (2,300) |
| Шарын гол ХК | (2,004) |
| Алтайн хүдэр ХХК | (1,563) |
| Олон овоот гоулд ХХК | (570) |
| Гоби консолидетед ХХК | (500) |
| Тайшэн девелопмент ХХК | (500) |
| Мо Эн Ко ХХК | (300) |
| Ханшижир ХХК | (150) |
| **Дүн** | **(41,989)** |
| **Цэвэр зөрүү** | **(41,989)** |

***Сум дүүрэгт өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийн (41,989)*** мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү нь “Эрдэнэ жас”, “Шинь Шинь”, “Мөнх ноён суварга”, “Хангад эксплорэшн”, “Гоби коул энд энержи”, “Төгрөг нуурын энержи”, “Шарын гол”, “Алтайн хүдэр”, “Олон овоот гоулд”, “Гоби консолидетед”, “Тайшэн девелопмент”, “Мо Эн Ко”, “Ханшижир” зэрэг компаниуд дээр үүссэн байна.

***Зөрүү үүссэн шалтгаан:*** ЗГ анхны тайландаа компаниудаас Төр, засгийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнг нэгтгээгүйгээс зөрүү үүссэн байна.

***Зөрүүг тохируулахаар хийгдсэн ажил:*** Нэгтгэл тайлангийн явцад компаниудаас дэлгэрэнгүй мэдээлэл авах тухай албан бичиг илгээж, хариу мэдээлэл авсан. Компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ Говь-Алтай аймгийн Цээл, Төгрөг, Эрдэнэ, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Дорноговь аймгийн Даланжаргалан, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Ханхонгор, Ховд аймгийн Мөнхайрхан, Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Овоо, Дорнод аймгийн Хэрлэн зэрэг сумдын ЗДТГ-т хандив, дэмжлэг өгсөн гэж хариу ирүүлсний дагуу эдгээр сумдын ЗДТГ-т 9 дүгээр сарын 26-нд 2/53 тоот албан бичгийг илгээж хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийсэн. Компаниудаас хандив, дэмжлэгийн анхан шатны баримтыг хувилуулж авсан.

***Шийдэгдээгүй зөрүүний тайлбар:*** Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь “Эрдэнэ жас” ХХК-иас 11,000 мянган төгрөг, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын ЗДТГ нь “Хангад эксплорэшн” ХХК-иас 10,167 мянган төгрөг, Баян-Овоо сумын ЗДТГ нь “Мөнх ноён суварга” ХХК-иас 6,412 мянган төгрөг, “Шинь Шинь” ХХК-иас Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ нь 1,100 мянган төгрөг, Дашбалбар сумын ЗДТГ нь 500 мянган төгрөг, Гурванзагал сумын ЗДТГ нь 200 мянган төгрөг, Баяндун сумын ЗДТГ нь 1,500 мянган төгрөг, “Гоби коул энд энержи” ХХК-иас Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЗДТГ нь 500 мянган төгрөг, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ЗДТГ нь 2,723 мянган төгрөг, Төв аймгийн Баян сумын ЗДТГ нь “Төгрөг нуурын энержи” ХХК-иас 2,300 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГ нь “Шарын гол” ХК-иас 2,004 мянган төгрөг, Говь-Алтай аймгийн Цээл сумын ЗДТГ нь “Алтайн хүдэр” ХХК-иас 1,563 мянган төгрөг, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Олон овоот гоулд” ХХК-иас 570 мянган төгрөг, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ нь “Гоби консолидетед” ХХК-иас 500 мянган төгрөг, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ нь “Тайшэн девелопмент” ХХК-иас 500 мянган төгрөг, Ховд аймгийн Мөнххайрхан сумын сургууль нь “Мо Эн Ко” ХХК-иас 300 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ нь “Хан шижир” ХХК-иас 150 мянган төгрөгийн хандив, дэмжлэгийн тус тус аваагүй гэсэн хариу ирүүлсэн. Иймд компаниас ирүүлсэн мэдээлэл болон анхан шатны баримтанд үндэслэн зөрүүг тохируулах боломжгүй юм.

## 7. АЖЛЫН ДААЛГАВАРТ ШААРДСАН НЭМЭЛТ СУДАЛГААНУУД

### 7.1 Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлт

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг ЗГ-ын 2007 оны 80 дугаар тогтоолоор баталсан хавсралтад сум, дүүрэг, аймаг нийслэлийн ЗДТГ нь орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, хандив дэмжлэг хүлээн авсан төсвийн байгууллагуудын мэдээг ОУИТБС-ын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж өгөхийг тодорхой тусгасан хэдий ч жил бүрийн нэгтгэл тайланд Төрийн байгууллагууд болон орон нутгийн төсвийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүн тусгагдахгүй зөрүү үүсгэхээс гадна Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалаар батлагдсан “Хандив, тусламжийг бүртгэх журам”-ыг ихэнх Төр, засгийн байгууллагууд болон аймаг, орон нутгийн ЗДТГ-ууд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал: Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Баянгол дүүргийн 20-р хороо зэрэг байгууллагууд тушаалыг хагас дутуу хэрэгжүүлсэн байна.

Харин Баянхонгор аймгийн Галуут, Бууцагаан, Булган аймгийн Хангал, Говь-Алтай аймгийн Шарга, Дорнод аймгийн Сэргэлэн, Чойбалсан, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Номгон, Цогтцэций, Ханхонгор, Сүхбаатар аймгийн Асгат, Түмэнцогт, Халзан, Баяндэлгэр, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Төв аймгийн Баян-Өнжүүл, Увс аймгийн Бөхмөрөн, Наранбулаг, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Хэнтий аймгийн Бэрх, Норовлин, Мөрөн, Батноров, Биндэр, Галшар зэрэг (нийт 12 аймгийн 26 сум) сумдууд уг тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Энд нэр дурьдагдаагүй аймгууд хандив, дэмжлэгийн дүнг ОУИТБС-ын маягтын дагуу хагас дутуу тусгаж, анхны нэгтгэл тайланд нэгтгүүлсэн байгаа тул 45-р тушаал хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Төрийн байгууллага болон орон нутгийн байгууллагуудын 45-р тушаалын хэрэгжилтийн дэлгэрэнгүйг Хавсралт “Ж-ийн а,б”–ээс харна уу.

### 7.2 СТОУС-ын мөрдөлтийн талаар хийсэн судалгаа

Нэгтгэлийн явцад бид нийт 200 компанид НББОУС/СТОУС-ыг хэрхэн дагаж мөрдөж байгааг маягтын дагуу гаргаж ирүүлэхийг хүссэн. 176 компани хариу ирүүлж, 24 компани хариу ирүүлээгүй байна. Хариу ирүүлсэн компанийн 16 нь аудит хийлгээгүй гэж ирүүлсэн. Судалгааны дэлгэрэнгүйг Хавсралт “З”–ээс харна уу.

Судалгааны дүнг нэгтгэн, шинжилгээ хийж үзэхэд эдгээр аудитын дүгнэлт гаргуулсан 160 компанид олон улсын 3, дотоодын 57, нийт 60 аудитын компани аудит хийсэн байна. Харин Улаанбаатар Аудит Корпораци ХХК нь 6 компанид аудит хийсэн байна.

Нийт аудитын дүгнэлтийн 92.5 хувь нь зөрчилгүй дүгнэлт, 7.5 хувь нь зөрчилтэй болон бусад хэлбэрийн аудитын дүгнэлтийг авсан байна. Гэтэл нийт хариу ирүүлсэн компанийн 20 нь буюу 12.5 хувь нь судалгаанд өгөгдсөн 11 асуулт бүхий стандартын заалтуудыг бүгдийг нь дагаж мөрдсөн гэж хариулт өгсөн. Харин үлдэх компаниуд нь аль нэг заалтыг нь дагаж мөрдөөгүй гэсэн боловч аудитын дүгнэлтээр 92.5 хувь нь аудитын ямар ч зөрчилгүй дүгнэлт авсан байгаа нь компаниудын ирүүлсэн хариу үндэслэлтэй эсэх, эсвэл аудитын компаниудын өгсөн дүгнэлт үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй байна.

Хүснэгтэд хариу ирүүлсэн 176 компанийн хувьд НББОУС/СТОУС-ын гол заалтуудыг компаниуд хэрхэн дагаж мөрдөж байгааг хувиар илэрхийлэн харуулбал дараах байдалтай байна.

| Дансдын нэрс | Заалтууд | Дагаж мөрдөлтийн хувь | | |
|---|---|---|---|---|
| | | Тийм | Үгүй | Тодорхой гүй |
| НББОУС 2-Бараа материал | Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэдэг эсэх? | 58.0 | 28.4 | 13.6 |
| НББОУС 16-Үндсэн хөрөнгө | Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг бүртгэдэг эсэх? | 47.7 | 45.5 | 6.8 |
| | Үндсэн хөрөнгийг бүрэлдхүүн хэсгүүдээр нь салгаж элэгдүүлдэг эсэх? | 65.9 | 29.0 | 5.1 |
| НББОУС 17-Түрээс | Санхүүгийн түрээсийн хөрөнгийг хөрөнгийн бодит үнэ цэнэ болон хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэдэг эсэх? | 33.0 | 39.8 | 27.3 |
| НББОУС 40-ХО-тын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн хөрөнгүүдийг тусад нь ангилж бүртгэдэг эсэх? | 44.9 | 33.0 | 22.2 |
| СТОУС 6-Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | Хайгуул ба үнэлгээний хөрөнгөд үнэ цэнийн бууралтын тест хийдэг эсэх? | 34.1 | 52.8 | 13.1 |
| НББОУС 10-Тайлагналын үеийн дараах үйл явдал | Тайлагналын өдрийн дараа болсон үйл явдлыг санхүүгийн тайландаа тодруулдаг эсэх? | 58.0 | 33.0 | 9.1 |
| НББОУС 24-Холбоотой талуудын тодруулга | Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээнүүдийг тодруулдаг эсэх? | 83.5 | 12.5 | 4.0 |
| НББОУС 37-Нөөц, болзошгүй өр төлбөр | Уурхайг хаах үе, байгалийг нөхөн сэргээх нөөцийг байгуулж, тэдэнд зохистой хорогдол тооцдог эсэх? | 40.9 | 38.1 | 21.0 |
| | Болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэдэг эсэх? | 52.3 | 42.0 | 5.7 |
| НББОУС 12-Орлогын татвар | Санхүүгийн болон орлогын албан татварын зөрүүг тохируулж, хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг эсэх? | 83.0 | 12.5 | 4.5 |
| **Дундаж хувь** | | **54.6** | **33.3** | **12.0** |

Дээрх хүснэгтээс харахад компаниудын НББОУС/СТОУС-ын мөрдөлт шаардлагын төвшинд хүрэхгүй байх магадлалтай нь харагдаж байна. Үүнийг дахин нягтлах шаардлагатай, түүнчлэн нийт компанийн 12 хувь нь СТОУС-ын талаар хариулахаас татгалзсан.

Хэрэв СТОУС-ын нийцэл нь МОҮИТБС-ын гол анхаарах асуудал бол компаниудын ирүүлсэн хариултуудад тайлбар өгүүлэх зорилгоор аудиторуудтай нь уулзах шаардлагатай. Хэдий тийм ч СТОУС-ын тайлагнал нь ОҮИТБС-ын Дүрмийн шаардлага биш юм.

ОҮИТБС-ын шаардлага 12-т шаардсаны дагуу МОҮИТБС-аас аудиторууд нь Аудитын олон улсын стандартыг дагаж мөрдөж байгааг эсэх талаар нэмэлт тодруулга авах хэрэгтэй.

### 7.3 Компаниудаас удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн байдал

Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компанид ОҮИТБС-ын маягтын дагуу гаргаж өгсөн тайлангийн хариуцлагатай байдлыг болон тайлан нь Аудитын олон улсын стандартын дагуу баталгаажсан эсэхийг “Удирдлагын хариуцлагын захидал”-аар (захидлын эхийг Хавсралт “И” –д харуулав) баталгаажуулах үүднээс уг захидлыг гаргаж ирүүлэхийг хүссэн.

**Удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн байдал**

сая.төг

| Удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн | Компани | | Орлого | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Бүгд | Хувь |
| Ирүүлсэн | 149 | 74.5 | 1,088,566 | 50.6 |
| Ирүүлээгүй | 51 | 25.5 | 1,062,168 | 49.4 |
| **Дүн** | **200** | **100.0** | **2,150,734.0** | **100.0** |

Удирдлагын хариуцлагын захидлыг 51 компани буюу 25.5 хувь нь хариу ирүүлээгүй байна. Нийт 1,088,566 сая төгрөгийн санхүүгийн урсгалын баталгаажуулалтыг хийсэн бөгөөд энэ нь нийт төлбөрийн 50.6 хувийг эзэлж байгаа юм. Үүнээс үзэхэд ОУИТБС-ын шаардлагын 12-д нийцэхгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрэхээр байна.

Компаниуд өөрсдийн үнэн зөвөө илэрхийлсэн бичгэн мэдэгдлээ ирүүлсэний дараагаар зарим мэдэгдэл нь нэгтгэл ажлын процессийн хэсэг болж материаллаг дүн бүхий нэмэлт тохируулга хийх болдог. Уг мэдэгдэлд хандах компаниудын хандлага нь эргэлзээтэй байна.

Ажлын хэсэг нь ОУИТБС-ын Шаардлага 12(б)-д заасан горимыг хэрэгжүүлэхийг бодолцож үзэхийг зөвлөж байна. Уг шаардлагад зааснаар компаниудын бэлтгэсэн мэдээлэл нь нэгтгэгч рүү хүргүүлэхээсээ өмнө тухайн компанийн хөндлөнгийн аудитороор баталгаажигдсан байх ёстой юм. Тухайн аудитор нь компанийн мөнгөн сууриар бэлтгэсэн ОУИТБС-ын мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байгааг баталгаажуулсан тайлан бэлтгэх ёстой.

### 7.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээг АМГ-аас ирүүлсэн 83 компанийн мэдээллийг нэгтгэн Хавсралт И-д харуулав.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээний нэгтгэлд хамрагдаагүй 117 компани нь хайгуул болон газрын тосны үйл ажиллагаа явуулдаг 55 компани, уул уурхайн үйл ажиллагаа явуулсан боловч нөхөн сэргээлт хийгээгүй 62 компани тухайн жилдээ нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөгүй, мөн нөхөн сэргээлтийн мэдээ тайланг ирүүлээгүй компаниуд байна.

Доорх хүснэгтэд нөхөн сэргээлт хийсэн 83 компанийн хураангуйг Хавсралт Й-д харуулав.

| Техникийн нөхөн сэргээлт (мян.м3) | | | Шимт хөрсний нөхөн сэргээлт (мян.м3) | | | Биологийн нөхөн сэргээлт (мян.м3) | | | Зарцуулагдах хөрөнгийн хэмжээ (мян.төг-р) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| **266.8** | **301.2** | **112.9** | **297.4** | **34.0** | **11.4** | **126.5** | **290.5** | **229.6** | **2,297.9** | **4,499.7** | **195.8** |

Нөхөн сэргээлтийн мэдээнээс харахад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хэмжээнд “Андын элч” ХХК, “Баялаг орд” ХХК, “Булгангангат” ХХК, “Дун-Эрдэнэ” ХХК, “Мондулаан трейд” ХХК, “Цайрт минерйл” ХХК зэрэг компаниуд хийсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Й-ийн а, б”-с харна уу)

Нөхөн сэргээлтэд хамгийн их мөнгө зарцуулсан компанийг дурьдвал “Бороо гоулд” ХХК 2.3 тэрбум төгрөг, “Энержи ресурс” ХХК 554.9 сая төгрөг, “Мөнхийн ноён суварга” ХХК 229.2 сая төгрөг, “МОНЭНКО” ХХК 200.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

БОНХЯ (Хуучнаар БОАЖЯ)-наас авсан мэдээллээр нэр бүхий 172 компани 2011 онд 1,215,632.0 мянган төгрөгийг Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн байна. (Хавсралт Е-аас үзнэ үү)

Тусгай дансны хөдөлгөөнийг ажиглахад 2011 онд нэг компани нөхөн сэргээлтээ бүрэн хийж, төвлөрүүлсэн хөрөнгөө буцааж авсан, БОНХЯ-аас тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлсэн тохиолдол гараагүй байна.

Иймээс компаниуд бага үнийн дүн бүхий барьцааг байршуулахын тулд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгөө багаар тооцоолдог байж болох талтай. Ашигт малтмал олборлогч ашигласан газраа орхиод явсан тохиолдолд тухайн газрыг нөхөн сэргээх санхүүгийн баталгаагүй болох эрсдлийг бий болгож байна.

Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 38 дугаар зүйлийн 3-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна” гэж заасан. Хэрэв тусгай дансны үлдэгдэл хүрэлцэхгүй болсон бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд сүйдсэн байгалийг нөхөн сэргээх асуудал бүрхэг хэвээр байна.
Бид энэхүү тайлангийн 8.3.1-т заасны дагуу зохих хууль эрх зүйг эргэн хянахыг зөвлөж байна.

Монгол улсын “Ашигт малтмалын тухайн хууль”-ийн дагуу тусгай зөвшөөрөл авсанаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах, холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлдэг. Уг зорилгоор энэхүү тусгай дансыг тухайн орон нутгийн Засаг дарга нээдэг. Хэдий тийм ч Тефис майнинг ХХК, Алтандорнод монгол ХХК, Бату майнинг ХХК, Орчлон орд ХХК, Олон овоот голд ХХК, Бэрх ресорсиз ХХК зэрэг компаниуд “Ашигт малтмалын тухай” хуулийн 38.1.8-д заасан байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх хуулийн хариуцлагаа биелүүлээгүй байна.

**Тоо мэдээний чанар**

| д/д | Компанийн нэр | Техникийн нөхөн сэргээлт (га) | Шимт хөрсний нөхөн сэргээлт (га) | Биологийн нөхөн сэргээлт (га) | Зарцуулсан хөрөнгө (сая.төг-р) | 1 га-д зарцуулагд сан зардал (сая.төг-р) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бороо голд ХХК | 55.2 | | 55.2 | 2,281.0 | 41.3 |
| 2 | "Энержи Ресурс" ХХК | 3.0 | - | 1.0 | 554.9 | 277.4 |
| 3 | "МоЭнКо" ХХК | 4.0 | - | 6.1 | 200.1 | 39.6 |
| 4 | "Саусгоби Сэндс" ХХК | 10.6 | 11.7 | 12.6 | 197.5 | 11.3 |
| 5 | Цайртминерал ХХК | 4.0 | | 4.0 | 146.3 | 36.6 |
| 6 | "Чин Хуа МАК Нарийн Сухайт" ХХК | - | 0.2 | 0.3 | 93.3 | 373.3 |
| 7 | "Таван толгой" ХК | 0.6 | 6.1 | 0.9 | 46.7 | 18.4 |
| 8 | Дун-Эрдэнэ ХХК | 3.2 | | 3.2 | 33.2 | 10.4 |
| 9 | Булган гангат ХХК | 4.1 | | 4.1 | 30.0 | 7.4 |
| 10 | "Андын илч" ХХК | 3.2 | 4.0 | 1.3 | 21.2 | 7.5 |
| 11 | Бэрх уул ХК | 22.5 | | 22.5 | 20.9 | 0.9 |
| 12 | "Болд Фо Ар Да" ХХК | - | 0.1 | - | 18.9 | 134.7 |
| 13 | "Шивээ-Овоо" ХК, "Эрдэнэс МГЛ" ХХК | - | - | 0.7 | 18.6 | 79.7 |
| 14 | "МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК | 3.1 | - | 3.0 | 18.4 | 6.0 |
| 15 | "Эрдэнэс Тавантолгой" ХК | - | 1.2 | - | 17.9 | 44.7 |
| 16 | "Шарын гол" ХК | 0.7 | 4.0 | - | 16.8 | 10.7 |
| 17 | "Адуунчулуун" ХК | 5.1 | 1.0 | 2.0 | 16.0 | 5.9 |
| 18 | Дацан трейд ХХК | 0.1 | | 0.1 | 11.3 | 113.0 |
| 19 | Хурай ХХК | 1.2 | | 1.2 | 9.3 | 7.5 |
| 20 | "Баялаг орд" ХХК | 2.5 | 1.7 | 1.7 | 7.2 | 3.7 |
| 21 | Гурван төхөм ХХК | 3.9 | | 3.9 | 6.6 | 1.7 |
| 22 | "Баянтээг" ХК | 3.7 | - | - | 5.5 | 1.5 |
| 23 | Гурван төхөм ХХК | 4.4 | | 4.4 | 5.0 | 1.1 |
| 24 | "Хотгор" ХХК | 1.0 | 1.8 | 1.8 | 2.9 | 1.9 |
| 25 | Эрэл ХХК | 0.4 | | 0.4 | 2.7 | 6.8 |
| 26 | Эм Си Ти Ти ХХК | 0.1 | | 0.1 | 2.5 | 27.8 |
| 27 | Шан Лун ХХК | 0.3 | | 0.3 | 2.0 | 5.9 |
| 28 | "Чингисийн Хар Алт" ХХК | - | 1.2 | - | 1.6 | 1.3 |
| 29 | Мондулаан трейд ХХК | 2.8 | | 2.8 | 1.5 | 0.6 |
| 30 | "Могойн гол" ХК | 4.5 | 1.0 | - | 0.8 | 0.3 |
| | **Нийт** | **144.3** | **34.0** | **133.6** | **3,790.6** | 42.6 |

Хүснэгтэд бодитоор гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн дүнг зарцуулсан хөрөнгийн дүнтэй харьцуулан, хөрөнгө зарцуулалтаар нь ихээс бага руу нь эрэмбэлэн харуулахад компаниудын зарцуулсан хөрөнгө харилцан адилгүй байна. Эндээс харахад компанийн тайлагнасан мэдээллийн найдвартай байдалд эргэлзээ төрөхөөр байна.

Тухайлбал: Нөхөн сэргээлтэд хамгийн их хөрөнгө буюу 2,251.0 сая төгрөг зарцуулсан “Бороо гоулд” ХХК нь 55.2 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн ба 1 га-д 41.3 сая төгрөг зарцуулсан байхад “Могойн гол” ХК нь 4.5 га-д техникийн нөхөн сэргээлт, 1 га-д шимт хөрсний нөхөн сэргээлт хийсэн гэж байгаа боловч нийт зарцуулсан хөрөнгө нь 800.0 мянган төгрөг байна.

Үүнээс үзэхэд ямар ч тохиолдолд 4.5 га газар техникийн нөхөн сэргээлт, 1 га шимт хөрсний нөхөн сэргээлт хийхэд 800.0 мянган төгрөгийн зардал гарах боломжгүй нь ойлгомжтой бөгөөд зарим компаниудын тоо мэдээ үнэн зөв эсэхэд эргэлзээ төрж байна.

### 7.5 Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа

Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааг олборлож буй бүтээгдэхүүн тус бүрээр давхардсан тоогоор нийт 128 компанийн мэдээлэл АМГ-аас ирсэн. Уг мэдээлэлд хамрагдаагүй компанийн хувьд хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг 45 компани, газрын тосны 13 компани компани байсан.
Доорх хүснэгтэд давхардсан тоогоор 40 компанийн уулын ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн судалгааг ижил нэгжээр илэрхийлэгдэх байдлаар нь салгаж илэрхийлсэн. Энэ хүснэгтэд зэс, цайр, хар тугалга, жонш, төмөр, шохойн чулуу, гөлтгөнө, битум зэрэг бүтээгдэхүүний үзүүлэлтийг нэгтгэн харуулав. (Дэлгэрэнгүйг Хавсралт “К”-аас харна уу) **Цаашид газрын тосны компаниудад тохируулсан өөр хэлбэрийн асуулгыг бэлтгэх нь зүйтэй болов уу.**

| Ашигт малтмалын төрөл | Хөрс хуулалт (мян.м3) | | | Хүдэр олборлолт (мян.м3) | | | Хүдэр боловсруулалт (мян.м3) | | | Бүтээгдэхүүн гаргалт (кг) | | | Бүтээгдэхүүн борлуулалт (кг) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| **Зэс, мөнгө, хар тугалга, цайр** | 6,539.6 | 7,133.5 | 233.3 | 27,070.1 | 28,163.9 | 202.6 | 26,112.5 | 26,555.2 | 200.2 | 609.6 | 3,394.5 | 255.3 | 609.6 | 3,381.7 | 242.7 |
| **Жонш** | 989.1 | 950.7 | 96.1 | 1,068.7 | 745.9 | 69.8 | 634.8 | 895.2 | 141.0 | 457.7 | 381.6 | 83.4 | 430.2 | 371.1 | 86.3 |
| **Төмөр** | 11,782.1 | 3,182.7 | 27.0 | 8,979.5 | 4,340.1 | 48.3 | 10,965.7 | 4,294.1 | 39.2 | 6,298.7 | 1,784.9 | 28.3 | 26,848.7 | 1,739.9 | 6.5 |
| **Барилгын материал** | 134.9 | 91.4 | 68.8 | 111.1 | 150.9 | 138.3 | 1.0 | - | - | 106.0 | 154.7 | 147.3 | 106.0 | 154.7 | 147.3 |
| **Дүн** | **19,445.8** | **11,358.3** | **58.4** | **37,229.4** | **33,400.8** | **89.7** | **37,714.0** | **31,744.5** | **84.2** | **7,472.0** | **2,942.7** | **39.4** | **27,994.5** | **2,874.4** | **10.3** |

Олборлох үйлдвэрлэлийн 2011 оны нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниас зэс олборлогч “Эрдэнэт үйлдвэр" ХХК уулын ажлын бүх үзүүлэлтийг 101.8-106.0 хувиар, цайр олборлогч “Цайрт минерал” ХХК 100.0-127.1 хувиар, жонш олборлогч “Нордвинд” ХХК 109.0-172.7 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Бусад компаниуд нь уулын ажлыг төлөвлөсөн хэмжээнээсээ 3.9-47.9 хувиар дутуу гүйцэтгэсэн байна.

Доорхи хүснэгтэд үндсэн ордоос алт олборлодог 4 компанийн уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн судалгааг харуулав. (Дэлгэрэнгүйг Хавсралт “К”-аас харна уу)

| Ашигт малтмалын төрөл | Хөрс хуулалт (мян.м3) | | | Хүдэр олборлолт (мян.м3) | | | Хүдэр боловсруулалт (мян.м3) | | | Бүтээгдэхүүн гаргалт (кг) | | | Бүтээгдэхүүн борлуулалт (кг) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| Үндсэн орд | 3,433.9 | - | - | 641.3 | - | - | 8,357.7 | 2.3 | 0.03 | 8,642.8 | 1.8 | 0.02 | 178.8 | 1.8 | 1.0 |

Доорхи хүснэгтэд шороон ордоос алт олборлодог 40 компанийн уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн судалгааг харуулав. (Дэлгэрэнгүйг Хавсралт “К”-аас харна уу)

| Ашигт малтмалын төрөл | Хөрс хуулалт (мян.м3) | | | Хүдэр олборлолт (мян.тн) | | | Хүдэр боловсруулалт (мян.тн) | | | Бүтээгдэхүүн гаргалт (мян.тн) | | | Бүтээгдэхүүн борлуулалт (мян.тн) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| Шорон орд | 18,818.2 | 5,244.6 | 27.9 | 6,085.7 | 3,777.7 | 62.1 | 5,168.1 | 3,764.6 | 72.8 | 4,611.5 | 4,951.7 | 47.2 | 4,265.0 | 4,066.8 | 30.3 |

Доорхи хүснэгтэд 35 нүүрс олборлогч компаниудын уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн судалгааг харуулав. (Дэлгэрэнгүйг Хавсралт “К”-аас харна уу)

| Хөрс хуулалт (мян.м3) | | | Бүтээгдэхүүн гаргалт (Нүүрс, мян.тн) | | | Бүтээгдэхүүн борлуулалт (Нүүрс, мян.тн) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **төл-гөө** | **гүйц-л** | **хувь** | **төл-гөө** | **гүйц-л** | **хувь** | **төл-гөө** | **гүйц-л** | **хувь** |
| 135,361.3 | 113,429.6 | 83.8 | 34,575.0 | 28,898.0 | 83.6 | 33,182.4 | 26,556.0 | 80.0 |

2011 онд хөрс хуулалтын байдлыг хамгийн их хөрс хуулсан компаниас эхлэн бага руу нь задлан харуулбал дараах байдалтай байна.

| Компанийн нэрс | Хөрс хуулалт (мян.м3) | Ашигт малтмалын төрөл |
|---|---|---|
| Энержи ресурс ХХК | 19,906.0 | Нүүрс |
| Саусгоби Сэндс ХХК | 18,178.4 | Нүүрс |
| Монголын Алт МАК ХХК | 17,533.8 | Нүүрс |
| Багануур ХК | 15,453.4 | Нүүрс |
| Таван толгой ХК | 12,378.4 | Нүүрс |
| Шивээ-Овоо ХК | 6,247.0 | Нүүрс |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | 5,670.0 | Зэс |
| Чин Хуа МАК Нарийн сухайт ХХК | 5,004.4 | Нүүрс |

| Компанийн нэрс | Хөрс хуулалт (мян.м3) | Ашигт малтмалын төрөл |
|---|---|---|
| Хангад Эксплорейшн ХХК | 3,941.6 | Нүүрс |
| Эрдэнэс Таван толгой ХК | 3,844.3 | Нүүрс |
| Бусад | 21,875.3 | |
| **Дүн** | **130,032.6** | |

Компаниуд нь янз бүрийн чиглэлээр олборлох үйл ажиллагаа явуулж байгаа тул олборлолт, боловсруулалт, бүтээгдхүүн гаргалт, бүтээгдхүүн борлуулалтын биет хэмжээг хооронд нь харьцуулах боломжгүй учраас ижил нэгжээр илэрхийлэгдэх байдлаар нь ангилж харууллаа.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ, уулын ажлын төлөвлөгөө болон түүний биелэлтийн судалгааг АМГ-аас гаргаж ирүүлсэн мэдээ материалд үндэслэн гаргасан.

### 7.6 Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн

Нэгтгэлд хамрагдсан компаниудын ашиглалтын болон хайгуулын лицензийн хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Л-ийн а” –аас харна уу).

| | Ашиглалтын лицензийн тоо | | | | Хайгуулын лицензийн тоо | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 оны эхэнд | Шинээр авсан | Хасагдсан | 2011 оны эцэст | 2011 оны эхэнд | Шинээр авсан | Хасагдсан | 2011 оны эцэст |
| Нэгтгэлд хамрагдсан компаниудын хувьд | 382 | 26 | 10 | 398 | 578 | 24 | 57 | 545 |

Хүснэгтээс харахад 2011 оны эхэнд нэгтгэлд хамрагдсан 200 компанийн 136 нь 382 ширхэг ашиглалтын лиценз эзэмшиж байсан бол оны эцэст 398 болж өссөн байна. Тухайлбал: “Баян тэгш”, “Гурван зам”, “Дорнын хүдэр”, “Жи Эл Ди Ви”, “Мөнх ноён суварга”, “Олон овоот гоулд”, “Саусгоби сэнд”, “Си Өү Эй Эл”, “Си Эм Кей Ай”, “Хан шижир”, “Эжбалей” зэрэг компаниуд тус бүр 1 ширхэг, нийт 11 ширхэг хайгуулын лицензийг, ашиглалтын лиценз рүү шилжүүлэн авсан, нэр бүхий 6 компани бусдаас 15 ширхэг ашиглалтын лицензийг шилжүүлэн авсан байна. “Баялаг орд”, “Бэрэн групп”, “Гүнбилэг трейд”, “Эрвэн хүдэр”, “Эрдэнэс МГЛ” зэрэг компаниуд нь 1-5 ширхэг ашиглалтын лицензийг бусдад шилжүүлсэн байна.

Мөн 2011 оны эхэнд нэгтгэл тайланд хамрагдсан 200 компанийн 69 компани нь 578 ширхэг хайгуулын лиценз эзэмшиж байсан бол оны эцэст 545 болж буурсан байна.

Энэ тайлант хугацаанд “Геомин”, Гоби коул энд энержи”, “Их монгол майнинг”, “Каскейд”, “Мондулаан трейд”, “Мон лаа”, “Монгол алтай ресорсиз”, “Өү Жи Си Эйч Эл”, “Си Си И Эм”, “Сод газар”, “Терра-Энержи”, “Тенгри терра ресурс”, “Хера Инвестмент”, “Хоту” зэрэг компаниуд нь 1-7 ширхэг буюу нийт 24 ширхэг хайгуулын лицензийг бусдаас шилжүүлэн авсан байна. Хайгуулын 57 ширхэг лицензийн хасагдсан хөдөлгөөн нь нэр бүхий 28 компани дээр гарсан байна. Тухайлбал: 11 ширхэг хайгуулын лицензийг ашиглалтын лиценз рүү, нэр бүхий 14 компани нийт 40 ширхэг лицензийг бусдад шилжүүлсэн байна. Харин “Азиагоулд” ХХК 1 ширхэг, “Тефис майнинг” ХХК 3 ширхэг, “Эрдэнэ жас” ХХК 2 ширхэг нийт 6 ширхэг хайгуулын лицензийн хугацаа дууссан байна.

АМГ-аас ирүүлсэн мэдээллээс харахад ашиглалтын 1,200 ширхэг, хайгуулын 2,576 ширхэг лиценз, нийт 3,776 лицензийг 1,841 компани эзэмшиж байна. Уг мэдээлэл нь 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр нэгтгэж гаргасан судалгаа болно. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Л-ийн б”-ээс харна уу).

### 7.7 Ашиглалтын болон хайгуулын хамгийн олон лиценз эзэмшигч

Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниудаас хамгийн олон лиценз эзэмшиж буй компанийг дараах байдлаар харуулав. **Үүнд:**

| Нэрс | БОНССанд барьцаа мян.төг | "А" лиценз | "Х" лиценз | Бүгд | Компанийн хэлбэр |
|---|---|---|---|---|---|
| 1.Тефис майнинг ХХК | - | | 63 | **63** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 2.Алтандорнод монгол ХХК | - | 29 | 6 | **35** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 3.Пибодивинсвэй ресорсез ХХК | 10,000.0 | 3 | 27 | **30** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 4.Сентеррагоулд монголия ХХК | 1,625.0 | 7 | 20 | **27** | 100 хувь гадаадын ХО-тай |

| Нэрс | БОНССанд барьцаа мян.төг | "А" лиценз | "Х" лиценз | Бүгд | Компанийн хэлбэр |
|---|---|---|---|---|---|
| 5.МОЭНКО ХХК | 66,442.0 | 10 | 9 | **19** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 6.Гобиконсолидетед ХХК | 4,175.0 | | 18 | **18** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 7.Эрдэнэжас ХХК | 2,601.5 | | 17 | **17** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 8.Бату майнинг монгол ХХК | - | | 15 | **15** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 9.Саусгоби сэндс ХХК | 125,745.0 | 3 | 12 | **15** | 100 хувь гадаадын ХО-тай |
| 10.Самтанморес ХХК | 900.0 | | 14 | **14** | 100 хувь гадаадын ХО-тай |
| **Дүн** | **211,488.5** | **52** | **201** | **253** | |
| 11.Гобикоул энд энержи ХХК | 7,775.0 | 4 | 28 | **32** | 100 хувь монголын ХО-тай |
| 12.Монголын алт МАК ХХК | 7,050.0 | 22 | 9 | **31** | 100 хувь монголын ХО-тай |
| 13.Гацуурт ХХК | 7,575.0 | 18 | 3 | **21** | 100 хувь монголын ХО-тай |
| 14. Орчлон-Орд ХХК | - | | 16 | **16** | 100 хувь монголын ХО-тай |
| 15. Олон Овоот гоулд ХХК | - | 7 | 8 | **15** | 100 хувь монголын ХО-тай |
| 16.Дацан трейд ХХК | 3,827.5 | 11 | 3 | **14** | 100 хувь монголын ХО-тай |
| 17. Тэнгритерра ресурс ХХК | 6,365.0 | | 13 | **13** | 100 хувь монголын ХО-тай |
| 18.Эм Ар Си Эм Жи Эл ХХК | 600.0 | | 13 | **13** | 100 хувь монголын ХО-тай |
| **Дүн** | **33,192.5** | **62** | **93** | **155** | |
| 19.Монголросцветмет ХХК | 76,313.5 | 33 | 3 | **36** | Төрийн өмч, ГХО |
| 20.Бэрхресорсиз ХХК | - | | 13 | **13** | ГХО-тай хамтарсан |
| **Дүн** | **76,313.5** | **33** | **16** | **49** | |
| **Нийт** | **320,994.5** | **147** | **310** | **457** | |

Нийт лицензийн 50 орчим хувийг 20 компани эзэмшиж байна. Дээрх нэр бүхий компаниудын эзэмшиж байгаа лиценз нь 2011 оны эцэст байгаа нийт лицензийн 49 хувийг эзэлж байна.

### 7.8 Гэрээний биелэлтийн судалгааны талаар

Нэгтгэл тайлангийн ажил эхлэхэд компаниудад 2012 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн 2/38 тоот албан бичгээр “Компанийн олборлолт болон хайгуул явагдаж байгаа орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний хуулбар, эсхүл биелэлтийн товч тайлан”-г хавсралтаар гаргаж явуулна уу гэж хандсан. Нэгтгэл тайлангийн явцад 21 компани буюу дөнгөж 10 хувь нь хариу ирүүлсэн. Нийт 39 гэрээг орон нутгийн ЗДТГ-тай давхардсан тоогоор 29 компанийн удирдлага байгуулсан байна. Орон нутгийн ЗДТГ-т 2012 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 2/53 тоот албан бичгээр “Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд болон орон нутгийн засаг захиргааны хооронд хамтран ажиллах гэрээ байгуулсан бол гүйцэтгэлийн товч танилцуулгыг ирүүлнэ үү” гэж хандсан боловч нэг ч аймаг, сумын ЗДТГ-аас хариу ирүүлээгүй. Гэрээний хураангуйг дараах байдлаар харуулав. (Дэлгэрэнгүйг Хавсралт “М”-ээс харна уу).

| д/д | Гэрээний утга | Гэрээ хийсэн компанийн тоо | Хийсэн гэрээний тоо | Гэрээнд хамрагдсан орон нутаг |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай | 5 | 8 | 8 |
| 2 | Хамтран ажиллах гэрээ | 8 | 8 | 7 |
| 3 | Ус ашиглах гэрээ | 8 | 8 | 7 |
| 4 | Газар эзэмшүүлэх гэрээ | 6 | 7 | 7 |
| 5 | Хайгуул хийх гэрээ | 1 | 1 | 1 |
| 6 | Бусад | 1 | 7 | |
| | **Нийт** | **29** | **39** | |

### 7.9 Мэдээ тайлангийн чанар

Бид анхлан компаниудад хандахдаа албан ёсны албан бичгийг хэд хэдэн хавсралтуудын хамт илгээсэн. Эдгээр хавсралтуудад:

- СТОУС-ыг дагаж мөрдөж байгаа байдал,
- Удирдлагын хариуцлагын захидал,
- Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хөдөлгөөн,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ,

- Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа,
- Орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний биелэлтийн тайлан зэргийг гаргаж ирүүлэхийг компаниудаас хүссэн.

Гэвч компаниудын гаргаж ирүүлж байгаа мэдээ тайлангийн чанар маш доогуур, нэр төдий байдлаар тайланг бөглөж ирүүлж байна. Хавсралтуудыг 5-аас дээш удаа хандаж байж гаргуулж авч байсан.

Компаниуд нь “Уурхайн уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл” (Маягт №2.7), “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ” (Маягт №2.9)-г АМГ-т гаргаж өгдөг ба компаниудад АМГ-т гаргаж өгсөн тайлангаа хувилж явуулна уу гэсэн албан бичгийг, эдгээр маягтуудын хамт хавсарган хүргүүлсэн.

Компаниудын гаргаж өгсөн мэдээ, судалгааг нэгтгээд АМГ-аас ирүүлсэн судалгаатай тулгаж үзэхэд өнгөрсөн жилийн гарч байсан (м3-ыг га-аар, тн-ыг кг-аар илэрхийлсэн гэх мэт) алдаа давтагдаж байсан. АМГ-аас уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх мэдээ зэргийг бэлтгэж ирүүлэхийг хүссэн боловч АМГ-аас ирүүлсэн мэдээлэл нь шаардлага хангахгүй байсан.

Тухайлбал:

1. Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааны маягтыг нэгтгэхдээ бүтээгдэхүүнийг хэмжих хэмжигдэхүүн нь ашигт малтмалын төрлөөсөө шалтгаалаад кг-аар, тн-оор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлтийг нэг хүснэгтэд нэгтгэсэн, нийлбэр дүнгий нь гаргаагүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх мэдээний хүснэгтэд байгаа тоон үзүүлэлтүүд нь гүйцэд гараагүй алдаа заасан, гүйцэтгэлийн хувийн жинг буруу гаргасан зэрэг алдаатай ирүүлсэн. Өнгөрсөн жил эдгээр мэдээллийг ОҮИТБС-ын ажил хариуцсан мэргэжилтэн бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж ирүүлж байсаныг дурьдах нь зүйтэй болов уу.
2. Нэгтгэл тайлангийн ажил хийгдэж буй энэ үед тус мэргэжилтэн ээлжийн амралтаа авсан байсан учраас ажлыг нь эзгүй хойгуур нь орлон гүйцэтгэсэн мэргэжилтэн тайлан мэдээ, судалгааг гаргах ажилд хариуцлагагүй хандсаныг энд дурьдаж байна.
3. Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний тайлан, мэдээнд тусгагдсан тусгай зөвшөөрлийн тоо, 2011 оны эцэст нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн судалгаанд тусгагдсан тусгай зөвшөөрлийн тоо хоорондоо зөрүүтэй байсан. Энэ нь нэг байгууллагын хоёр өөр хэлтсээс гаргасан мэдээлэл зөрүүтэй байгаа нь тус байгууллагын хэлтсүүдийн хоорондын ажлын уялдаа холбоо муу, түүнд тавих хяналт сул байгааг харуулж байна.
4. Гаалийн ерөнхий газар нь мэдээллийг төлөлт бүрээр гаргаж ирүүлэлгүй, бөөн дүнгээр ирүүлсэнээс компаниудаас төлсөн гаалийн татвар болон гаалийн үйлчилгээний хураамжийн зөрүүтэй дүнгүүд шийдвэрлэгдэхгүй дахин дахин тус байгууллагад хандсан. Тус газар нь жилийн жилд л нэгтгэл тайлангийн ажилд хойрго, үл тоосон байдал гаргаж байдгийг Ажлын хэсэг, Үндсэний зөвлөл анхааралдаа авч, зохих арга хэмжээг авах нь зүйтэй болов уу.

### 7.10 Засгийн газар болон компаниудын оролцоо

Бид нийт 491 байгууллагад албан бичиг хүргүүлж, холбогдох мэдээллийг авч ажиллалаа. Үүнд:

| | Албан бичиг илгээсэн байгууллагуудын тоо |
|---|---|
| Яам, агентлаг | 31 |
| Төсвийн байгууллага | 33 |
| Аймаг | 21 |
| Сум | 198 |
| Дүүрэг | 8 |
| Компани | 200 |
| **Нийт** | **491** |

Ажлын даалгаварт зааснаар тайлагнагч байгууллагуудын ил тод байдал, харилцааны соёлын талаар ямар байсныг тайландаа дүгнэлт оруулахыг хүссэн. Бид энэ талаар оролцогч 200 компани, Төрийн байгууллагуудын оролцоог дараах байдлаар үнэлсэн.

| Ангилал | Нэгтгэлд хамрагдсан ЗГ-ын байгууллага, компанийн тоо | Үнэлгээ | | |
|---|---|---|---|---|
| | | Хангалттай | Дунд | Хангалтгүй |
| ЗГ-ын байгууллагууд | 11 | 5 | 4 | 2 |
| ОНӨЗ (аймаг) | 21 | 8 | 5 | 8 |
| Компаниуд | 200 | 54 | 118 | 28 |

Тухайлбал: Төрийн байгууллагуудын хувьд хангалттай-5, дунд-4, хангалтгүй-2 гэсэн үнэлгээтэй гарлаа. (Дэлгэрэнгүйг Хавсралт “Н”-ээс харна уу).

Хангалттай үнэлгээг ТЕГ, ГТГ, БОНХЯ, НДЕГ, Төрийн өмчийн хороо зэрэг байгууллагууд авсан.

Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Цөмийн энергийн газар зэрэг байгууллагуудад дараахь шалтгааны улмаас “Дунд” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

- “Оюу толгой” ХХК-иас төлсөн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлсөн урьдчилгаа төлбөрийг тодруулах зорилгоор илгээсэн албан бичгийн хариуг Сангийн яамнаас авахад нэлээд хүндрэлтэй байсан.
- Гаалийн ерөнхий газарт зөрүүтэй дүнг шийдвэрлэх зорилгоор 2012 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн 2/41 тоот албан бичигт “Өмнөх жилүүдэд танай байгууллага уул уурхайн компаниудаас төлсөн гаалийн татвар болон үйлчилгээний хураамжийг төлөлт тус бүрээр бус нэгтгэсэн нэг дүнгээр ирүүлж байсан. Нэгтгэсэн дүнгээр ирүүлэх нь зөрүү шийдвэрлэгдэхгүй, дахин танай байгууллагад хандаж чирэгдэл болдог учраас мэдээллийг дэлгэрэнгүй задаргаагаар ирүүлэхийг хүсье” гэж дурьдсан боловч уг албан бичгийн зорилгод ач холбогдол өгөлгүй өмнөх жилийн нэгэн адил бөөн дүнгээр ирүүлсэн.
- Ашигт малтмалын газар нь мэдээллийг оновчтой хэлбэрээр гаргаж өгөөгүй бүх лиценз эзэмшигч компаниудаас төлсөн төлбөр, үйлчилгээний хураамжийг гаргаж өгч, цаг хугацаа их алдуулж байсан ба уг мэдээллээс шаардлагатай дүнг хайхад хүндрэлтэй байсан. Энэ шалтгааныг эс тооцвол өмнөх жилүүдтэй харьцуулахад ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг ам.долларoор биш төгрөгөөр тайлагнасан, мөн цаг хугацаанд ач холбогдол өгч ажилласаныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.
- Цөмийн энергийн газар нь мэдээллийг бүрэн гүйцэд гаргаж өгөөгүй дахин хандаж мэдээллийн гүйцээж авсан.

МХЕГ-т дараахь шалтгааны улмаас “Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

- ЗГ-ын нэгтгэл тайланд МХЕГ нь өөрт хамааралтай торгуулийн дүнг тайлагнаж нэгтгүүлсэн учраас торгуулийн зөрүүтэй дүнг тодруулах зорилгоор МХЕГ-т албан бичиг хүргүүлсэн. Уг албан бичгийн хариуг авахаар ерөнхий нягтлан бодогчтой олон хоног ажиллахад Сангийн яамны төрийн сангийн газрын торгууль шийтгэврийн орлогын дансны хуулганаас шүүлгэх нь зүйтэй гэсэн хариуг өгч байсан. Бид ЗГ-ын нэгтгэл тайланд тусгагдсан өөрт хамааралтай дүнгээ тодруулж өгөх талаар дахин дахин хүсэлт гаргасны эцэст хариу мэдээллийг шаардлагын хэмжээнд гаргаж өгөөгүй нэгтгэл тайланд хамааралгүй хуулийн этгээдийн мэдээлэл дийлэнх нь байсан.
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар албан бичгийн хариуг өгөхдөө асар их хойрго хандаж байсан. Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр хариуцсан мэргэжилтэн нь би энэ орон тоон дээр байх эсэхээ мэдэхгүй байгаа учраас дараагийн мэргэжилтэн томилогдохоор наад асуудлаа тавьсан нь дээр гэсэн шалтгаан тоочин нэгтгэл тайлангийн ажилд хойрго хандаж, цаг хугацаа их алдуулж байлаа.

Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хувьд хангалттай-8, дунд-5, хангалтгүй-8 гэсэн үнэлгээтэй гарсан. ОНЗЗ-ны байгууллагуудын нээлттэй байдлын талаарх хураангуйг (Хавсралт “О”-с харна уу).

Орон нутгийн захиргааны байгууллагуудад нэгтгэл тайлангийн явцад компаниудаас гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, үзүүлсэн хандив, дэмжлэгийн зөрүүтэй дүнгүүдийг тодруулах зорилгоор ОУИТБС-ын ажлын алба болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн хамтарсан 2/53 тоот албан бичгийг 2012 оны 09 дүгээр сарын 26-ний өдөр факсаар илгээж, хариу мэдээллийг авч ажилласан. Аймгуудын ЗДТГ-т үнэлгээ өгөхдөө албан бичгийн хугацаанд хэрхэн ач холбогдол өгч байсан, хавсралтад дурьдсан мэдээллийг бүрэн гүйцэд үнэн зөв бэлтгэсэн эсэх зэрэгт үндэслэсэн.
Ихэнхдээ мэдээ тайлангаа дутуу ирүүлдэг, худал мэдээлдэг, 5-аас дээш удаа хандаж байж зөв мэдээллийг гаргуулж авах зэргээр аль аль талдаа хүндрэл учруулж байна.

***“Дунд”*** гэсэн үнэлгээг дараах шалтгааны улмаас өгсөн.

- Баянхонгор аймгийн ЗДТГ нь олон дахин шаардуулсан, Шинэжинст, Баян-Овоо зэрэг сумдын ЗДТГ-ын мэдээллийг дутуу ирүүлсэн.
- Хөвсгөл аймгийн ЗДТГ нь аймаг, сумын орон нутгийн төсөвт компаниудаас төлсөн төлбөр болон үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүнг дутуу ирүүлсэн. Дахин нөгөө компаниуд руу хандаж анхан шатны баримтыг авч мэдээллийг илүү тодорхой болгосны эцэст мэдээллийг гүйцээж өгсөнийг эс тооцвол хугацаанд ач холбогдол өгч мэдээллийг шуурхай гаргаж өгч байсан.
- Дархан-Уул, Дорнод, Орхон зэрэг аймгийн ЗДТГ-ууд нь хугацаандаа мэдээллээ гаргаж өгөхгүй олон дахин шаардуулж чирэгдэл болж байсан.

***“Хангалтгүй”*** гэсэн үнэлгээг дараах шалтгааны улмаас өгсөн.

- Баян-Өлгий аймгийн ЗДТГ нь ЗГ-ын нэгтгэл тайланд нэгтгүүлсэн хандив, дэмжлэгийн дүнгээ, нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн мэдээлэлдээ аваагүй гэсэн албан бичиг ирүүлсэн.
  Эндээс дүгнэхэд гаргаж ирүүлж байгаа мэдээ тайлангийн чанар маш доогуур, мэдээ тайлангийн үнэн зөв бэлтгэхэд хандаж буй хандлага сул зөвхөн ор нэр төдий байдлаар тайланг бөглөж ирүүлж байсан.

- Дорноговь, Завхан, Сэлэнгэ, Увс, Ховд зэрэг аймгийн ЗДТГ-ууд руу албан бичиг илгээснээс хойш ажлын 5 хоногийн дараа холбогдох албан тушаалтантай утсаар холбогдож, зөрүү тодруулах ажлын явц ямар шатандаа явж байгаа, хэзээ ирүүлэх талаар асуухад огт хийж эхлээгүй байсан, араасаа маш олон дахин шаардуулж, ихээхэн чирэгдэл учруулсаны эцэст мэдээллээ ирүүлэхэд Увс, Ховд аймгийн ЗДТГ нь дутуу ирүүлсэн. Завхан аймгийн хувьд уул уурхайн цөөхөн компаниас 1-3 сумыг хамарсан мэдээлэл бэлтгэж ирүүлэх байтал цаг хугацаанд нь хийж ирүүлээгүй. Эдгээр аймгууд нь албан бичгийн хугацаанд ач холбогдол өгөхгүй байсан.
- Дундговь аймгийн ЗДТГ нь жилийн жилд л нэгтгэл тайлангийн ажилд идэвхгүй оролцдог, мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж ирүүлдэггүй, хугацаанд ач холбогдол өгдөггүй, араасаа олон дахин шаардуулж чирэгдэл болж байсан.
- Өмнөговь аймгийн ЗДТГ нь тухайн жилийн тайлан мэдээндээ уул уурхайн компаниудаас авсан хандив, дэмжлэгийн дүнг тусгаж өгсөн, одоо дахин гаргаж өгөхөд чирэгдэлтэй байна гэсэн тайлбар өгч, цаг хугацаа их хэмжээгээр алдуулсаны эцэст бидний шаардсан мэдээллийг бэлтгэх болсон. Уг мэдээллийг бэлтгэж байсан албан тушаалтан нь хэд хэдэн сумдын ЗДТГ-аас авсан мэдээллээ нэгтгэж ирүүлэлгүй, албан томилолтоор сумдад ажиллаж байна гэж нэгтгэл тайлангийн ажилд хойрго хандаж, мэдээллийг албан бичиг авсанаас хойш нэг сарын дараа ирүүлсэн. ЗГ-ын анхны тайланд тухайн аймгаас нэгтгэгдэж ирсэн дүн нь бөөн дүнгээр, мөн хандив, дэмжлэг нь зөв ангилагдаагүй, мөн компаниудаас өгсөн хандив, дэмжлэгийн дүн гүйцэд тусгагдаагүй, нэгтгэл тайлангийн явцад компаниуд нь хандив, дэмжлэгийн дүнг нэмж ирүүлсэн зэргээс шалтгаалаад зайлшгүй дахин тодруулах шаардлага олон дахин гарч байлаа.

Компаниудын хувьд хангалттай-53, дунд-119, хангалтгүй-28 гэсэн үнэлгээтэй гарсан. Компаниудын нээлттэй байдлын талаарх хураангуйг (Хавсралт “Ө”-с харна уу).

Ил тод байдал, харилцааны соёлын талаар дараахь компаниудад “Хангалттай” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

| | | | |
|---|---|---|---|
| 1.Адуунчулуун ХК | 14.Голден крос ХХК | 27.Монголросцветмет ХХК | 40.Си Си И Эм ХХК |
| 2.Азиагоулд монголиа ХХК | 15.Дацан трейд ХХК | 28.Мөнх ноён суварга ХХК | 41.Си Эм Кэй Ай ХХК |
| 3.Алтай хангай бүрд ХХК | 16.Жи Эл Ди Ви ХХК | 29.Одод гоулд ХХК | 42.Сонор трейд ХХК |
| 4.Алшаахайрхан ХХК | 17.Жотойн бажууна ХХК | 30.Олова ХХК | 43.Тайшэн девелопмент ХХК |
| 5.Баялаг орд ХХК | 18.Зараяа холдингс ХХК | 31.Орчлон орд ХХК | 44.Тефис Майнинг ХХК |
| 6.Баян айраг эксплорэйшн ХХК | 19.Зуунмод Уул ХХК | 32.Очир-Ундраа ХХК | 45.Тэн хун ХХК |
| 7.Баян эрч ХХК | 20.Илт гоулд ХХК | 33.Оюут улаан ХХК | 46.Улзгол ХХК |
| 8.Баянтээг ХХК | 21.Каскейд майнинг ХХК | 34.Өү Жи Си Эйч Эл ХХК | 47.Хар тарвагатай ХК |
| 9.Белгравия майнинг ХХК | 22.Кожеговь ХХК | 35.Петрокоал ХХК | 48.Хос хас ХХК |
| 10.Булган гангат ХХК | 23.МЕС ХХК | 36.Рэдхил Монголиа ХХК | 49.Чингисийн хар алт ХХК |
| 11.Бумбат ресорсес ХХК | 24.Мон Лаа | 37.Сансарын геологи хайгуул ХХК | 50.Чинхуа МАК нарийн сухайт ХХК |
| 12.Бэрх-Уул ХХК | 25.Монгол ураниум ресурс ХХК | 38.Саусгоби сэндс ХХК | 51.Шинэ шивээ ХХК |
| 13.Голден гоби майнинг ХХК | 26.Монголжүюаньли ХХК | 39.Сентерра гоулд монголиа ХХК | 52.Эмээлт майнз ХХК |
| | | | 53.Эс Би Эф ХХК |

Ил тод байдал, харилцааны соёлын талаар дээрхи компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээллийг богино хугацаанд шуурхай, үнэн, зөв, гүйцэд гаргаж өгсөнөөс гадна, нэмж тодруулах зүйлд цаг алдалгүй хариу өгч байсан учраас “Хангалттай” гэсэн үнэлгээг өгсөн.

Ил тод байдал, харилцааны соёлын талаар дараахь компаниудад “Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

| | | | |
|---|---|---|---|
| 1.Алтан дорнод монгол ХХК | 8.Гацуурт ХХК | 15.Зө Юү Э ХХК | 22. Тавантолгой ХК |
| 2.Бату Майнинг Монгол ХХК | 9.ГБНБ ХХК | 16.Их Хан Уул ХХК | 23. Ханшижир ХХК |

| | | | |
|---|---|---|---|
| 3.Биг Могул Коул энд Энержи ХХК | 10.Геомин ХХК | 17.Монгол алтай ресорсиз ХХК | 24. Хотгор шанага ХХК |
| 4.Болд төмөр ерөө гол ХХК | 11.Гүнбилэг голд ХХК | 18.Монгол метал майнинг ХХК | 25. Хүдэн ХХК |
| 5.Броад ХХК | 12.Гүнбилэг трейд ХХК | 19.Олон овоот голд ХХК | 26. Эм Ар Си Эм Жи Эл ХХК |
| 6.Буман-Олз ХХК | 13.Дэлгэр-Орчлон ХХК | 20.Си Өү Эй Эл ХХК | 27. Эрдэнэ жас ХХК |
| 7.Бумбат ХХК | 14.Жинхуа орд ХХК | 21.Си Си Эм ХХК | 28. Эрдэнэс таван толгой ХК |

“Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн учир нь:

Нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөхдөө асар их хойрго хандаж байснаас гадна, дэлгэрэнгүй задаргаа хэлбэрээр биш, бөөн дүнгээр, дутуу, бусад хавсралтаар гаргаж өгөх, мэдээллийг гаргаж ирүүлэхгүй, цаг хугацаа алдуулж байсан.

### 7.11 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг

Анхны тайлан болон нэгтгэл тайлангийн явцад компаниудын зүгээс Төр, засгийн байгууллагуудад 14,872.7 сая төгрөгийн хандив, дэмжлэг үзүүлсэн гэж тусгаж өгсөний дагуу Төр, засгийн байгууллагуудад хандаж хариу мэдээлэл авахад 14,851.7 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг хүлээн авсан гэсэн хариу өгч, 21.0 сая төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “П, Р”-с харна уу).

**(Мянган төгрөгөөр)**

| д/д | Хандив авсан байгууллагуудын нэр | Тохируулагдсан байдал | | Шийдэгдэ эгүй зөрүү | Хандив үзүүлсэн компанийн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | | Нэр | Тоо |
| 1 | Сангийн яам | 21,000.0 | 21,000.0 | | Энержи ресурс ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК | 2 |
| 2 | ГХЯам | 14,000.0 | 14,000.0 | | Мон полимет ХХК, Энержи ресурс ХХК | 2 |
| 3 | ЭБЭХЯам | 25,880.0 | 27,880.0 | (2,000.0) | Петрочайна дачин тамсаг ХХК, Бороо голд ХХК,Тэн хун ХХК,Чинхуа МАК нарийн сухайт ХХК ,Шанлун ХХК,Эй Пи И Экс Пи Ар Өү ХХК,Эрдэнэт үйлдвэр ХХК,МоЭнКо ХХК | 8 |
| 4 | Төрийн өмчийн хороо | 453,208.3 | 453,208.3 | | Шивээ Овоо ХК, Эрдэнэт үйлдвэр ХХК | 2 |
| 5 | АМГ | 10,800.0 | 10,800.0 | | Дун юань ХХК, МоЭнКо ХХК | 2 |
| 6 | Газрын тосны газар | 266,695.6 | 266,695.6 | | Зон Хэн Юу Тиан ХХК,Петро Матад ХХК,Петрочайна дачин тамсаг ХХК,Сансарын геологи хайгуул ХХК,Доншен Газрын тос ХХК,Шэйман ХХК,Эй Пи И Экс Пи Ар Өү ХХК,Эн Пи Ай ХХК,Магнай трейд ХХК,Голден сий петролиум ХХК,Гоби энержи партнерс ХХК,М Си Эс Петро Монголиа ХХК | 12 |
| 7 | МХЕГ | 213,799.2 | 213,799.2 | | Оюу Толгой ХХК | 1 |
| 8 | ХХҮГ | 5,879,999.0 | 5,879,999.0 | | Оюу Толгой ХХК, Тэн хун ХХК | 2 |
| 9 | Замын цагдаагийн ерөнхий газар | 1,500.0 | 1,500.0 | | Оюу Толгой ХХК, Чингисийн хар алт ХХК | 2 |
| 10 | Цагдаагийн ерөнхий газар | 31,000.0 | 31,000.0 | | Дун юань ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК | 2 |
| 11 | Шинжлэх ухааны академи | 33,500.0 | 33,500.0 | | Багануур ХК, Шивээ Овоо ХК, Энержи ресурс ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Шаоын гол ХК | 5 |
| 12 | Гадаадын хөрөнгө оруулалтын газар | 13,800.0 | 13,800.0 | | Зон Хэн Юу Тиан ХХК, Кью Жи Экс Монгол ХХК, Голден сий петролиум ХХК, Дун юань ХХК, Чинхуа МАК нарийн сухайт ХХК , Эй Пи И Экс Пи Ар Өү ХХК, Петро Матад ХХК | 7 |
| 13 | ГИХАЭГ | 60,234.7 | 69,762.7 | (9,528.0) | МоЭнКо ХХК,Оюу толгой ХХК, Саусгоби сэндс ХХК,Вестерн Проспектор монголия ХХК,Цайртминерал ХХК,Шинь шинь ХХК,Зон Хэн Юу Тиан ХХК,Капкорп Монголиа ХХК,Петрочайна дачин тамсаг ХХК | 8 |
| 14 | Монголын хөрөнгийн бирж | 17,534.5 | 17,534.5 | | Шивээ Овоо ХК, Энержи ресурс ХХК | |

| д/д | Хандив авсан байгууллагуудын нэр | Тохируулагдсан байдал | | Шийдэгдэ эгүй зөрүү | Хандив үзүүлсэн компанийн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | | Нэр | Тоо |
| | | | | | | 2 |
| 15 | Мэргэжлийн боловсрол сургалтын газар | 4,098,244.1 | 4,098,244.1 | | Оюу Толгой ХХК | 1 |
| 16 | Гаалийн төв лаборатори | 23,652.1 | 23,652.1 | | Эрдэнэт үйлдвэр ХХК | 1 |
| 17 | Нийслэлийн ЗДТГ | | 8,950.0 | (8,950.0) | Сод газар ХХК | 1 |
| 18 | Нийслэлийн автотээврийн газар | | 500.0 | (500.0) | АУМ ХХК | 1 |
| 19 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /1-р амаржих газар/ | 3,291,609.0 | 3,291,609.0 | | Бороо гоулд ХХК | 1 |
| 20 | Стандарчилал хэмжилзүйн газар | 1,000.0 | 1,000.0 | | Саусгоби сэндс ХХК | 1 |
| 21 | СБДүүрэг | 50.0 | 50.0 | | Чинхуа МАК нарийн сухайт ХХК | 1 |
| 22 | СХДүүрэг | 1,000.0 | 1,000.0 | | Гацуурт ХХК | 1 |
| 23 | Уул уурхайн аврах алба | 25,600.0 | 25,600.0 | | Шинь шинь ХХК, Төгрөг нуурын энержи ХХК, Рэдхил Монголиа ХХК, Тэн хун ХХК, Олон овоот гоулд ХХК | 5 |
| 24 | Хүүхэд асран хүмүүжүүлэх төв | 9,104.1 | 9,104.1 | | Пибоди винсвэй ресорсиз ХХК, Кежеговь ХХК | 2 |
| 25 | Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс | 400.0 | 400.0 | | Таац мөрөн ХХК | 1 |
| 26 | БГД-ийн 20-р хороо | 1,100.0 | 1,100.0 | | Дун юань ХХК, Гацуурт ХХК | |
| 27 | БЗД-ийн 4-р хороо | 193.0 | 193.0 | | Гурвантөхөм ХХК | 1 |
| 28 | МҮОНРТ | 356,800.0 | 356,800.0 | | Оюу Толгой ХХК, Цайртминерал ХХК | 2 |
| | **Дүн** | **14,851,703.6** | **14,872,681.6** | **(20,978.0)** | **-** | **74** |

**Тайлбар:** “Сод газар” ХХК-иас үзүүлсэн 8,950.0 мянган төгрөгийн хандив, дэмжлэгийг компанийн тохируулгын хүснэгтэд “Аймаг, нийслэл”-д өгсөн хандив, дэмжлэг хэсэгт тусгаж, шийдэгдээгүй зөрүү үлдсэн. Төр, засгийн байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгийн дээрхи хүснэгтэн мэдээллийн нийт дүн нь 8,950.0 мянган төгрөгөөр илүү байгаа болно.

**Компаниудаас орон нутгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг**

Анхны тайлан болон нэгтгэл тайлангийн явцад компаниудын зүгээс орон нутгийн захиргааны байгууллагад 12,072.5 сая төгрөгийн хандив, дэмжлэг үзүүлсэн гэж тусгаж өгсөний дагуу орон нутгийн байгууллагуудад хандахад 11,955.6 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг хүлээн авсан гэсэн хариу ирүүлж, 116.9 сая төгрөгийн зөрүү үлдсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт “П, Р”-с харна уу).

**(Мянган төгрөгөөр)**

| д/д | Аймгийн нэр | Тохируулагдсан байдал | | Шийдэгдэ эгүй зөрүү | Хандив үзүүлсэн компанийн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | | Нэр | Тоо |
| 1 | Архангай | 50,000.0 | 50,000.0 | - | Бэрэн майнинг ХХК | 1 |
| 2 | Баян-Өлгий | 7,050.0 | 8,250.0 | (1,200.0) | Казмон контакт ХХК, Геомин ХХК, Эрдэнэжас ХХК | 3 |
| 3 | Баянхонгор | 404,343.4 | 419,493.4 | (15,150.0) | Монголбалгоргео ХХК, Ододгоулд ХХК, Ханшижир ХХК, Андын тэмүүлэл ХХК, Жамп-Алт ХХК, Баялаг орд ХХК, Гоби коул энд энержи ХХК, Баяжмал-Алт ХХК, | 8 |
| 4 | Булган | 492,542.6 | 492,542.6 | - | ГБНБ ХХК, Тэнгри терра ресурс ХХК, Мон полимет ХХК, Монгол металл майнинг ХХК, Өрмөн-Уул ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК | 6 |
| 5 | Говь-Алтай | 154,611.7 | 161,162.3 | (6,550.6) | МоЭнКо ХХК, Алтайн хүдэр ХХК, Гоби коул энд энержи ХХК, Марко поло ХХК, Сод газар ХХК, Тэнгри терра ресурс ХХК, Самтон Морес ХХК, Гоби консолидетед ХХК | 8 |
| 6 | Говьсүмбэр | 88,769.0 | 88,769.0 | - | Шивээ Овоо ХК, Шинэ Шивээ ХХК, Эм Си Ти Ти ХХК, Оюу Толгой ХХК | 4 |
| 7 | Дархан-Уул | 34,160.3 | 36,664.3 | (2,504.0) | Шарын гол ХК, Эрэл ХХК, Дадизи юиан ХХК | 3 |

| д/д | Аймгийн нэр | Тохируулагдсан байдал | | Шийдэгдэ эгүй зөрүү | Хандив үзүүлсэн компанийн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | | Нэр | Тоо |
| 8 | Дорноговь | 1,199,536.6 | 1,200,036.6 | (500.00) | Казмон контакт ХХК, Монголросцветмет ХХК, Цайртминерал ХХК, Чингисийн хар алт ХХК, Эм Си Ти Ти ХХК, Эрэл ХХК, Монгол Ураниум Ресурс ХХК, Пибоди винсвэй ресорсиз ХХК, Монгол Алт Мак ХХК, Тайшэн девелопмент ХХК, Жи Эл Ди Ви ХХК, Шинэ шивээ ХХК, Сод газар ХХК, Кожеговь ХХК, Доншен Газрын тос ХХК, Баянтэгш импекс ХХК, Зараяа Холдингс ХХК, Бэрхресорсиз ХХК, Тэнгри терра ресурс ХХК, Зон Хэн Юу Тиан ХХК, Орчлон орд ХХК, Коммод ХХК | 22 |
| 9 | Дорнод | 474,347.7 | 479,827.7 | (5,480.0) | Монгол Алт Мак ХХК, Петро Матад ХХК, Петрочайна дачин тамсаг ХХК, Адуунчулуун ХК, Буман-Олз ХХК , Шинь шинь ХХК, Сентерра гоулд Монголиа ХХК, Дун-Эрдэнэ ХХК, Жамп-Алт ХХК, Эмээлт Майнз ХХК, Эн Пи Ай ХХК, Тэнгри терра ресурс ХХК, Зараяа Холдингс ХХК, Бороо гоулд ХХК, Шанлун ХХК | 15 |
| 10 | Дундговь | 104,700.0 | 108,422.7 | (3,722.7) | Монголросцветмет ХХК, Самтон Морес ХХК, Тайшэн девелопмент ХХК, Гоби коул энд энержи ХХК, Биг могул коул энд энержи ХХК, Эм Си Ти Ти ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Эрдэнэ жас ХХК, Монгол Алт Мак ХХК, Саусгоби сэндс ХХК, Ихмонгол майнинг ХХК | 11 |
| 11 | Завхан | 3,000.0 | 3,000.0 | - | Тэнгри терра ресурс ХХК, Самтон Морес ХХК | 2 |
| 12 | Орхон | 33,200.0 | 33,200.0 | - | Эрдэнэт үйлдвэр ХХК | 1 |
| 13 | Өвөрхангай | 172,047.5 | 172,047.5 | - | АУМ ХХК, Гацуурт ХХК, Баянтээг ХК | 3 |
| 14 | Өмнөговь | 4,557,806.9 | 4,583,595.1 | (25,788.2) | Хангад Эксплорэйшн ХХК, Оюу толгой ХХК, Саусгоби сэндс ХХК, Тавантолгой ХК, Ихмонгол майнинг ХХК, Чинхуа МАК нарийн сухайт ХХК, Энержи ресурс ХХК, Альшаахайрхан ХХК, Сод газар ХХК, ОНТРЭ ХХК, Мөнх ноён суварга ХХК, Си Си И Эм ХХК, АГМ майнинг ХХК, Олон Овоот гоулд ХХК, Терра-Энержи ХХК, Азиагоулд монголиа ХХК, Пибоди винсвэй ресорсиз ХХК, Дун юань ХХК, Болд фо ар да ХХК, Голден Гоби майнинг ХХК, Эрдэнэс МГЛ ХХК | 21 |
| 15 | Сүхбаатар | 627,682.5 | 627,682.5 | - | Петро Матад ХХК, Андын илч ХХК, Баян-Эрч ХХК, Өрмөн-Уул ХХК, Цайртминерал ХХК, Эрвэн хүдэр ХХК, Сод газар ХХК, Каскейд майнинг ХХК, Сентерра гоулд Монголиа ХХК, Монголжүюаньли ХХК, Бороо гоулд ХХК, Гоби эксплорейшн ХХК , Кожеговь ХХК | 13 |
| 16 | Сэлэнгэ | 2,377,705.2 | 2,419,420.1 | (41,714.9) | Ханшижир ХХК, Хунан жинлэн ХХК, Хурай ХХК, Рэдхил Монголиа ХХК, Болд төмөр ерөө гол ХХК, Бороо гоулд ХХК, Гацуурт ХХК, Шар нарст ХХК, Пенинсуламайнинг ХХК, Сонор трейд ХХК, Бүүргэнт ХХК, Казмон контакт ХХК, Жей Кей Эм Кей ХХК, Эрдэс холдинг ХХК, Тэнгри терра ресурс ХХК, Камейкс ХХК | 16 |
| 17 | Төв | 554,625.0 | 567,925.0 | (13,300.0) | Илтгоулд ХХК, Тэн хун ХХК, Анхай-Интернэшнл ХХК, Жей Кей Эм Кей ХХК, Эрдэнэ жас ХХК, Мондулаан трейд ХХК, Пибоди винсвэй ресорсиз ХХК, Төгрөг нуурын энержи ХХК, Гүнбилэг гоулд ХХК, Монголросцветмет ХХК, Мон полимет ХХК, Булган гангат ХХК, Буд-Инвест ХХК, Жотойн бажууна ХХК, Шижир алт ХХК, Монгол Алт Мак ХХК, Таац мөрөн ХХК, Гурвантөхөм ХХК | 18 |
| 18 | Увс | 101,432.4 | 101,432.4 | - | Хар тарвагатай ХК, Дацан трейд ХХК, Хотгор ХХК, Хотгор шанага ХХК, Монголросцветмет ХХК | 5 |
| 19 | Ховд | 281,113.0 | 282,043.0 | (930.0) | МоЭнКо ХХК | 1 |
| 20 | Хөвсгөл | 108,645.0 | 108,645.0 | - | Могойн гол ХК, Мон-Ажнай ХХК, Хургатай Хайрхан ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Гоби эксплорейшн ХХК | 5 |
| 21 | Хэнтий | 128,298.8 | 128,298.8 | - | Монголрудпром ХХК, Нордвинд ХХК, Бэрх-Уул ХХК, Лут чулуу ХХК, Айвуун тэс ХХК, Казмон контакт ХХК, Монголросцветмет ХХК, Жинхуа орд ХХК, Зө юу э ХХК, Баянтэгш импекс ХХК | 10 |
| | **Аймгийн дүн** | **11,955,617.7** | **12,072,458.1** | **(116,840.4)** | | **175** |
| | **Төр, засгийн байгууллаг дүн** | **14,851,703.6** | **14,872,681.6** | **(20,978.0)** | | |
| | **Нийт дүн** | **26,807,321.3** | **26,945,139.7** | **(137,818.4)** | | |

Тайлбар: “Сод газар” ХХК-ийн Нийслэлийн ЗДТГ-т өгсөн 8,950.0 мянган төгрөгийн хандиваар дутуу, Төр, засгийн байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэг нь уг дүнгээр илүү байгаа болно.

### 7.12 Нэгтгэл тайлангийн зөрүүний талаархи судалгаа

(сая.төг)

| д/д | Аудитын компанийн нэр | Он | Нэгтгэл тайланд хамрагдсан компанийн тоо | Анхны нэгтгэлийн зөрүү | Танилцуулсан байдал | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ажлын хэсэг | Үндэсний зөвлөл |
| 1 | Крейн Уайт энд Ассоушиэтс аудитын компани | 2006 | 25 | (96,826.9) | | 25,094.2 |
| 2 | Монгол улс, Малайз улсын Эрнст энд Янг аудитын компани | 2007 | 38 | (23,442.4) | | 775.0 |
| 3 | Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британи Умард Ирландын Вант улсын Харт Нойрс компанийн хамтарсан аудитын консерциум | 2008 | 46 | (47,148.9) | 8,523.4 | 431.0 |
| 4 | Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британи Умард Ирландын Вант улсын Харт Нойрс компанийн хамтарсан аудитын консерциум | 2009 | 101 | (265,507.7) | 143,400.0 | 58.2 |
| 5 | Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британи Умард Ирландын Вант улсын Харт Нойрс компанийн хамтарсан аудитын консерциум | 2010 | 150 | 11,133.2 | 426.5 | 0.358 |
| 6 | Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК, Их Британи Умард Ирландын Вант улсын Харт Нойрс компанийн хамтарсан аудитын консерциум | 2011 | 200 | 477,553.3 | 4,383.6[1]<br>339.6[2] | 74.6 |

[1]Ажлын хэсгийн анхны хуралдаанд танилцуулсан шийдэгдээгүй зөрүү
[2]Ажлын хэсгийн 2 дахь хуралдаанд танилцуулсан шийдэгдээгүй зөрүү

Хүснэгтээс харахад 2011 оны нэгтгэл тайлангийн анхны зөрүү хамгийн их дүнтэй байгаа нь харагдаж байна.

### 7.13 Орон нутагт төлсөн татвар, төлбөр, хураамж, хандив дэмжлэгийг аймаг бүрээр нь гаргасан судалгаа

Анхны ажлын хэсгийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу компаниудын зүгээс орон нутагт төлсөн татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийг аймаг бүрээр нь гаргаж тайланд оруулах тухай ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналын дагуу компаниудын орон нутагт төлсөн санхүүгийн урсгалуудыг аймаг бүрээр бүлэглэн, Хавсралт Р–д харуулсан.

Энэхүү хавсралтад нэгтгэлийн явцад ЗГ-ын байгууллагууд болон компаниудын зүгээс ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсон санхүүгийн урсгалууд тусгагдсан ба анхны тайланд хоёр талын дүн нь тохирсон санхүүгийн урсгалууд нь чухам аль аймагт төлөгдсөн санхүүгийн урсгал вэ гэдгийг нь тодруулах шаардлага байдаггүй тул зарим нэг санхүүгийн урсгал хавсралтад ороогүй байх магадлалтай.

## 8. Асуудал ба зөвлөмжүүд

ОУИТБС-ын шаардлага 17-ын дагуу бид ОУИТБС-ын нэгтгэлийн процессийг сайжруулах дараах зөвлөмжүүдийг өгсөн.

Өмнөх жилүүдийн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа тул эдгээр зөвлөмжүүдийг эргэн харахыг Ажлын хэсэгт санал болгож байна. Бидний үзэж байгаагаар, өмнөх жилүүдийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн бол, 6 дахь удаагийн нэгтгэл ажлын явцад үүсч бий болсон хэд хэдэн асуудлуудаас сэргийлэх боломжтой юм.

| д/д | Өгсөн зөвлөмж | Хэрэгжилт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Нэгтгэл тайланд хамрагдах компанийг сонгох талаар | Хэрэгжүүлээгүй | Олон тооны хайгуулын лиценз эзэмшдэг компаниудаас нэгтгэл тайланд оруулалгүй лицензээ бусдад шилжүүлсэн "Синчи-ойл", "Ээрмэл" зэрэг компанийг хамруулсан. |
| 2 | Зарим төлбөрийн дүнг анхны нэгтгэлд бүрэн хамруулах, заримыг хасах талаар | Хэрэгжүүлээгүй | Хураамж, үйлчилгээний хөлс нь ОУИТБС-ын нэгтгэл тайланд нөлөөлөх хэмжээний ач холбогдолтой санхүүгийн урсгал биш учраас нэгтгэлээс хасах талаар, орон нутгийн төсөвт төлсөн болон байршуулсан байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа, гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийг анхны нэгтгэлд нэгтгэж байх талаар зөвлөмж өгсөн. Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 8.5 тэрбум төгрөгийн төлбөр, 1.1 тэрбум төгрөгийн үйлчилгээний хураамж, 0.7 тэрбум төгрөгийн барьцаа, нийт 10.3 тэрбум төгрөгийн анхны зөрүү үүссэн. |
| 3 | Оюу Толгойн санхүүжилт | Хэрэгжүүлээгүй | 2009 онд 100 сая ам.долларын болон 2010 онд 50 сая ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлсөн урьдчилгааг Засгийн газар анхны нэгтгэлд тусгаагүй. ЗГ тайландаа эдгээр гүйлгээг оруулах ёстой ба Ажлын хэсэг нь жил бүр маягтуудын зохистой эсэхийг хянан үзэж, зохих өөрчлөлтийг хийж, сайжруулж байх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэнгүй. 2011 оны нэгтгэл тайланд 100 сая ам.долларын урьдчилгааг тусгаагүй байна. |
| 4 | Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлсөн урьдчилгаа төлбөрийг ОУИТБС-ын тайланд хамруулах тухай | Хэрэгжүүлээгүй | Монгол улсад хэрэгжих уул уурхайн томоохон төслүүдийн хувьд урьдчилгаа төлбөр хэлбэрийн мөнгөн урсгалууд гарах магадлалтай тул үүнийг ОУИТБС-ын тайланд оруулах эсэх дээр ажлын хэсэг тодорхой шийдвэр болон заавар, журам гаргах нь зүйтэй. |
| 5 | Орон нутгийн төсвийн орлогын бүртгэлийг сайжруулах талаар | Хэрэгжүүлээгүй | Төсвийн орлогын нэр төрлийг хооронд нь гүйлгэснээс шалтгаалан ЗГ-ын тайлангийн зарим татварын нэр төрөл буруу илэрхийлэгдэж, анхны зөрүү үүсэхэд нөлөөлж байна. Иймд төсвийн орлогын бүрдүүлэлт, түүний бүртгэлд тавих хяналт тавих механизмыг сайжруулах хэрэгтэй. |
| 6 | Хандив, тусламжийг бүртгэх журмыг хэрэгжүүлэх талаар | Хэрэгжүүлээгүй | СЯ-аас төвийн болон орон нутгийн төсвийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сургалт, семинар зохион байгуулж, цаашид журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаас гадна хэрэгжүүлээгүй Төр, засгийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтнуудад зохих арга хэмжээ авч байх нь зүйтэй гэсэн зөвлөмж хэрэгжээгүйгээс 18.8 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэгийн дүн ЗГ-ын анхны нэгтгэлд нэгтгэгдээгүй учраас анхны зөрүү үүсгэж байна. |
| 7 | ОУИТБС-ын тайлангийн чанарыг сайжруулах талаар | Хэрэгжүүлэх талаар ажилласан | Цаашид ирүүлсэн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулж байх, аудитор нь аудитлагдсан санхүүгийн тайланд нийцсэн гэдэгээ мэдэгдэхийг компаниудаас шаардаж байх. “Санхүүгийн тайлангийн тодруулга”-д ОУИТБС-ын маягтыг нэмэлт байдлаар оруулж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгч байсан гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Сангийн яаманд санхүүгийн тайлангийн тодруулгад ОУИТБС-ын тайланг хавсралт болгон оруулах санал өгсөн. Харин Сангийн яам нь тайлан давхардана, нүсэр болох учраас боломжгүй |

| д/д | Өгсөн зөвлөмж | Хэрэгжилт | Тайлбар |
|---|---|---|---|
| | | | гэсэн. |
| 8 | Маягтыг бөглөж ирүүлэх процедур ба маягтыг дэмжих дэлгэрэнгүй мэдээлэл | Хэрэгжүүлээгүй | ТЕГ нь холбогдох Төр, засгийн байгууллагуудаас, Санаачлагын ажлын алба нь компаниудаас ОҮИТБС-ын маягтаар тайланг авахдаа санхүүгийн урсгал тус бүрд тусгагдсан тоон үзүүлэлтийн бүтцийг дэлгэрэнгүй задаргаагаар гаргуулан авч, уг дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэл тайлангийн хавсралт болгон өгөх нь ажлыг хөнгөвчлөх, нэгтгэлийн ажлын чанар сайжрах, нэгтгэлийг богино хугацаанд явуулах ач холбогдолтой гэсэн зөвлөмж хэрэгжээгүй байна. |
| 9 | ОҮИТБС процессийг чиглүүлэх | Хэрэгжүүлээгүй | ЗГ-ын холбогдох байгууллагуудын систем нь мөн шаардлагатай мэдээллийг тогтмол боловсруулж байх хэрэгтэй. Одоогоор СЯ-ны нэрийн өмнөөс ТЕГ ЗГ-ын тайланг нэгтгэж, нэгтгэл тайланд хамрагдах компаниудыг сонгон, бэлтгэл ажлыг хийж байгааг бид ойлгож байна. Энэ процессийг автоматжуулах хэрэгтэй байна. |
| 10 | Төрийн үйлчилгээг ил тод болгох талаар | Хэрэгжүүлээгүй | Компаниуд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, түүний баялагийг зохистой ашиглах талаар хуулийн хүрээнд үйл ажиллагааг хэрхэн явуулж байгааг, төрийн байгууллагын аль шатанд хүнд суртал байгаа зэргийг ил тод болгох зэрэг зөвлөмж өгсөн. Харин хэрэгжилт нь тодорхойгүй байна. |
| 11 | ОҮИТБС-ын ажлыг олон нийтэд сурталчлах талаар | Хэрэгжүүлээгүй | Зарим нэгэн компани тайланг заавал гаргаж өгөх шаардлагагүй, наад ажил чинь бидэнд эргээд ямар үр дүнтэй вэ гэсэн асуултыг өмнөөс тавьж байгаагаас үзэхэд ОҮИТБС-ын ажлын албаны зорилго, зорилт, Монгол улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны цар хүрээг сурталчилан таниулаагүй байна гэж ойлгож болохоор байна. |
| 12 | Нэгтгэлийн тайлангийн зохион байгуулалтын талаар | Хэрэгжүүлээгүй | Ажлын хугацаанд ач холбогдол өгөөгүй. |
| 13 | Орон нутагт төвлөрүүлсэн зарим нэгэн төлбөрт хяналт тавих талаар | Хэрэгжүүлээгүй | Орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийг тус орон нутагт олборлох үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд буцаагаад авч байгаа эсэх, эсвэл уг барьцаа хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээж байгаа үгүйд хяналт тавьж тайланг ил тод болгосон нь харагдахгүй байгаа. |
| 14 | Мэдээлэл авах хэлбэрийг хялбарчилах талаар | Хэрэгжүүлээгүй | АМГ нь мэдээллийн баазыг хялбарчилах байтугай улам хүндрүүлж өгсөн. |
| 15 | ОҮИТБС-ын ажилд идэвхтэй оролцсон Төр, засгийн байгууллага болон компаниудыг сайшаах /магтах, өргөмжлөх/ талаар | Хэрэгжүүлээгүй | Компаниудад энэ арга хэмжээ мэдэгдэхүйц авагдсан бол энэ жилийн тайланд компаниудын хандах хандлага өөр баймаар байхад мөн л хойрго ханддаг хэвээрээ байлаа. |
| 16 | Тайланг удаа дараа гаргаагүй, нэгтгэл тайлангийн ажилд хойрго хандсан компаниудад арга хэмжээ авах талаар | Хэрэгжүүлээгүй | |
| | Орон нутгийн түвшний тайланд 9, үндэсний тайланд 16, нийт 25 зөвлөмж өгсөн. | | |

### 8.1 ОҮИТБС-ын нэгтгэл ажлын техник зөвлөмж

#### 8.1.1 Анхны зөрүүгийн шалтгаан

ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн ажил зургаа дахь жилдээ хийгдэж байгаа хэдий ч анхны нэгтгэлийн зөрүү буурахгүй байна. Аудитын консерциумаас анхны зөрүүний шалтгааныг тодорхойлоод цаашид зөрүү үүсгэхгүй байх талаар ажил хэрэгч зөвлөмжүүдийг өгдөг. Үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор уг зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гардаг.

Монголын ОҮИТБС-ын он оны нэгтгэлд ЗГ-ын тайлан болон компаниудын ирүүлсэн тайланг анх нэгтгэхэд томоохон хэмжээний зөрүү үүсдэг ба зөрүү нь ЗГ талдаа ч, компани талдаа ч үүсдэг. Доорх хүснэгтэд өмнөх нэгтгэлүүдэд үүсэж байсан анхны зөрүүг харуулав.

**(сая төгрөгөөр)**

| | **Он** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **2006** | **2007** | **2008** | **2009** | **2010** | **2011** |
| АМГ-т бүртгэлтэй лиценз эзэмшигч компанийн тоо | | | | | 1900 гаруй | 1840 |
| ОҮИТБС-ын тайлан гаргасан компаниудын тоо | 64 | 102 | 115 | 129 | 264 | 301 |
| Сангийн яамнаас гаргасан тайланд хамрагдсан компаниудын тоо | 137 | 184 | 184 | 363 | 478 | 518 |
| Монгол улсын нэгдсэн тайланд хамруулахаар Ажлын хэсгээс шийдвэрлэсэн компаниудын тоо | 25 | 38 | 46 | 101 | 150 | 200 |
| **Анхны зөрүү** | | | | | | |
| Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүн нь компанийн тайлагнасан дүнгээс их | 6,407.5 | 58,973.4 | 7,069.9 | 2,462,121.0 | 131,343.8 | 654,790.9 |
| Компанийн тайлагнасан дүн нь Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүнгээс их | (103,234.3) | (82,415.8) | (54,218.8) | (267,969.9) | (120,210.6) | (177,237.6) |
| **Нийт зөрүү*** | **109,641.8** | **141,389.3** | **61,288.7** | **270,432.0** | **251,554.4** | **832,028.5** |
| **Цэвэр зөрүү** | **(96,826.8)** | **(23,442.4)** | **(47,148.9)** | **(265,507.7)** | **11,133.2** | **477,553.3** |

*Уг зөрүү нь анхны нэгтгэлийн татварын төрлөөр гаргасан дүн юм.

Анхны нэгтгэл хийхэд зөрүү нь дараах зүйлсээс шалтгаалан үүсч байна. Үүнд:

- ЗГ нь хүлээн авсан томоохон төлбөрүүдийг анхны нэгтгэл тайланд тусгадаггүй.
- Он дамжиж төсвийн дансанд орсон дүнг дараа оны нэгтгэлд хамруулдаг. (Компани нь тухайн төлсөн хугацааны тайландаа тусгадаг).
- ЗГ уул уурхайн компаниудаас хүлээн авсан хураамж, үйлчилгээний хөлсийг нэгтгэл тайланд тусгадаггүй.
- Мөн ЗГ нь компаниудаас хүлээн авсан хандив, дэмжлэгийн дүнг анхны тайландаа бүрэн тусгаж нэгтгүүлдэггүй.
- ОҮИТБС-ын тайланд компаниуд хураамж, үйлчилгээний хөлс болон торгуулийн дүнг бүрэн хэмжээнд тусгадаггүй, нэгтгэл тайлангийн явцад нэмж буюу хасч тусгадаг.

- Орон нутгийн төсөвт төлсөн гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр, байгаль орчныг нөхөн сэргээх санд байршуулсан төлбөр зэргийг орон нутгийн засаг захиргааны байгууллага ЗГ-ын анхны тайланд тусгаж өгдөггүй.
- ОУИТБС-ын ажлын алба нь тайлангаа огт гаргаж ирүүлээгүй компаниудыг нэгтгэлийн тайланд хамруулдаг,
- Компаниуд бага хэмжээний төлбөрийг банкинд тушаахдаа компанийн нэрээр биш хувь хүн өөрийнхөө нэрээр төлдөг,
- Компанийн нэрээр төлбөр хийгдсэн боловч баримт нь байхгүй зэргээс шалтгаалан аль нэг талын тайланд тусгагдаагүйгээс болж зөрүү үүсч байна.

Ажлын хэсэг нь зөрүүгийн шалтгааны мөн чанарыг олж танин, компаниуд, ЗГ, орон нутгийн засаг захиргаа нь тайлангийн маягтыг үнэн зөв бөглөхөд анхаарал хандуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл ажлын хэсгээс тайлан мэдээний чанарыг дээшлүүлэх, анхны зөрүү үүсэх асуудлыг багасгах үүднээс ОУИТБС-ын маягтуудыг бөглөх болон тайланг нэгтгэхэд гардаг алдаа дутагдлыг багасгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хайгуулын лиценз эзэмшигч компаниуд ОУИТБС-ын тайланд уг төвлөрүүлсэн дүнг тусгаж, харин ЗГ талаас энэ дүнг хэрхэн нэгтгэж тайлагнах чиг үүрэг нь тодорхой бус учраас зөрүү үүсгэж байна. Энэ зөрүүг гаргахгүй байх үүднээс аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-аас АМГ-т нэгтгүүлдэг байх талаар ажлын чиг үүргийг нарийн тодорхойлж өгөх нь чухал байна.

Аймаг, сумын түвшингээс эхлээд ЗГ-ын түвшин хүртэл мэдээллийг нэгтгэх систем Засгийн газарт байхгүй байна. Түүнчлэн компаниас улсын түвшинд төлсөн зарим томоохон төлбөрийг Засгийн газар тайландаа тусгадаггүй нь анхны зөрүүг үүсгэж байна. Тухайлбал: Хайгуулын лиценз эзэмшиж байгаа компаниудын байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа, “Ашигт малтмалын тухай” хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр сум, дүүргийн төсөвт төвлөрүүлсэн дүнг тухайн аймаг, сум, дүүргийн ЗДТГ нэгтгэн ХХҮГ-т тайлагнаж байх талаар талуудын чиг үүрэгт тодорхой тусгаж өгч байх шаардлагатай байна.

СЯ нь эдгээр мэдээллүүдийг нэгтгэх зохистой системийг бүрдүүлж, уг тайланг бэлтгэх ажлын удирдамж нь талуудын ажил үүргийн хуваарьт тусгагдсан байвал зохино.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх барьцаа хөрөнгө, гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн бүрдүүлэлт болон зарцуулалтад хяналт тавьж, буцаагдаагүй нөхөн сэргээлтийн хөрөнгийг орон нутгийн орлогод татаж байх.

ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төвлөрсөн татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг зэрэг санхүүгийн урсгалыг нэгтгэхгүй байна. Энэ алдаа нь жил болгон давтагдаж байна. Эндээс харахад Засгийн газрын харъяаны зарим байгууллагууд өөрөөр хэлбэл татварын төв болон орон нутгийн байгууллагын хоорондын мэдээллийн солилцоо, нэгтгэл, түүнд тавих хяналт сул байгаа нь нотлогдож байна. Энэ нь зөрүүгийн хамгийн гол, цорын ганц эх сурвалж юм.

### 8.1.2 Орхигдсон орлого/төлбөр

“Оюу толгой” ХХК-ийн 100 сая ам.долларын буюу 125.4 тэрбум төгрөгийн төлбөрийг компани тайлагнасан боловч ЗГ анхны тайландаа тусгаагүй байсан.

“Оюу толгой” ХХК нь хөрөнгө оруулалтын гэрээний дагуу урьдчилгаа хэлбэрээр Сангийн яаманд 2012 оны 06 дугаар сарын 7-нд 100 сая ам.доллар буюу 125.4 тэрбум төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн тухайгаа нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэн.

Мөн “Эрдэнэс таван толгой” ХК-иас төлсөн хамтран ажиллах гэрээний урьдчилгаа хэлбэрээр ЗГ-т төлсөн 250 сая ам.долларыг хоёр тал аль аль нь анхны нэгтгэлд оруулаагүй байна.

Нэгтгэл ажлын цар хүрээнд төлсөн болон хүлээн авсан 2 талын орхигдуулсан төлбөр/орлогыг илрүүлж, баталгаажуулах ажил ороогүй бөгөөд ийм төлбөр, орлогууд нь илрэхгүй өнгөрч болох юм. Хэдий тийм ч энэхүү мэдээлэл нь олон нийтийн хэвлэл мэдээллээр цацагдсан бөгөөд энэ нь маргаангүй материаллаг дүнтэй учир олон нийтийн анхааралд байгаа юм.

Ажлын хэсэг нь Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Урьдчилгаа хэлбэрээр төлсөн төлбөрийг тайланд тусгах шинэ мөрийг тайландаа оруулж өгөх, иймэрхүү зүйлсийг төлөгч болон хүлээн авагч хоёр тал аль аль нь тайлагнасан болохыг тодорхой болгож байхыг зөвлөж байна.

ОУИТБС-ын тайлан нь мөнгөн сууриар бэлтгэгддэг. Иймээс Засгийн газарт компаниудаас урьдчилгаа хэлбэрээр төлсөн төлбөрийг хамруулах ёстой. Монголын ОУИТБС нь компаниудад зориулан удирдамж боловсруулах, Засгийн газрын агентлагууд иймэрхүү ажил гүйлгээг зохих хугацаанд нь тайлагнасан эсэхийг баталгаажуулах ёстой.

### 8.1.3 Нэгтгэл тайланд хамрагдах компанийг сонгох талаар

Нэгтгэл тайланд хамрагдах компаниудыг сонгохдоо АМГ-ын лиценз эзэмшигч компанийн мэдээлэлд үндэслэдэг байх. Өөрөөр хэлбэл тухайн онд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлт, ашиглаж буй лицензийн идэвхтэй байдал зэргийг ТЕГ нь өөрийн мэдээлэлтэй харьцуулан оновчтой зөв сонголтыг хийдэг байх. ОУИТБС-ын шаардлага 11-д тайлагнасан дүн ямарч тохиолдолд материаллаг бус байна гэдгийг компани тус бүрээр маш тодорхой харуулаагүй л бол бүх компани тайлан явуулах шаардлагатай. Энэ процессийг жил бүр явуулах шаардлагатай.
Түүнчлэн, Засгийн газрын эсвэл компаниудын тайлагнасан сайн мэдээлэлд тулгуурласан системтэй арга чухал юм. Үндэсний зөвлөл үүнийг авч үзэх шаардлагатай. Боломжит арга замууд нь:

a) Бүх компанийг тайлан ирүүлэхийг шаардах, мөн тухайн компани нь төлсөн төлбөрөө тайландаа тусгахаас гадна тухайн жилд нийт төлсөн төлбөр нь тогтоосон материаллаг түвшингээс бага бол бичгээр мэдэгдэх ёстой.
b) Сангийн яам нь Ашигт малтмалын газрын лиценз эзэмшигчдийн жагсаалтыг ашиглах, тэдгээс хүлээн авсан нийт төлбөрийг харуулсан бүх компанийн жагсаалтыг бэлтгэх шаардлагатай. Сангийн яамны анхны мэдээлэл дутмаг байгааг туршлага харуулж байгаа бөгөөд сайн нягтлах шаардлагатай.

### 8.1.4 Тодорхой бус тайлагналаас үүдэлтэй шийдвэрлэгдээгүй зөрүүнүүд

Компаниуд гадаад, дотоодын компаниудтай гэрээ хийсний үндсэн дээр зарим ажил, үйлчилгээг гүйцэтгүүлдэг байна. Гэрээнд өөрт ногдох орлогоос улс болон орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөр, хураамжийг хэрхэн төлөх талаар тодорхой тусгаж, тохиролцоогүйгээс шалтгаалан зарим зөрүү шийдвэрлэгдэхгүй тохиолдлууд гарч байна. Тухайлбал: бүх татвар, төлбөрийг гэрээлэгч компани хариуцахаар тохирч гэрээт компани татвар, төлбөр, үйлчилгээний хураамжийг гэрээлэгч компанийн нэр дээр (өмнөөс) шилжүүлсэн байна. Татвар, төлбөр, хураамжийг гэрээлэгч компани, гэрээт компанитай тухайн тайлангийн жилийн эцэст тооцоо нийлж, уг дүнг нягтлан бодох бүртгэлдээ бүртгэж, санхүүгийн тайландаа тусгаж, ОУИТБС-ын тайлангийн маягтын холбогдох дүнд оруулан тайлагнадаггүй байна.

Харин Засгийн газар тайландаа гэрээлэгч компанийн нэр дээр төлөгдсөн төлбөр, үйлчилгээний хураамжийн дүнг нэгтгэж, гэрээлэгч компани нь уг дүнг тайлагнаагүйгээс зөрүү үүссэн байна. Зөрүүг шийдвэрлэхээр тухайн компаниас лавлахад мэдэхгүй байх тохиолдол их гарч байна. Энэ асуудал бусад орнуудад бас үүсдэг ба бүрэн шийдвэрлэхэд хэд хэдэн үе шаттай арга хэмжээнүүдийг зүй зохистойгоор авах шаардлагатай. Гэрээлэгчдийг ОУИТБС-ын хамрах хүрээнд багтаах шийдвэр гарсан гэдгийг бид ойлгож байгаа. Үүний тулд гэрээлэгчдийг ОУИТБС-д хэрхэн багтаах талаар нарийвчилсан зөвлөмжийг өгсөн болно.

### 8.1.5 Ханшийн зөрүүний асуудлаас үүдэлтэй шийдвэрлэгдээгүй зөрүү

Компаниуд зарим төлбөрийг ам.долларoор шилжүүлсэнээс зөрүү үүссэн байна. Тухайлбал: Засгийн газар төлбөр хүлээн авсан өдрийн ханшаар, шилжүүлсэн компани шилжүүлгээ хийсэн өдрийн ханшаар нягтлан бодох бүртгэлдээ тусгаснаас валютын ханшийн зөрүү гарч, энэ нь анхны нэгтгэлийн зөрүүнд нөлөөлөхөөс гадна Монгол улсын “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хууль хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

Гадаад валютаар хийсэн гүйлгээг ОУИТБС-ын зорилгоор тухайн гадаад валютаар бүртгэлд тусгах нь хамгийн сайн шийдэл юм. Засгийн газар гадаад валютаарх дүнг төгрөгөөрх дүнтэй хамт тусгах шаардлагатай. Гэвч энэ нь Засгийн газрын бүртгэлийн системд өртөг өндөртэй бөгөөд тохируулахад хүнд томоохон өөрчлөлт хийх шаардлагыг бий болгож байна.

Бас өөр нэг шийдэл /сайн биш/ бол ажлын хэсэг төлбөр төлж байгаа компаниудыг тайлангийн маягтанд 2 валютаар тодорхойлон, төгрөгтэй адил хэмжээгээр бөглөхийг шаардах. Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн төгрөгөөрх дүнгийн зөрүүг тухайн компаний мэдүүлсэн дүнтэй тохируулах, зөрүү гэж харуулахгүй байх шаардлагатай.

### 8.1.7 ОУИТБС-ын тайлангийн маягтны үзүүлэлтийн талаар

ОУИТБС-н шаардлага 9-д Үндэсний зөвлөл материаллагийн түвшинг тогтоох, тайлангийн маягтыг тохиролцох талаар тусгасан. Шаардлага 9 (b)-д Үндэсний зөвлөл тохиромжтой материаллагийн түвшинд хүрэх сонголтыг авч үзэж, баримтжуулахыг шаардсан байна. Хэрэв түүнийг хасах эсвэл тайланд тусгахгүй байснаар ОУИТБС-ын эцсийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхээр бол орлогын урсгал материаллаг байна.

Үндэсний зөвлөл уг асуудлыг 2010 онд авч үзээд, шийдвэрийг гаргасан.

ОУИТБС-ын 5 ба 6 дахь нэгтгэл тайлангийн туршлагаас авч үзвэл, тайлангийн маягтанд ямар үр ашигтай урсгалыг оруулах талаарх шийдвэрийг Үндэсний зөвлөл нягтлах хэрэгтэй гэж бид зөвлөсөн. Энэ асуудлыг авч үзэх нь ОУИТБС-ын тайлангийн үндсэн зорилгод голлон анхаарах шаардлагатай ба тухайлбал ядуурлыг бууруулах, эдийн засгийг хөгжүүлэх талаар иргэдэд өгөөжтэй байхад үндэслэх шаардлагатай.

Нэгтгэл тайлангийн зорилгод онцгой ач холбогдолгүй жижиг хэмжээний татвар, төлбөр, хураамжууд тайланд хамрагдсан. Иймд тайлангаас зарим төрлийн татвар, төлбөр, хураамжийг ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангаас хасахийг санал болгож байна. Ингэснээр тайлангийн хэмжээ багасаж, гол санаанд чиглүүлэхэд хялбар болно. Энэ нь тайланд нөлөө үзүүлэхгүй харьцангуй жижиг дүнг тайлагнах, нэгтгэхтэй холбоотой Засгийн газар болон компанийн дарамтыг багасгах болно.

ОУИТБС-ын маягтын зарим санхүүгийн урсгалын ангилал болон үзүүлэлт нь ойлгомжгүй байна. Тухайлбал маягтын 1.1.9-1.1.12, 1.1.13 дугаар мөр болон 2.2.7 дугаар мөрний санхүүгийн урсгал нь ангилал буруу байна. Мөн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлсөн урьдчилгаа төлбөрийн дүнг тусгах мөр байхгүйгээс ЗГ болон компани аль аль тал нь уг төлбөрийн дүнг тайланд тусгаж, нэгтгэхгүй зөрүү үүсгэж байна. Иймд татвар, төлбөр, хураамжийн ангилал нь татварын хуулийн ангилалтай зохицохгүй байгааг анхааралдаа авч ОУИТБС-ын маягтыг зөв ангилалд нь залруулахыг зөвлөж байна.

### 8.1.8 Хандив, тусламжийг бүртгэх бодлого, журмын мөрдөлт

Засгийн газрын байгууллагууд нь 2010 онд Сангийн сайдын 45 тоот тушаалаар батлагдсан “Хандив, тусламжийг бүртгэх тухай” журмын талаар бүрэнойлголтгүй бөгөөд уг журмыг дагаж мөрддөггүй. Өнгөрсөн жил уг журмыг дагаж мөрдөх талаар өгсөн зөвлөмжтэй холбогдуулан тодорхой үүргүүдийг Засгийн газрын байгууллагуудад өгөөгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах ажиллагаа явагдаагүй, үүнээс үүдэн хандив, тусламжтай холбоотойгоор зөрүү гарсаар байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг шинэчлэх, Сангийн сайдын 2010 оны 45 тоот тушаалаар батлагдсан “Хандив, тусламжийг бүртгэх” журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах. Зургаа дахь удаагийн нэгтгэл ажил нь зохих горимуудыг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Энэ журамд мөнгөн бус хандивыг Засгийн газрын бүртгэлд зах зээлийн үнээр эсвэл өртгөөр бүртгэх талаар тусгасан. Энэ 2 тоон үзүүлэлтийн субьектив байдлаас болоод энэ хангалтгүй юм. Энэ нь компанийн мэдүүлсэн дүн Засгийн газрын бүртгэсэн дүнтэй тохирох баталгаа болж чадахгүй. Түүнчлэн бид нар мөнгөн бус хандивыг бүртгэсэн дүн нь компанийн өртгөөс давах ёсгүй байх талаар нэмэлт журам гаргахыг зөвлөж байна. Компани болон хүлээн авагч байгууллага хоорондоо энэ дүнг тохиролцох ёстой ба хандивыг компаниас хүлээн авагчид шилжүүлсэн өдөр бичгээр тохиролцох ёстой.

### 8.1.9 АМГ-ийн лизензийн мэдээлэл дэх алдаатай байдал

Бид “Синчи-Ойл”, “Ээрмэл” зэрэг ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамрагдсан компаниудад тодорхой мэдээлэл гаргаж өгөх хүсэлтийг тавьсан. Гэвч эдгээр компаниуд нь олборлох үйл ажиллагаа эрхлэн явуулдаггүй, үйл ажиллагааны чиглэл өөр зэрэг шалтгаанаар бидний хүссэн мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзаж байсан ч тусгай зөвшөөрлийг шилжүүлэх баримт материалаа АМГ-т 2011 онд өгсөн, шилжилт хөдөлгөөн нь 2012 оны эхээр хийгдсэн тухай мэдээллийг АМГ-аас авч, дахин компаниуд руу хандаж, энэ байдлыг тайлбарласны эцэст холбогдох мэдээллийг гаргуулан авч, тохируулгыг хийж зөрүүг шийдвэрлэсэн.

“Синчи-ойл” ХХК нь 2007 оны үед ашиглалтын нэг лицензтэй байсан, уг лицензийг тэр ондоо өөр хуулийн этгээдэд шилжүүлсэн, “Ээрмэл” ХХК нь хайгуулын нэг лицензтэй байсан 2010 онд хугацаа нь дууссан гэсэн тайлбаруудыг өгч байхад АМГ-аас ирүүлсэн лицензийн судалгаанд тус хоёр компани нь ашиглалтын болон хайгуулын нэг нэг лиценз эзэмшиж байгаагаар мэдээлэгдэж байгаагаас харахад АМГ нь лицензийн хөдөлгөөнийг үнэн зөв, бүрэн гүйцэд хийж байгаа эсэх нь, эсвэл тус компаниуд нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 49-р заалтын дагуу ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх болон хүчингүйд тооцуулахад шаардлагатай бичиг баримтыг цаг хугацаанд нь бүрдүүлж өгч чадсан эсэх нь тодорхой бус байсан.

Бид АМГ нь бүх лицензүүд нь байгаа эсэх, тухайн лицензийн огноо нь үнэн зөв эсэх зэргийг шалгаж мэдээллийн баазаа цэгцлэхийг зөвлөж байна.

Дүрэм журмын дагуу бус шилжүүлсэн лицензтэй холбоотой асуудлыг хуулийн дагуу арга хэмжээ авахыг Ашигт малтмалын газарт бид зөвлөж байна. Ашигт малтмалын газарт өөрчлөлтийг бүртгүүлэх хүртэл шилжүүлэгч тал лицензтэй холбоотой болон ОУИТБС-ын албанд тайлан хүргүүлэх бүх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Ашигт малтмалын газарт өөрчлөлтийг бүртгүүлсэнээр тус компани үүрэг харицлагаас чөлөөлөгдөнө. Бүртгэл зөв хийгдээгүй бол Ашигт малтмалын газраас тус лицензийн шилжүүлэлтийг хүчин төгөлдөр бус гэж олон нийтэд мэдэгдэх шаардлагатай ба хүлээн авагч хуулиас гадуур үйл ажиллагаа явуулж байгаад тооцогдоно.

### 8.1.10 Нэгтгэл ажлын хүрээнд гэрээлэгчдийг оролцуулах

2011 оны нэгтгэлд гэрээлэгчийг оруулах шаардлагатай гэсэнд 2012 онд Засгийн газрын шийдвэр гарсан. Энэ шийдвэр олборлох үйлдвэрлэлийн салбарт цогц байдлыг бий болгох боломжтой. Гэсэн хэдий ч Үндэсний зөвлөл дараах асуудлыг шийдвэрлэхгүй бол эргэлзээ үүснэ. Үүнд:

а) ОУИТБС-ын тайланд бүх гэрээлэгч орох эсэх талаар Үндэсний зөвлөл нарийн авч үзэх шаардлагатай.

b) Үндэсний зөвлөл орохгүй гэрээлэгчдийг яаж тодорхойлж, ялгах талаар Төрийн байгууллагуудад зааварчилгаа гаргаж өгөх шаардлагатай.
c) Төрийн байгууллагууд төлбөр хүлээн авсан компанийн нэрийг тодорхой бүртгэх шаардлагатай. Лиценз эзэмшигчтэй холбоотой төлбөрийг гэрээлэгч төлсөн байвал Засгийн газар авч үзэх шаардлага байхгүй.
d) Өөр компанийн өмнөөс төлсөн төлбөрийг тусад нь харуулах боломжийг компанид олгохын тулд компанийн тайлангийн маягтыг өөрчлөх шаардлагатай.

### 8.2 Нэгтгэл ажлын удирдлагыг сайжруулах зөвлөмжүүд

#### 8.2.1 ОУИТБС-ын тайлагналын урсгалын шаардлага

Зарим компаниудын нягтлан бодогч солигдсон шинээр орсон нягтлан бодогч нь өмнөх нягтлан бодогчийнхоо ажлыг мэдэхгүй энэ ажлыг хийх зав байхгүй хэмээн цааргалан мэдээлэл өгөхөөс татгалзах явдал ихээр тохиолдож байна. Мөн хайгуулын лиценз эзэмшигч ихэнх компаниудын нягтлан бодогч нь жилийн жилд өөрчлөгддөгөөс шалтгаалан ЗГ-ын болон ОУИТБС-ын тайланд тусгагдсан дүнг төлсөн төлөлт бүрээр дэлгэрэнгүй задаргаа гаргаж өгч мэдэхгүй, анхан шатны баримтыг нь олохгүй байна, энэ ажлыг хийх завгүй байна гэх зэргээр шалтгаан тоочиж  бидний ажилд хүндрэл учруулж байлаа.

“Петро чайна дачин тамсаг” ХХК нь туслан гүйцэтгэгч компани олонтой, мөн жил болгон л ийм мэдээлэл авч байх юм, Манай компани гаргаж өгч чадахгүй хэмээн татгалзсан хариу бидэнд ирүүлж цаг хугацаа ихээхэн алдуулж байсаны эцэст үүсээд байсан томоохон зөрүүнд тайлбар гаргаж өгсөн.

Мөн Газрын тосны газарт төлсөн төлбөрүүдээ ам.долларoор төлсөнөө санаачлагын албанд гаргаж өгсөн тайландаа төгрөгт хөрвүүлэн тайлагнаагүй нь Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулинд заасан “Бүртгэлийн үзүүлэлтийн нэгжийг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Нэгтгэл тайлангийн Ажлын даалгаврын дагуу бид холбогдох хавсралтуудыг бэлтгэж компаниудад хүргэсэн. Зарим компаниуд бүх шаардлагатай хавсралтуудыг бөглөж ирүүлээгүй. Зарим нягтлан бодогч нар татвар, төлбөр, үйлчилгээний хураамжийн төлөлт, СТОУС-ын хэрэгжилт зэргийг хагас дутуу бэлтгэж өгөөд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ, уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа, компанийн ерөнхий мэдээлэл зэрэг хавсралтуудыг огт ирүүлдэггүй, дахин нягтлан бодогчид хандахад иймэрхүү мэдээллийг геологичдоос ав гэх мэтээр хариу өгч байлаа. Үүгээр компаниуд нь ОУИТБС-ын нийцлийг системтэйгээр зохион байгуулахгүй байгаа нь харагдаж байна. Компани бүр ОУИТБС-д олон төрлийн тайланг бэлтгэн, танилцуулах нэг хүнийг томилж, Ажлын хэсэгт тухайн томилогдсон хүний нэр, албан тушаалыг мэдээлж байх ёстой.

Төр, Засгийн байгууллагын хувьд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай харьцахад бэрхшээлтэй байсан.

Ашигт малтмалын газраас лицензийн төлбөр болон үйлчилгээний хураамжийн талаар мэдээлэл авахыг хүссэн албан бичиг илгээж, холбогдох мэргэжилтэнтэй холбогдсон. Хэдий тийм ч АМГ нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын мэдээлэл бус, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч АМГ-т бүртгэлтэй бүх компанийнхаа мэдээллийг  электрон файлаар бидэнд ирүүлсэн..

Зарим компанийн нэрийг Монголоор өөр өөрөөр бичсэн, гүйлгээний утга нь тодорхой бус гэх мэтийн хүндрэлтэй байсан.

Дээрхээс засгийн газрын зарим байгууллагууд нь ОУИТБС-ын үйл ажиллагааг дэмждэггүй, Ажлын хэсгийн тодорхойлсон үйл ажиллагаанд нийцүүлэхгүй байхыг илүүд үздэг гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

#### 8.2.2 ОУИТБС-ын тайлагналд хойрго ханддаг байдал

Нэгтгэл тайлангийн явцад үүссэн зөрүүг шийдвэрлэх зорилгоор компаниудад хандахад ОУИТБС-ын ажлын албанд саяхан гаргаж өгсөн, нэг ажлыг хоёр удаа хийлгэж байна гэх зэрэг шалтгаанаар асар их хойрго ханддаг.  Тухайлбал албан бичгийн хариуг өгөлгүй ихээхэн цаг алдуулж байсан “Хүдэн, “Ээрмэл”, “Марко поло”, “Жем интернэйшнл”, “Бату майнинг монгол”, “Болд төмөр ерөө гол”, “Алтандорнод монгол”, “Бумбат”, “Тиенжинсанжо”, “Синчи-Ойл” зэрэг компаниуд байна.

Гэрээт нягтлан бодогч ажиллуулдаг компаниуд нь цаг хугацаа хожимдуулах асуудлаас сэргийлэхийн тулд тухайн нягтлан бодогчдоо компанийн нягтлан бодох бүртгэлтэй холбогдох баримт, бичгүүдийг ямар нэгэн онцгой зөвшөөрөлгүйгээр толилуулах эрхийг өгч байх хэрэгтэй байна.

“Гүнбилэг трейд”, “Гүнбилэг гоулд”,  “Эм Ар Си Эм Жи Эл”, “Броад”, “Биг могул коул энд энержи” зэрэг компаниуд нь дараах асуултуудыг тавьж байсан.

- танай байгууллагын статус зохистой биш,
- энэ тайланг заавал өгөхийг аль хууль, журманд заасан байдаг вэ,
- тайлан өгөхгүй бол ямар нэгэн хариуцлага тооцно гэсэн хууль эрх зүйн акт байна уу,
- хэрвээ байгаа бол тэр хууль эрх зүйн актаа явуул, тэр цагт өгөх эсэхээ шийднэ гэж байсан.

Эдгээр компаниуд мэдээлэл цуглуулж, зөрүүг тодруулах ажлыг удаашруулах хандлагатай байсан. ОУИТБС-ыг үл тоомсорлох, ОУИТБС-ын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан хариу үйлдэл үзүүлж байсан. Дараа дараагийн жилүүдэд дараах зүйлсийг хийхийг зөвлөж байна. Үүнд:

1. Ажлын хэсэг нь нэгтгэл тайланд хамрагдсан бүх компаниудад тухайн нэгтгэлийн ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэхээр сонгогдсон байгууллагын талаар мэдээлж байх,
2. Ажлын хэсэг нь Монголын ОУИТБС-ын цахим хуудсан дээрээ энэ талаар нийтэлж байх,
3. Цааш цаашдаа дээрх шиг хариу үйлдэл үзүүлсэн компаниудыг ОУИТБС-ын ажлын албанд ирэхийг урьж, ОУИТБС-ын үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл өгч байх,
4. Ажлын хэсэг нь ОУИТБС-ын дүрэм 7 болон 11-ийн дагуу компаниудыг олон хэлбэрээр, цаг хугацаандаа тайлагнаж байхыг хуульчилан заах.

Бид өмнө нь (ОУИТБС-ын 5 дахь удаагийн нэгтгэл тайлангийн зөвлөмж 9.8) компаниуд нь ажил гүйлгээг бөөн дүнгээр биш тус бүрийг дэлгэрэнгүй байдлаар тайлагнаж байхыг зөвлөсөн. Ажлын хэсэг нь уг зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хэрэв хэрэгжүүлсэн бол цаг хугацаа алдах хүндрэл бэрхшээл багасах байлаа.

**8.2.3 Компаниудын санал гомдлын талаар**

Нэгтгэл тайлангийн явцад ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн ажил хийгдэж байгаа талаар өмнө нь нэгтгэлд хамрагдаж байгаагүй компаниудын удирдлага болон нягтлан бодогч, геологич нарт танилцуулах болдог. Энэ ажил нь Ажлын хэсгийн үүрэг бөгөөд шинэ компанийг сонгохдоо Ажлын хэсэгт багтсан компанийн төлөөлөгчдөд ОУИТБС болон нэгтгэлийн үйл ажиллагааг тайлбарлаж байх нь зүйтэй.

Зарим компанийн удирдлагууд ОУИТБС-ын үйл явцын талаар гомдол гаргаж байсан. Тухайлбал:

- Компанийн удирдлага нь олон төрлийн судалгаа, тайлан, мэдээг янз бүрийн сувгаар авах юм, энэ тоон мэдээнд үндэслэн ямар нэгэн дүгнэлт гаргаж, биднийг дэмжсэн бодлогын чанартай аливаа нэгэн ажил хийгдэхгүй байна.
- Компаниуд ил тодын тайланг цаг хугацаанд нь гаргаж өгсөн, нэгтгэл тайлангийн явцад нэгтгэлийн ажлыг гүйцэтгэж буй аудитын консерциумд хүссэн мэдээллийг хурдан шуурхай гаргаж өгч, тайлагнасан мөн тайланд тусгагдсан дүнгийн зөрүү шийдвэрлэгдээгүй компаниудад ямар арга хэмжээ авч байгаа нь мэдрэгдэхгүй ил тод бус байна гэсэн санал, шүүмжлэл тавьж байлаа.

Компаниудын хүсэлтийг бодолцож Ажлын хэсэг нь ОУИТБС-ын нэгтгэл ажилд идэвхтэй оролцдог болон оролцдоггүй компаниудын нэрийг албан ёсны цахим хуудсандаа нийтлэх нь зүйтэй байна.

**8.2.4 Нэгтгэл тайлангийн ажил цаг үеэ олоогүй талаар**

Анхны нэгтгэлийн зөрүүг шийдвэрлэх зорилгоор 8 дугаар сарын 14-нөөс компаниудад албан бичиг хүргэж эхэлсэн. Энэ үед ихэнх компанийн удирдлагууд нь хөдөө уурхай дээрээ ажиллаж байсан учраас гар утас нь холбогдох боломжгүй, нягтлан бодогч нар нь ээлжийн амралтаа авсан мөн эмчилгээ сувилгаанд явцгаасан, орлож байгаа хүн нь компанийн геологич, нярав гэх мэт хүмүүс байсан нь мэдээлэл авах боломжгүй болж, цаг хугацаа их алдаж, бидний ажлын гэрээний хугацаа зөрчигдөхөд хүрсэн. Нэгтгэл тайлангийн ажлын цаг үе нь олборлох үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын ажлын улиралтай давхцаж байсан нь ажлын цагийн хуваарилалтыг бодит бус болгоход нөлөөлсөн.

ОУИТБС-ын 6 дахь удаагийн тайлан буюу нэгтгэл тайлангийн ажлыг зуны улиралд хийх нь компаниудын ид ажлын цаг үетэй давхцаж байсан нь үүссэн зөрүүг тохируулах, зөрүүний шалтгааныг тайлбарлахад ихээхэн хүндрэлтэй байсныг дурьдах нь зүйтэй болов уу. Ийм учраас нэгтгэл тайлангийн ажлыг дараа оны 3 дугаар сараас эхэлдэг болгохыг зөвлөж байна. Оролцогч компаниудын тоо жилээс жилд өсч байгаатай холбогдуулан нэгтгэл тайлангийн ажлыг гүйцэтгэх хугацааг нэмэгдүүлэх. Богино хугацаа нь нэгтгэлийн ажлын чанарт нөлөөлж байна. Иймээс нэгтгэл ажлыг гүйцэтгэх хугацааг 13 долоо хоногоос багагүй байхаар сунгахыг зөвлөж байна.

Бид нэгтгэл ажлыг зуны баяр, наадамаас өмнө дуусгах зорилгоор тухайн жилийн 3 дугаар сараас оройтолгүй эхлүүлэхийг зөвлөмж байна. Ажлын хэсэг нь үүний дагуу худалдан авалтын журмыг өөрчлөх хэрэгтэй.

**8.2.5 Компаниуд мэдээллийг буруу бэлтгэдэг талаар**

Нэгтгэл тайлангийн явцад компаниудын гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд алдаа, дутагдлууд гарч байна. Тухайлбал,

- үйлчилгээний хураамж болон хандив дэмжлэгийг хүлээн авсан Төрийн захиргааны байгууллагын нэрийг буруу бичих,
- бүтнээр биш товчилж бичих, эсвэл ижил төстэй статустай байгууллагыг хооронд нь андуурч сольж бичих зэрэг зөрчил дутагдал их гаргадаг.

Энэ байдал нь компаниуд руу дахин дахин хандаж цаг хугацаа их алддаг, мөн үйлчилгээний хураамж болон хандив, дэмжлэгийн дүнг тохируулах зорилгоор компаниас ирүүлсэн байгууллагын нэрээр албан бичиг хүргүүлэхэд нөгөө газраас манайд хамааралгүй төлбөр болон хандив, дэмжлэг байна гэсэн хариуг өгдөг, ийм тохиолдолд компанид дахин хандахад өмнөх мэдээлэлд нэр андуурсан байна гэж залруулж өгөх зэргээр түвэг учруулж байна.

### 8.2.6 ОУИТБС-ын оролцооны үнэлгээ

Жилийн ОУИТБС-ын нэгтгэл ажлыг үр дүнтэй явуулахын тулд компаниудыг нэгтгэл тайланд оролцсон оролцоог үндэслэн сайшаан шагнах, шилдэг компанийг шагнаж, урамшуулах, зохистойгоор нийтэд мэдээллэхийг зөвлөж байна. Нөгөө талаар хангалтгүй оролцоо бүхий компаниудын нэрийг мөн олон нийтэд мэдээллэх хэрэгтэй.

### 8.2.7 ОУИТБС-ын тайланг нийтлэх ажлыг боловсронгуй болгох талаар

ОУИТБС-ын ажлын алба нь санхүүгийн болон албан ажлын хэрэглээний программ зохиодог байгууллагыг судалж, ОУИТБС-ын тайланд тохирсон санхүүгийн программтай болох нь зүйтэй байна.

Монголын ОУИТБС-ын нэтгэл тайланд хамрагдаж буй компанийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаатай холбогдуулан нэгтгэл тайлан хавсралтын хамт маш олон хуудас болж, хэрэглэгчид ашиглахад түвэгтэй байдал үүсч байхыг үгүйсгэхгүй. Иймд аудитын консерциум нь нэгтгэл тайлангийн ажлыг дуусгаад тайланг хэвлэхдээ зөвхөн тайлан хэсгийг хэвлэж, хавсралтуудыг онлайн эсэл CD дээр буулгаж электрон хэлбэрээр тараах нь зүйтэй байна.

### 8.2.8 АМГ-ын мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах талаар

АМГ мэдээлэл авахад компанийн регистрийн дугаараар төлбөрийг нягтлан бодох бүртгэлдээ тусгаагүй, компанийн нэрээр буюу харилцагчаар тусгасан нь мэдээлэл авахад хүндрэлтэй байна. Мөн нягтлан бодох бүртгэлд гадаад нэртэй аж ахуйн нэгжүүдийн нэрийг буруу тусгаснаас компанийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн ирүүлэхэд хүндрэлтэй байсан. Ийм учраас АМГ нь компаниудаас төлсөн лицензийн төлбөр болон үйлчилгээний хөлсийг нягтлан бодох бүртгэлдээ тусгахдаа компанийн регистрийн дугаараар оруулах нь хоёр талын ажлыг хөнгөвчлөх сайн талтай байх талаар өнгөрсөн жилийн нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийг АМГ нь хэрэгжүүлээгүй нь ажлын үр дүнг бууруулахад нөлөөлж байна.

### 8.3 Олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиглагдсан бусад асуудлууд

### 8.3.1 Байгаль орчны нөхөн сэргээлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Монгол улсад байгаль хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой нэлээд хууль тогтоомж, дүрэм журам (жагсаалтыг Хавсралт “Т”-с харна уу) үйлчилдэг боловч уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд сөрөг нөлөөлөл байсаар байна. Компаниудын Байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлын зардлын тооцоолол нь газар дээрээ хийгдэх ажилтай хэрхэн уялдаатай байгааг шалгаж баталгаажуулдаг байх, байгаль хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгө нь бодит гүйцэтгэлээр гарах зардалтай хэрхэн уялдаж байгаад дүн шинжилгээ хийх шаардлага байгаа нь харагдаж байна. Уг тайланд компаниуд тухайн орон нутгийн засаг захиргааны тусгай дансанд байршуулах урьдчилгаанаас зайлсхийх зорилгоор төлөвлөлт (бага үнийн дүн), түүний гүйцэтгэл (том үнийн дүн) хооронд маш том хэмжээний зөрүү байгааг харуулж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийг орон нутгийн иргэний нийгмийн бүлгүүд хэлэлцэж, ил тод болголтыг сайжруулах хэрэгтэй.

### 8.3.2 Уул уурхайн НББ-тэй холбоотой санхүүгийн хариуцлагыг сайжруулах

НББОУС 37-Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө стандартад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой өр төлбөрийг хэрхэн бүртгэх талаар удирдамжийг өгсөн байдаг. Үүнтэй холбоотойгоор Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх тухай” журамд байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөцийг байгуулах талаар заасан байдаг. Гэвч СТОУС-ын судалгаанд хамрагдсан 176 компанийн 40.9 хувь нь ямар нэгэн нөөц байгуулдаггүй, 24 компани энэ талаар хариулт өгөхөөс татгалзсан байна.

Ашиглалтын хугацаа дуусаад уурхайг хаах үед нөхөн сэргээлттэй холбоотой нилээд материаллаг хэмжээний зардал гардаг тул компаниуд үүнтэй холбоотой нөөцийг анх уурхайг ашиглаж эхлэх үед байгуулах боломжтой юм. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээлт, уурхайн хаалттай холбоотой тооцоолсон ирээдүйн зардлуудын өнөөгийн үнэ цэнийн дүнг тооцоолон, тооцоолсон зардлыг уурхайн ашиглах хугацаанд хувь тэнцүүлэн эсвэл борлуулалттай уялдуулан зардалд шингээж, нөөцийн сан байгуулах замаар хугацааны эцэст хуримтлал үүсгэх ба үүсгэсэн хуримтлалаар уурхайг хаах, нөхөн сэргээх зардлыг санхүүжүүлэх явдал юм. Уурхайг хаах үед компани нь уурхайг хаах, байгаль орчныг нөхөн сэргээх хангалттай хөрөнгөтэй эсэхийг зохицуулсан тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Жишээлбэл: Уурхайн ашиглаж эхлэх үеэс компаниудын тооцоолж, тухайн жилд байгуулсан нөхөн сэргээлтийн нөөцийн дүнгээр Байгаль орчны яамны тусгай дансанд баталгаа хэлбэрээр мөнгөн хөрөнгийг жил бүр төвлөрүүлэн авдаг байх, эсвэл компаниуд өөрсдөө нөөцийн дүнгээр тусгай дансыг бий болгон мөнгөн хөрөнгийг төвлөрүүлдэг байх, ямар нэгэн эрсдэл учраад нөхөн сэргээлтийг хийх боломжгүй болох эсвэл зохистой санг бүрдүүлээгүй үедээ компани

дампуурах тохиолдолд даатгуулсан байх тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Уг асуудлыг олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд болон олон улсын туршлагатай харьцуулан судалж үзэх.

Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх тухай” журмыг илүү дэлгэрэнгүй, өргөн хүрээг хамарсан байдлаар, өөрөөр хэлбэл уул уурхайн хайгуулын үе шатнаас уурхайг хаах, нөхөн сэргээлт хүртэлх үе шатыг хамарсан, уул уурхайн салбарт мөрдөж буй хууль, дүрэм, журамтай уялдуулан дахин боловсруулж, мөрдөх шаардлагатай байна.

### 8.3.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сайжруулах талаар

**Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны түвшинд:**

- Байгаль орчны хяналтыг сумдад ажиллах бүтэц зохион байгуулалтын эрх зүйн орчинг бий болгох
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн боловсруулалтыг сайжруулах зорилгоор Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зайлшгүй тусгах ажлын жагсаалт, түүнийг дүгнэх шалгуур гаргах
- Нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авахдаа мэргэжлийн байгууллагын хийсэн дэвсгэр зургийг үндэслэн хүлээн авах журамд шилжих
- Нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авдаг мэргэжлийн байгууллагын ажлыг шалгах

**Уул уурхайн яамны түвшинд:**

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түрээсийн гэрээгээр иргэн аж ахуйн нэгжид ашигт малтмал олборлох эрхээ шилжүүлж байгааг таслан зогсоох арга хэмжээ авах
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

### 8.3.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар

АМГ-аас гаргаж ирүүлсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээний чанар нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад тааруу байна. Энэ нь компаниуд уг тайланг бүрэн гүйцэд гаргаагүй юм уу, эсвэл нөхөн сэргээлтийн ажил ийм муу хийгдсэн юм уу ойлгомжгүй байна.

### 8.3.5 Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн гэрээг тодорхой болгох талаар

ОҮИТБС-ын ажлын удирдамжинд Орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээнүүдийн жагсаалтыг гаргах, гэрээний биелэлтийг дүгнэх тухай заасан. Нэгтгэл тайлангийн явцад 21 компаниас үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээ болон түүний биелэлтийн талаар мэдээлэл ирсэн.

Ирсэн гэрээнүүдийг судалж үзэхэд орон нутгийн хөгжлийг дэмжих гэрээнээс гадна газар ашиглах, эзэмших, ус рашаан ашиглах гэх мэт гэрээнүүдийг ирүүлсэн. Бид ирүүлсэн гэрээнүүдийн ерөнхий утга, биелэлтийн байдлыг харуулсан жагсаалтыг нэгтгэлийн тайланд хавсралтаар оруулсан.

Иймд Ажлын хэсэг нь ажлын удирдамжиндаа аль төрлийн гэрээг нь судалж, ямар заалтуудыг ил тод болгох талаар илүү тодорхой болгох нь зүйтэй байна.

**Хавсралт А. Нэгтгэлийн дүнд үүссэн тохируулгууд (1)–санхүүгийн урсгалаар**

Энэхүү хавсралтаар Монголын ОУИТБС-ын ажлын алба болон СЯ-наас гаргасан тайлангуудыг нэгтгэн, анхлан үүссэн зөрүүтэй дүнд хийгдсэн тохируулгуудыг харуулж байна.

## 1. Татварууд

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| 1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 78,050,048 | 2,753,617 | 80,802,900 | 765 |
| 2.Гаалийн албан татвар | 112,099,345 | (60,946,219) | 51,153,126 | - |
| 3.Нэмэгдсэн өртгийн албан татвар | 222,394,475 | (125,866,209) | 96,528,266 | - |
| 4.Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 10,909,524 | (1,501,448) | 9,405,301 | 2,775 |
| 5.Автобензин, дизелийн түлшний албан татвар | 2,133,199 | (653) | 2,132,546 | - |
| 6.Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 1,191,983 | (687) | 1,191,296 | - |
| 7.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 245,079 | 130,903 | 383,926 | (7,945) |
| 8.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 267,499 | 499 | 274,064 | (6,065) |
| 9.Бусад | (22,252,716) | 6,343 | (22,246,373) | - |
| **Нийт** | **405,038,435** | **(185,423,854)** | **219,625,052** | **10,471** |

### 1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү,цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 78,050,048 | 2,753,617 | 80,802,900 | 765 |

***ААНОАТ-ын анхны нэгтгэлийн зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- “Авдар баян” ХХК нь 1,791.7 мянган төгрөг, “Баганаур” ХК нь 50,000.0 мянган төгрөг, “Дацан трейд” ХХК нь 14,048.2 мянган төгрөгийг анхны тайландаа тусгаагүйгээс зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад эдгээр компаниуд нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж ирүүлсэн тул тохируулгыг хийсэн.
- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “АГМ майнинг” ХХК 29,303.3 мянган төгрөг, “Алтайн хүдэр” ХХК 7,879.7 мянган төгрөг, “АУМ” ХХК 253,580.8 мянган төгрөг, “Баян айраг эксплорэйшн” ХХК 196,504.9 мянган төгрөг, “Гурвантөхөм” ХХК 19,606.6 мянган төгрөг, “Бату майнинг монгол” ХХК 32,200.9 мянган төгрөг, “Белгравия майнинг” ХХК 19,499.9 мянган төгрөг, “Гоби эксплорэйшн” ХХК 184,382.0 “Жем интернэйшнл” ХХК 930,041.8 “Каскейд майнинг” ХХК 295,528.5 мянган төгрөг, “Жей Кей Эм Кей” ХХК 43,978 мянган төгрөг, “Өрмөн-Уул” ХХК 243,256.3 мянган төгрөг, “Коммод” ХХК 12,138.3 мянган төгрөг, “Мондулаан трейд” ХХК 29,503.9 мянган төгрөг, “Шинэ Шивээ” ХХК 57,742.8 мянган төгрөг, “Шар нарст” ХХК 59,945.1 мянган төгрөг, “Хоту” ХХК 16,549.1 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн. Эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж өгсөн тул холбогдох тохируулгуудыг хийсэн.
- “Мон-Ажнай” ХХК нь 2011 оны эцэст төлсөн 8,000.0 мянган төгрөгийн татварыг оруулж тусгасан байна. Харин уг татвар нь он дамжиж улсын төсөвт орсон учраас компанийн тайлагнасан дүнгээс хасч тохируулсан.
- “Ханшижир” ХХК нь 9,649.7 мянган төгрөгийг дутуу тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр нэмж тохируулсан.
- “Эрдэнэс таван толгой” ХК нь анхны тайландаа уг татварын дүнг мянган төгрөгөөр бус сая төгрөгөөр тусгасан тул 39,721,438.8 мянган төгрөгийн анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөнөөр зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ анхны тайландаа “Саусгоби сэндс” ХХК-иас хүлээн авсан 2,307,806.0 мянган төгрөгийн, Жинхуа орд ХХК-иас хүлээн авсан 112,037.1 мянган төгрөгийн татварыг дутуу тусгасан байна. ТЕГ нь нэгтгэл тайлангийн явцад нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтөөс суутган тооцсон дүнг нэмж тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- “Орчлон орд” ХХК нь анхны тайландаа 218,968.7 мянган төгрөгийн татварыг огт тусгаагүй байна. Нэгтгэл тайлангийн явцад компани дэлгэрэнгүй мэдээллээ ирүүлсэнээр тухайн дүн тохируулагдсан.
- “Монлаа” ХХК нь анхны тайландаа ААНОАТ-т 96,695.5 мянган төгрөгийг төлсөнөөр тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ уг дүнг 2011 оны эцэст төлөөгүй

үлдэгдэл, харин 2012 оны эхний улиралд төлсөн дүнгээ тусгаж өгсөн тухай тайлбар өгсөн тул хасч, тохируулсан.

- “Оюу толгой” ХХК нь анхны тайландаа 66,719.2 мянган төгрөгийн татвар төлсөн гэж тайлагнасан нь ЗГ-ын дүнгээс ихээхэн зөрүү үүссэн. Компани нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөнөөр холбогдох тохируулгыг хийсэн.
- “Чинхуа МАК нарийн сухайт” ХХК нь анхны тайландаа ноогдол ашгийн татвар болох 334,253.5 мянган төгрөгийг тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр нэмж тохируулсан.
- “Шанлун” ХХК нь анхны тайландаа 51,963.6 мянган төгрөгийн татварыг илүү тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон тул хасч, тохируулсан.
- ЗГ анхны тайландаа “Шижир Алт” ХХК-иас төлсөн 52,170.4 мянган төгрөгийн татварын торгуулийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дүнд оруулж тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ТЕГ болон компаниас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ анхны нэгтгэлд нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Ээрмэл” ХХК-ийг хамруулсаны улмаас тус компани дээр 33,577.7 мянган төгрөгийн татварын зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад компанид нэгтгэл тайлангийн ажлын талаар ойлголт өгч, хариу мэдээлэл авах гэж ихээхэн хүндрэлтэй тулгарсаны эцэст, уг компаниас холбогдох мэдээллийг гаргуулан авч тохируулгыг хийсэн.

### 1.2 Гаалийн албан татвар

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Гаалийн албан татвар | 112,099,345 | (60,946,219) | 51,153,126 | - |

***Гаалийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- Гаалийн албан татварын хувьд Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн тайлан болон дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн компаниуд руу тохируулах үүднээс ажилласан ба компаниуд нь ихэвчилэн гаальд төлсөн НӨАТ, онцгой албан татвар, авто бензин дизелийн түлшний албан татвар, гаалийн бүрдүүлэлтийн хураамж зэргийг бүхэлд нь тайлагнасан учраас тохируулгыг Гаалийн ерөнхий газрын тайлангийн дүнгээр хийсэн.
- Анхны тайландаа “Адуунчулуун” ХК 12,295.5 мянган төгрөг, “Анхай Интернэшнл” ХХК 53,409.4 мянган төгрөг, “Багануур” ХК 71,214.8 мянган төгрөгийн татварыг тайландаа тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. Эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргэж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 2,231,600.4 мянган төгрөг, “АУМ” ХХК 132,221.2 мянган төгрөг, “Баян айраг эксплорэйшн” ХХК 5,870.0 мянган төгрөг, “Дэлгэр орчлон” ХХК 911,782.0 мянган төгрөг, “Коммод” ХХК 87,591.8 мянган төгрөг, “Магнай трейд” ХХК 2,860,384.1 мянган төгрөг, “Олон овоот голд” ХХК 29,717.5 мянган төгрөг, “Хера Инвестмент” ХХК 859,244.9 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн байсныг нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа “Кожеговь” ХХК-иас хүлээн авсан 22,681.3 мянган төгрөгийн гаалийн албан татварыг тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ГЕГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулгыг хийсэн.
- “Могойн гол” ХХК нь санаачлагын албанд гаргаж өгсөн тайландаа 5,615.1 мянган төгрөгийн татварыг тусгаагүйн улмаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа “Монгол-Алт” ХХК-иас хүлээн авсан 246.1 мянган төгрөгийн гаалийн албан татварыг 246,084.4 гэж мянгачилж тайлагнаагүй төгрөгөөр илэрхийлсэний улмаас анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ГЕГ болон компанийн ирүүлсэн мэдээлэлээр нотлогдож хасч, тохируулсан.
- “Хангад Эксплорэйшн” ХХК санаачлагын албанд өгсөн тайландаа гаалийн албан татвараа нэмэгдсэн өртгийн албан татвар мөрөнд тайлагнаснаас анхны зөрүү үүссэн ба ГЕГ болон компанийн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн НӨАТ-аас хасч, гаалийн албан татвар мөрөнд нэмж тохируулсан.
- “Петрокоал” ХХК нь анхны тайландаа тухайн татварт төлсөн дүнгээ дутуу тайлагнаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгасан тул тохируулгыг хийсэн.
- ЗГ анхны тайландаа “Гоби энержи партнерс” ХХК-ийн гаалийн албан татварт 44,871.9 мянган төгрөгийг тусгасан байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас уг татварын дүнг тодруулахад манай компанийн нэр дээр өөр компани импортоор бараа оруулж ирсэн ба түүнд төлсөн татвар байна гэсэн хариу өгсөн учраас ЗГ талаас хасч, тохируулсан
- “Шивээ Овоо” ХК нь анхны тайландаа 30,544.8 мянган төгрөгийн гаалийн татварыг дутуу тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж ирүүлсэн тул компани талд нэмж, тохируулсан.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа гаалийн албан татварын дүнд гаальтай холбоотой бүх татварыг оруулж тусгаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад ГЕГ-аас тус компаниас

төлсөн татваруудын дүнг дэлгэрэнгүй задаргаагаар гаргуулан авч, компаниас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зохих тохируулгыг хийсэн.

### 1.3 Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 222,394,475 | (125,866,209) | 96,528,266 | - |

***НӨАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- Анхны тайландаа “Адуунчулуун” ХК 25,820.6 мянган төгрөг, “Анхай Интернэшнл” ХХК 112,159.8 мянган төгрөг, “Нордвинд” ХХК 27,933.9 мянган төгрөгийн НӨАТ-ыг огт тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 5,022,866.2 мянган төгрөг, “АУМ” ХХК 426,492.7 мянган төгрөг, “Баян айраг эксплорэйшн” ХХК 110,199.2 мянган төгрөг, “Геомин” ХХК 126,268.8 0 мянган төгрөг, “Коммод” ХХК 183,942.8 мянган төгрөг, “Хера Инвестмент” ХХК 555,999.9 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Кожеговь” ХХК-иас хүлээн авсан 49,606.6 мянган төгрөгийн татварыг тусгаагүйгээс анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ГЕГ-аас гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Пибоди Винсвэй ресорсиз” ХХК нь анхны тайландаа 426,762.4 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг тусгаснаас зөрүү үүссэн тул хасч тохирууллаа.
- ЗГ нь анхны тайландаа “Оюу толгой” ХХК-иас төлсөн татварыг илүү дүнгээр тусгаж зөрүү үүсгэсэн. Нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ЗГ-ын анхны тайланд тусгасан дүн 300,455,686.4 мянган төгрөгийг бууруулж 175,762,788.6 мянган төгрөгөөр тохируулсан.
- “Редхил Монголиа“, “Улз гол” зэрэг компаниуд нь анхны тайландаа уг татварыг буруу дүнгээр тайлагнаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ төлсөн татварын дүнг залруулж ирүүлсэн тул зөрүүг тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа Гоби энержи партнерс” ХХК-ийн НӨАТ-ийн дүнг 94,231.1 мянган төгрөгөөр нэгтгэсэн байна. ЗГ-аас ирүүлсэн энэ дүнг компаниас тодруулахад манай компани 2011 онд татвар төлөөгүй гэсэн хариу өгсөн. ТЕГ-т дахин хандаж тодруулахад тус компаниас 2012 онд төлсөн татварын дүнг нэгтгэсэн байна гэсэн тайлбар өгсөний дагуу зохих тохируулгыг хийсэн.
- “Шарын гол” ХК нь анхны тайландаа 627,064.1 мянган төгрөгийн НӨАТ-ын буцаалтыг НӨАТ-ын дүнд оруулж тусгасан тул зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон тул хасч, тохируулсан.
- “Шивээ Овоо” ХК нь анхны тайландаа 158,571.6 мянган төгрөгийн гаальд төлсөн НӨАТ-ыг тайлагнаагүй ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөнөөр зохих тохируулгыг хийсэн.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа НӨАТ-т төлсөн дүнгээ гаалийн албан татварын дүнгээс салгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.

### 1.4 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 10,909,524 | (1,501,448) | 9,405,301 | 2,775 |

***Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- “Петро чайна дачин тамсаг” ХХК нь анхны тайландаа төлсөн дүнгээ огт тусгаагүй байна. Компани нь онцгой албан татвараас 2011 онд чөлөөлөгдсөн учраас уг татварыг төлөөгүй, манай компанийн нэр дээр НИК дизелийн түлш оруулж ирдэг, тэр компаниас төлсөн татвар гэсэн тайлбар өгсөн тул компани талаас хасч, тохируулсан.
- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүйгээс “Магнай трейд” ХХК 8,296,018.1 мянган төгрөг, “Монголын алт МАК” ХХК 16,098.0 мянган төгрөг “Казмонконтакт” ХХК 23,281.9 мянган төгрөгийн онцгой албан татварын зөрүү үүссэн байна. Эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад

санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж өгсөн тул зохих тохируулгыг хийсэн.

- “Монголросцветмет” ХХК нь анхны тайландаа -ийн 115,338.9 мянган төгрөгийн татварыг автобензин дизелийн түлшний албан татварын дүнд оруулан тусгасан байна. ГЕГ-ын мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- Санаачлагын ажлын албанд өгсөн анхны тайландаа “Гоби коул энд энержи” ХХК нь тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ ч ирүүлээгүй учир ТЕГ-ын мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Дорнынхүдэр” ХХк нь анхны тайландаа 6,955.7 мянган төгрөгийн онцгой албан татварыг гаалийн албан татварт оруулан тусгасан байсаныг салгаж, уг урсагалд оруулан компани талд нэмж, тохируулсан.
- “Синчи ойл” ХХК нь өөрийн эзэмшилд байсан хайгуулын лицензээ 2012 оны эхэнд хувь хүнд худалдан борлуулсан бөгөөд анхны тайлангаа санаачлагын албанд гаргаж өгөөгүйгээс тухайн компанийн үндсэн үйл ажиллагаа болох автобензин, дизелийн түлшний албан татвар дээр 370,887.7 мянган төгрөгийн зөрүү үүссэнн байна. Нэгтгэл тайлангийн явцад мэдээллээ дэлгэрэнгүй ирүүлсэнээр компанийн дүнг тохируулж зөрүүг шийдвэрлэсэн.
- “Хера инвестмент” ХХК дээр 949,141.7 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба 2011 онд тус компаниас тусгаарласан "Хера фүүдс" ХХК нь шар айраг худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ба тухайн компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь өөр боловч зарим нэг бизнесийн онцлогоос шалтгаалсан хүндрэл бэрхшээлээс шалтгаалан гаалиар оруулж ирсэн бараагаа "Хера инвестмент" ХХК-ийн нэр дээр бүрдүүлэлтээ хийж төлбөрийг нь "Хера фүүдс" ХХК төлж тайландаа тусгаж байсан байна. Компаниас албан бичгээр тайлбар авсаны үндсэн дээр компани талаас хасч тохируулсан.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа 923,635.6 мянган төгрөгийн татварыг гаалийн татварт оруулж тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.

### 1.5 Автобензин, дизелийн түлшний албан татвар

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Автобензин, дизелийн түлшний албан татвар | 2,133,199 | (653) | 2,132,546 | - |

***Автобензин, дизелийн түлшний албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүйгээс “Магнай трейд” ХХК 1,779,052.2 мянган төгрөг , “Петрочайна дачин тамсаг” ХХК 33,974.3 мянган төгрөг, “Казмонконтакт” ХХК 1,298.7 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад эдгээр компаниуд нь санаачлагын тайланг дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж өгсөн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Монголросцветмет” ХХК нь анхны тайландаа 111,584.1 мянган төгрөгийн автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг уг татварын дүнд оруулж тусгасан байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн мэдээлэлд үндэсэлн тохируулсан.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа 54,059.8 мянган төгрөгийн татварыг гаалийн татварын дүнд оруулж тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн тохируулсан.

## 1.6 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (ЗБҮӨАТ)

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 1,191,983 | (687) | 1,191,296 | - |

***ЗБҮӨАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- “Андын тэмүүлэл” ХХК нь анхны тайландаа андуурч өөр дүн тусгаснаас 33,495.5 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ залруулж зөв дүнг тусгаж өгсөнөөр тохируулсан.
- “Буд-Инвест” ХХК нь анхны тайландаа 4,368.0 мянган төгрөгийн татварын дүнг огт тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Жинхуа Орд” ХХК-иас хүлээн авсан 41,630,0 мянган төгрөгийн татварын дүнг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад ТЕГ болон компани руу хандаж мэдээлэл авахад компани нь андуурч тусгасан, ТЕГ нь тус компаниас төлөлт байхгүй тухай хариу ирүүлсэний дагуу компани талаас хасч, тохируулсан.
- “Цэвдэг” ХХК нь анхны тайландаа 9,998.8 мянган төгрөгийн татварын дүнг тусгаагүйн улмаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөн тул компани талд нэмж тохируулсан.
- “Олон овоот гоулд” ХХК нь санаачлагын ажлын албанд анхны тайлангаа гаргаж ирүүлээгүйгээс ЗБҮӨАТ-т төлсөн 1,290,686.0 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад мэдээллээ ирүүлсэнээр компанийн дүн тохируулагдаж зөрүүг шийдвэрлэгдсэн.
- “Хар тарвагатай” ХК нь анхны тайландаа ЗБҮӨАТ-т 38,634.9 мянган төгрөг төлсөн гэж ирүүлсэн ба нэгтгэл тайлангийн явцад тухайн татварт буруу дүн ирүүлсэнээ нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ залруулж ирүүлсэнээр компанийн дүнг хасч, тохируулсан.

## 1.7 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар(ҮХЭХАТ)

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 245,079 | 130,903 | 383,926 | (7,945) |

***Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

Уг татварын зөрүү ихэвчилэн орон нутгийн төсөвт төлсөн татварын дүн анхны нэгтгэлд нэгтгэгдээгүйгээс үүссэн байна.

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 7,428.3 мянган төгрөг, “Коммод” ХХК дээр 3,336.8 мянган төгрөг, “Олон овоот гоулд” ХХК 8,133.0 мянган төгрөг, “Лут чулуу” ХХК 2,756.0 мянган төгрөг, “МЕС” ХХК 1,500.0 мянган төгрөг, “Мондулаан трейд” ХХК 3,338.6 мянган төгрөг, “Монполимет” ХХК 566.5 мянган төгрөг, “Монгол алт МАК” ХХК 36,689.4 мянган төгрөг, “Монгол алт” ХХК 781.9 мянган төгрөг, “Монголболгаргео” ХХК 3,298.8 мянган төгрөг, “Сонор трейд” 11,185.0 мянган төгрөг, “Таван толгой” ХК 18,000.0 мянган төгрөг, “Тэн хун” ХХК 8,417.3 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Хар тарвагатай” ХК анхны тайланд тухайн татварыг дутуу тайлагнаж ирүүлсэн байсан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээллээр нэмж ирүүлсэнээр тохируулсан.
- ЗГ анхны нэгтгэлд нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Ээрмэл” ХХК-ийг хамруулсаны улмаас тус компани дээр 26,046.8 мянган төгрөгийн татварын зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад компанид нэгтгэл тайлангийн ажлын талаар ойлголт өгч, хариу мэдээлэл авах гэж ихээхэн хүндрэлтэй тулгарсаны эцэст, уг компаниас холбогдох мэдээллийг гаргуулан авч тохируулгыг хийсэн. Санаачлагын албанд тайлангаа гаргаж өгөөгүйгээс
- “Эрэл” ХХК нь санаачлагын албанд өгсөн тайландаа илүү тайлагнасан нь нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон тул хасч, тохируулсан.

## 1.8 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 267,499 | 499 | 274,064 | (6,065) |

***Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргэж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 54,618.3 мянган төгрөг, “Булгангангат” ХХК 1,854.0 мянган төгрөг, “Буман олз” ХХК 1,606.0 мянган төгрөг, “Геомин” ХХК 1,968.0 мянган төгрөг, Гоби-эксплорэйшн ХХК 2,297.0 мянган төгрөг, “Гурван зам” ХХК 1,382.0 мянган төгрөг, “Гурван төхөм” ХХК 1,580.0 мянган төгрөг, Жей Кей Эм Кей ХХК 2,261.0 мянган төгрөг, “Мондулаан трейд” ХХК 6,699.3 мянган төгрөг, “Монполимет” ХХК 3,623.2 мянган төгрөг, “Монгол алт МАК” ХХК 24,987.4 мянган төгрөг, “Олон овоот голд” ХХК 6,983.0 мянган төгрөг, “Тиенжинсанжо” ХХК 14,406.3 мянган төгрөг, “Шинэ Илион Нэн Юань” ХХК 97,303.6 мянган төгрөг, “Эжбалей” ХХК 1,485.0 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Гацуурт” ХХК нь анхны тайландаа 3,160.9 мянган төгрөгийн татварыг тайлагнаснаас зөрүү үүссэн ба тус компани агаарын бохирдлын төлбөр оруулсаныг хасч тохируулсан.
- “Монлаа” ХХК нь анхны тайландаа тухайн татварын дүнг илүү тайлагнаж ирүүлсэнээр зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ хасч ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Чингисийн хар алт” ХХК нь анхны тайландаа 1,162.4 мянган төгрөгийн татварыг дутуу тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул компани талд нэмж тохируулаа.
- ЗГ нь анхны тайландаа “Эрвэн хүдэр” ХХК-иас хүлээн авсан 848.5 мянган төгрөгийн татварын дүнг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад ТЕГ-т хандан, холбогдох мэдээллийг авч, тохируулгыг хийсэн.
- “Эс Би Эф” ХХК нь санаачлагын албанд өгсөн тайландаа илүү тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ уг татварын дүнг хасч ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.

## 1.9 Бусад

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Бусад | (22,252,716) | 6,343 | (22,246,373) | - |

***Бусад албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- Анхны тайландаа дараах компаниуд санаачлагын тайлангийн маягтаар тайлагнах санхүүгийн урсгал биш ХХОАТ-ыг тусгаж зөрүү үүсгэсэн байна. Үүнд: “Адуунчулуун” ХК 259,274.2 мянган төгрөг, “Андын илч” ХХК 5,135.0 мянган төгрөг, “Анхай Интернэшнл” ХХК 31,796.8 мянган төгрөг, “Бүүргэнт” ХХК 28,016.0 мянган төгрөг, “Бэрэн групп” ХХК 26,100.0 мянган төгрөг, “Дацан трейд” ХХК 14,048.4 мянган төгрөг, “Дун-Эрдэнэ” ХХК 8,917.3 мянган төгрөг, “Кожеговь” ХХК 427,163.5 мянган төгрөг, “Мо Эн Ко” ХХК 280,034.7 мянган төгрөг, “Мон лаа” ХХК 61,615.2 мянган төгрөг, “Монгол металл майнинг” ХХК 94,800.0 мянган төгрөг, “Оюу толгой” ХХК 5,831,579.9 мянган төгрөг, “Петро матад” ХХК 195,428.0 мянган төгрөг, “Саус гоби сэндс” ХХК 1,336,009.7 мянган төгрөг, “Сентерра голд” ХХК 92,142.4 мянган төгрөг, “Хангад эксплорэшн” ХХК 3,437.7 мянган төгрөг, “Хуади куонез” ХХК 38,700.0 мянган төгрөг, “Эм Пи Эйч Си Эл” ХХК 41,739.8 мянган төгрөг, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 10,730,114.0 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн. Эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ ХХОАТ-ын төлсөн дүнг “Бусад” татвар хэсэгт тусгаж өгсөн тухайгаа тайлбар ирүүлсэн тул хасч, тохируулсан.

## 2. Төлбөрүүд

(мян.төг)

| | Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|---|
| | | | ЗГ | Компани | |
| 1 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | 123,105,212 | 12,776,722 | 135,881,934 | - |
| 2 | Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | (19,185,508) | 4,066,187 | (15,160,675) | 41,354 |
| 3 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 328,583 | (7,433) | 299,141 | 22,009 |
| 4 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 3,592,072 | 1,052,893 | 4,790,175 | (145,211) |
| 5 | Агаарын бохирдлын төлбөр | 10,884,877 | 106,231 | 10,992,086 | (978) |
| 6 | Газрын төлбөр | (2,002,665) | 2,457,980 | 497,785 | (42,469) |
| 7 | Ус, рашаан ашигласны төлбөр | 25,066 | 290,819 | 320,029 | (4,144) |
| 8 | Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр | (48,232) | (413) | (48,645) | - |
| 9 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | (45,577) | 167,372 | 121,795 | - |
| 10 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | (8,568,398) | 6,514,716 | (2,053,682) | - |
| | **Нийт** | **108,085,430** | **27,425,074** | **135,639,944** | **(129,440)** |

### 2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр (АМНАТ)

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | 123,105,212 | 12,776,722 | 135,881,934 | - |

***Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

ЗГ нь анхны тайландаа орон нутагт төлсөн төлбөрийн дүнг давхардуулж тусгах, мөн огт тусгаагүй зэргээс шалтгаалан зөрүү үүссэн байна. Энэ алдаа нь жилийн жилд гарч байна.

- Санаачлагын албанд анх гаргаж өгсөн тайландаа “Авдар баян” ХХК нь 2,084.0 мянган төгрөг, “Эрдэнэт Үйлдвэр”ХХК 1,370,370.8 мянган төгрөг, “Энержи ресурс” ХХК 2,260,790.3 мянган төгрөг, “Шижир Алт” ХХК 239,435.3 мянган төгрөг “Шар нарст” ХХК 37,091.2 мянган төгрөгийн төлбөрийг тус тус дутуу тусгаснаас зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 7,468,247.4 мянган төгрөг, “АУМ” ХХК 249,556.8 мянган төгрөг, “Булган гангат” ХХК 686,723.9 мянган төгрөг, “Гурвантөхөм” ХХК 182,477.9 мянган төгрөг, “Жи Энд Юу Голд” ХХК 367,394.4 мянган төгрөг, “Өрмөн-Уул” ХХК 556,167.1 мянган төгрөг, “Коммод” ХХК 9.936,1 мянган төгрөг, “Мондулаан трейд” ХХК 1,878,448.4 мянган төгрөг, “Рэмет” ХХК 518,362.2 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ анхны тайландаа “Гацуурт” ХХК-иас төлсөн 108,884.3 мянган төгрөг, “Дацан трейд” ХХК-иас төлсөн 41,948.1 мянган төгрөгийг дутуу тусгаснаас зөрүү үүссэн ба ТЕГ-аас нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Бэрэн групп” ХХК нь анхны тайландаа тухайн онд төлсөн 289,621.6 мянган төгрөгийн төлбөрийг, “Чингисийн хар алт” ХХК-ийн 34,705.2 мянган төгрөгийн төлбөрийг тус тус огт тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж ирүүлсэн тул тохируулсан.
- ЗГ анхны тайландаа “Саусгоби сэндс” ХХК-ийн НӨАТ-ын илүү төлөлтөөс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрт шилжүүлэн тооцсон 8,419,433.4 мянган төгрөгийг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. ТЕГ нь нэгтгэл тайлангийн явцад тус компани дээр үүссэн зөрүүнд нэмэлт тодруулга өгсөн тул зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Баянтэгш импекс” ХХК-иас хүлээн авсан төлбөрийг 19,700.0 1 мянган

төгрөгөөр дутуу, харин компани уг төлбөрийн дүнг 37,501.0 1 мянган төгрөгөөр илүү тусгаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн холбогдох тохируулгыг хийсэн.

- “Дадиази юиан” ХХК нь ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүйн улмаас 287,276.2 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад тайланг дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж өгсөнөөр тохируулга хийгдсэн. Мөн ЗГ нь анхны тайландаа тус компаниас хүлээн авсан төлбөрийн дүнг 86,182.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан ба ТЕГ нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн учраас ЗГ талд нэмж тохируулгыг хийсэн.
- “Хотгор” ХХК нь анхны тайландаа 35,835.2 мянган төгрөгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэж андуурч тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ залруулж тусгаж өгсөн тул уг татварын дүнгээс хасч, тохируулсан.
- “Хүрээ дэл” ХХК нь анхны тайландаа “Таван толгой” ХК-иас нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу суутган тооцсон татвар 619,013.2 мянган төгрөгийг тусгаснаас зөрүү үүссэн байна. Уг татвар нь “Таван толгой” ХК-иас улсын төсөвт төлсөн татвар учраас “Хүрээ дэл” ХХК-ийн дүнгээс хасч, тохируулсан. Энэ зөрүүгийн шалтгааныг нэгтгэл тайлангийн явцад хоёр талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тодруулсан.
- “Хэрлэн Энерго” ХХК нь анхны тайландаа 42,039.4 мянган төгрөгийн төлбөрийг илүү тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ уг төлбөрийн дүнг хасч тусгаж өгсөн тул тохируулсан.

## 2.2 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | (19,185,508) | 4,066,187 | (15,160,675) | 41,354 |

***Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “АГМ майнинг” ХХК 179,658.4 мянган төгрөг, “Алтайн хүдэр” ХХК 25,903.5 мянган төгрөг, “Баян айраг эксплорэйшн” ХХК 121,580.7 мянган төгрөг, “Булгангангат” ХХК 14,090.8 мянган төгрөг, “Гурвантөхөм” ХХК 8,531.8 мянган төгрөг, “Жей Кей Эм Кей” ХХК 15,039.4 мянган төгрөг, “Занадуметалс монголиа” ХХК 284,201.7 мянган төгрөг, “Коммод” ХХК 133,852.2 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Багануур” ХК нь анхны тайландаа тухайн онд төлсөн төлбөр 32,894.0 мянган төгрөгийг тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгасан тул тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Жи Эс Би майнинг” ХХК-иас хүлээн авсан 164,901.5 мянган төгрөгийн төлбөрийг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. АМГ нь нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Зараяа Холдингс” ХХК-иас хүлээн авсан 791,414.9 мянган төгрөг, “ЗБАА” ХХК-иас хүлээн авсан 161,314.4 мянган төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Цөмийн энергийн газарт хандаж, холбогдох мэдээллийг авч, зөрүүг тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа “Монголын-Алт МАК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг “Монгол-Алт” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн төлбөрт оруулан, андуурч тусгаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад АМГ болон компаниас гаргаж ирүүлсэн мэдээллээр зөрүү нь нотлогдсон тул зохих тохируулгыг хийсэн.
- “Самтон Морис” ХХК нь 2011 онд “Женерал Метал Минералс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан ба “Женерал Метал Минералс” ХХК нь тус компанийн нэрийн өмнөөс тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлсөнийг анхны тайландаа тусгаагүйгээс 31,146.7 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба нэгтгэлийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр тохируулсан.
- “Хунан жинлэн” ХХК нь санаачлагын албанд өгсөн анхны тайландаа 5,258.9 мянган төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр хэсэгт

тайлагнаж анхны зөрүү үүссэн ба нэгтгэлийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр тохируулсан.

- ЗГ нь анхны тайландаа “Пенинсуламайнинг” ХХК-иас хүлээн авсан 86,387.4 мянган төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг тусгаагүйгээс зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад АМГ-т хандаж, тус байгууллагаас гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа “Броад” ХХК-иас хүлээн авсан 230,422.4 мянган төгрөгийн төлбөрийг огт тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад АМГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Гоби консолидетед” ХХК нь анхны тайландаа 17,671.9 мянган төгрөгийн төлбөрийг дутуу тусгаж зөрүү үүсгэсэн байна. Нэгтгэл тайлангийн явцад АМГ болон компанид хандаж, холбогдох мэдээллийг авч, тохируулгыг хийсэн.
- “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн 32,473.1 мянган төгрөгийн зөрүү нь валютын ханшийн зөрүү учраас АМГ-ын мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Хүдэн” ХХК нь санаачлагын албанд өгсөн тайландаа мянгачлаагүй 323,230.00 төгрөөр тусгаж 322,906.8 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад АМГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.

## 2.3 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 328,583 | (7,433) | 299,141 | 22,009 |

***Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ЗГ анхны тайландаа “Монголын Алт Мак” ХХК-ийн 7,597.8 мянган төгрөгийн төлбөрийг “Монгол-Алт” ХХК-ийн тайланд нэгтгэснээс анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад АМГ-аас гаргаж ирүүлсэн мэдээллээр нотлогдсон тул зохих тохируулгыг хийсэн.
- “Хар тарвагатай” ХК нь анхны тайланд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордны нөхөн төлбөр хэсэгт 28,500.0 мянган төгрөг тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн мэдээлэлдээ уг төлбөрийг андуурч тусгасан тухайгаа тайлбарласан тул хасч, тохируулсан.

## 2.4 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 3,592,072 | 1,052,893 | 4,790,175 | (145,211) |

***Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

ЗГ нь компанид буцаасан төлбөрийг компани нь мөн буцааж авсан төлбөрийг анхны тайландаа оруулж тусгаснаас зөрүү үүссэн.

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргэж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 132,794.7 мянган төгрөг, “Баян айраг эксплорэйшн” ХХК 14,774.4 мянган
  төгрөг, “Си Эм Кэй Ай” ХХК 29,073.0 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Анхай Интернэшнл” ХХК нь анхны тайландаа 22,464.0 мянган төгрөгийн төлбөрийг дутуу тусгаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн нэмж, тохируулсан.
- ЗГ нь анхны тайландаа “Зараяа Холдингс” ХХК-иас төлсөн 10,843.2 мянган төгрөгийн, “Кожеговь” ХХК-иас төлсөн 56,734.4 мянган төгрөгийн, “Шинь Шинь” ХХК-иас төлсөн 96,585.8 мянган төгрөгийн төлбөрийг тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ХХҮГ-т хандаж, тус газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.

- “Зон Хэн юу тиан” ХХК нь 114,323.6 мянган төгрөг, “Монголжүюаньли” ХХК 7,641.0 мянган төгрөгийн төлбөрийг улсын төсөвт төлсөн төлбөр хэсэгт тайлагнаагүй, орон нутгийн төсөвт төлсөн төлбөр хэсэгт тайлагнаснаас зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад ХХҮГ болон компаниас гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.
- “Саусгоби сэндс” ХХК-ийн анхны тайланд тайлагнасан дүн ХХҮГ-ийн тайлагнасан дүнгээс дутуу байсан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул зохих тохируулгыг хийсэн.
- “Си Өү Эй Эл” ХХК нь анхны тайландаа 66,549.6 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн гэж тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад тухайн дүнг хасч ирүүлсэнээр компанийн дүнг тохируулсан.
- “Шивээ овоо” ХК санаачлагын албанд өгсөн тайландаа 2,052.0 мянган төгрөгийн төлбөрийг тайлагнаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөн тул нэмж тохируулсан.

## 2.5 Агаарын бохирдлын төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Агаарын бохирдлын төлбөр | 10,884,877 | 106,231 | 10,992,086 | (978) |

***Агаарын бохирдлын төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьд*вал:**

ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргэж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 1,885.0 мянган төгрөг, “Болд Фо Ар Да” ХХК 20,098.5 мянган төгрөг, “Бэрх-Уул” ХХК-д 8,038.8 мянган төгрөг, “Жинхуа Орд” ХХК 7,107.5 мянган төгрөг, “Тэн хун” ХХК 238,2 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.

- “Андын илч” ХХК нь ОУИТБС-ын ажлын албанд өгсөн тайландаа 9,603.3. мянган төгрөгийн татварыг дутуу тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж өгсөн тул зөрүүг тохируулсан.
- “Оюу толгой” ХХК нь анхны тайландаа 1,389.5 мянган төгрөг төлсөн гэж тайлагнасан ба Засгийн газар талд дүн байхгүй байснаас зөрүү үүссэн. ТЕГ-аас тухайн дүнг ирүүлсэнээр Засгийн газар талд нэмж тохируулсан. Компанийн дүн Засгийн газрын дүнгээс 1,800.00 төгрөгөөр дутуу тайлагнаж ирүүлсэн нь материаллаг түвшинд хүрэхгүй дүн учир Засгийн газрын дүнд үндэслэж тохируулсан.
- “Редхил Монголиа” ХХК тухайн төлбөрт 60,457.4 мянган төгрөг төлсөн ба тухайн дүнг Засгийн газар тайлагнаагүй байснаас зөрүү үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад Сүхбаатар дүүргийн татварын хэлтсээс ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Засгийн газрын дүнг нэмж тохируулсан.

## 2.6 Газрын төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Газрын төлбөр | (2,002,665) | 2,457,980 | 497,785 | (42,469) |

***Газрын төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьд*вал:**

ЗГ анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг нэгтгээгүйгээс зөрүү үүссэн. Энэ алдаа өмнөх жилүүдэд гарч байсан ба энэ жил өмнөх жилүүдийг бодвол арай багассан байна.

- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргэж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК 8,362.1 мянган төгрөг, “АУМ” ХХК 7,305.1 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- ЗГ анхны тайландаа “Мон-Ажнай” ХХК-иас Хөвсгөл аймаг, мөн тус аймгийн Бүрэнтогтох сумын төсөвт төлсөн 15,640.0 мянган төгрөгийн төлбөрийг тайлагнаагүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн тус аймгийн ЗДТГ-т албан бичиг илгээж, хариу мэдээлэл авч, тохируулсан.
- ЗГ анхны тайландаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2,015,007.1 мянган төгрөгийн "Эрдэнэт-Ус ДТС" ОНӨХК-тай холбоотой усны төлбөрт суутган тооцуулсан дүнг тусгаагүй байна. Компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Орхон аймгийн ЗДТГ-т хандаж, холбогдох мэдээллийг авч, тохируулсан.

Дараах компаниудаас зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын алба болон татварын байгууллагуудад төлсөн төлбөрүүдийг ТЕГ нь анхны тайландаа тайлагнаагүй байна. **Үүнд:**

| № | Компанийн нэр | Төлбөр хүлээн авсан | |
|---|---|---|---|
| | | Аймгийн нэр | Сумын нэр |
| 1 | Авдар баян ХХК | Төв | Аймаг |
| 2 | АГМ майнинг ХХК | Өмнөговь | Аймаг |
| 3 | Адил-Оч ХХК | Дундговь | Өлзийт |
| 4 | Азиагоулд монголиа ХХК | Өмнөговь | Ханбогд |
| 5 | Айвуун тэс ХХК | Хэнтий | Батширээт |
| 6 | Алтай хангай бүрд ХХК | Хэнтий | Өмнөдэлгэр |
| 7 | Андын илч ХХК | Сүхбаатар | Аймаг |
| 8 | Андын тэмүүлэл ХХК | Баянхонгор | Аймаг |
| 9 | АУМ ХХК | Өвөрхангай | Аймаг |
| 10 | Баялаг орд ХХК | Баянхонгор | Галуут |
| 11 | Баянтэгш импекс ХХК | Дорноговь | Иххэт |
| | | Хэнтий | Дархан |
| 12 | Баянтээг ХК | Өвөрхангай | Аймаг |
| 13 | Биг могул коул энд энержи ХХК | Дундговь | Аймаг |
| 14 | Бороо гоулд ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 15 | | Төв | Аймаг |
| 16 | Буд-Инвест ХХК | Төв | Аймаг |
| 17 | Булган гангат ХХК | Төв | Заамар |
| 18 | Бүүргэнт ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 19 | Бэрх-Уул ХХК | Хэнтий | Аймаг |
| 20 | Гацуурт ХХК | Булган | Сэлэнгэ |
| | | Сэлэнгэ | Зүүнбүрэн |
| | | Сэлэнгэ | Мандал |
| | | Сэлэнгэ | Түшиг |
| | | Төв | Батсүмбэр |
| 21 | Дацан трейд ХХК | Хэнтий | Норовлин |
| | | Увс | Тариалан |
| 22 | Жамп-Алт ХХК | Баянхонгор | Галуут |
| | | Дорнод | Баяндун |
| 22 | Жей Кей Эм Кей ХХК | Төв | Аймаг |
| 23 | Жи Эл Ди Ви ХХК | Дорноговь | Даланжаргалан |
| 24 | Жотойн бажууна ХХК | Төв | Аймаг |
| 25 | Капкорп Монголиа ХХК | Өвөрхангай | Төгрөг |
| 26 | Кожеговь ХХК | Дорноговь | Улаанбадрах |
| | | Сүхбаатар | Онгон |
| | | Сүхбаатар | Дарьганга |
| 27 | Магнай трейд ХХК | Архангай | Аймаг |
| | | Баянхонгор | Аймаг |
| | | Булган | Аймаг |
| | | Говь-Алтай | Аймаг |
| | | Дорнод | Аймаг |
| | | Өвөрхангай | Аймаг |
| | | Төв | Аймаг |
| | | Ховд | Аймаг |
| | | Хөвсгөл | Мөрөн |
| | | Хэнтий | Аймаг |
| 28 | Мон-Ажнай ХХК | Хөвсгөл | Аймаг |
| | | Хөвсгөл | Бүрэнтогтох |
| 29 | Монгол Алт Мак ХХК | Дорноговь | Даланжаргалан |
| | | Дорноговь | Мандах |

| | | | |
|---|---|---|---|
| | | Дорнод | Баянтүмэн |
| | | Дорнод | Хэрлэн |
| | | Дорнод | Аймаг |
| | | Дундговь | Дэлгэрхангай |
| | | Өмнөговь | Гурвантэс |
| 30 | Монголболгаргео ХХК | Баянхонгор | Аймаг |
| | | Баянхонгор | Баян-Овоо |
| | | Баянхонгор | Галуут |
| 31 | Монголжүюаньли ХХК | Сүхбаатар | Түмэнцогт |
| 32 | Монголрудпром ХХК | Хэнтий | Батноров |
| 33 | Мондулаан трейд ХХК | Төв | Аймаг |
| 34 | МоЭнКо ХХК | Ховд | Дарви |
| 35 | Нордвинд ХХК | Хэнтий | Галшар |
| 36 | Олова ХХК | Төв | Аймаг |
| 37 | Өрмөн-Уул ХХК | Төв | Аймаг |
| 38 | Петро Матад ХХК | Дорнод | Аймаг |
| | | Дорнод | Матад |
| | | Сүхбаатар | Эрдэнэцагаан |
| 39 | Петрокоал ХХК | Төв | Баян |
| 40 | Редхил монголиа ХХК | Сэлэнгэ | Түшиг |
| 41 | Саусгоби сэндс ХХК | Өмнөговь | Гурван тэс сум |
| 42 | Си Эм Кэй Ай ХХК | Хэнтий | Татварын хэлтэс |
| 43 | Сонор трейд ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 44 | Төгрөг нуурын энержи ХХК | Төв | Баян |
| 45 | Хангад Эксплорэйшн ХХК | Өмнөговь | Ханхонгор |
| 46 | Хар тарвагатай ХК | Увс | Тариалан |
| 47 | Хурай ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 48 | Хургатай Хайрхан ХХК | Хөвсгөл | Цэцэрлэг |
| 49 | Чингисийн хар алт ХХК | Дорноговь | Аймаг |
| 50 | Цайрт минерал ХХК | Сүхбаатар | Асгат |
| | | Сүхбаатар | Баяндэлгэр |
| 51 | Шижир алт ХХК | Төв | Аймаг |
| 52 | Энгүй тал ХХК | Баянхонгор | Шинэжинст |
| 53 | Эрвэн хүдэр ХХК | Сүхбаатар | Сүхбаатар |
| 54 | Эрдэнэт үйлдвэр ХХК | Орхон | Аймаг |
| 55 | Эрдэс холдинг ХХК | Сэлэнгэ | Ерөө |
| | | Сэлэнгэ | Хүдэр |
| | | Сэлэнгэ | Шаамар |
| 56 | Эрэл ХХК | Дархан-Уул | Аймаг |
| | | Дорноговь | Аймаг |
| 57 | Эс Би Эф ХХК | Төв | Аймаг |

## 2.7 Ус, рашаан ашигласны төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Ус, рашаан ашигласны төлбөр | 25,066 | 290,819 | 320,029 | (4,144) |

***Ус, рашаан ашигласны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ОУИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “Алтайн хүдэр” ХХК-д 20,063.0 мянган төгрөг, “АУМ” ХХК 52,950.0 мянган төгрөг, “Жей Кей Эм Кей” ХХК 6,488 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.

- ЗГ нь анхны тайландаа “Андын тэмүүлэл” ХХК-иас төлсөн 11,550.0 мянган төгрөгийн төлбөрийг нэгтгээгүйгээс зөрүү үүссэн байна. ТЕГ нь нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгаж өгсөн тул тохируулгыг хийсэн.

Дараахи компаниудаас зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын алба болон татварын байгууллагуудад төлсөн төлбөрүүдийг ТЕГ нь анхны тайландаа тайлагнаагүй байна. **Үүнд:**

| № | Компанийн нэр | Төлбөр хүлээн авсан | |
|---|---|---|---|
| | | Аймгийн нэр | Сумын нэр |
| 1 | Авдар баян ХХК | Төв | Заамар |
| 2 | АГМ майнинг ХХК | Өмнөговь | Аймаг |
| 3 | Адил-Оч ХХК | Дундговь | Өлзийт |
| 4 | Азиагоулд монголиа ХХК | Өмнөговь | Ханбогд |
| 5 | Айвуун тэс ХХК | Хэнтий | Батширээт |
| 6 | Алтай хангай бүрд ХХК | Хэнтий | Өмнөдэлгэр |
| 7 | Андын илч ХХК | Сүхбаатар | Аймаг |
| 8 | Андын тэмүүлэл ХХК | Баянхонгор | Аймаг |
| 9 | Анхай-Интернэшнл ХХК | Төв | Аймаг |
| 10 | АУМ ХХК | Өвөрхангай | Уянга |
| 11 | Баян айраг эксплорэйшн ХХК | Завхан | Дөрвөлжин |
| | | Завхан | Эрдэнэхайрхан |
| 12 | Баянтэгш импекс ХХК | Дорноговь | Иххэт |
| | | Хэнтий | Дархан |
| 13 | Биг могул коул энд энержи ХХК | Дундговь | Баянжаргалан |
| 14 | Бороо гоулд ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 15 | Буд-Инвест ХХК | Төв | Заамар |
| 16 | Булган гангат ХХК | Төв | Заамар |
| 17 | Бэрхресорсиз ХХК | Увс | Өлгий |
| 18 | Голден Гоби майнинг ХХК | Өмнөговь | Хүрмэн |
| 19 | Дацан трейд ХХК | Хэнтий | Норовлин |
| 20 | Доншен Газрын тос ХХК | Дорноговь | Сайншанд |
| 21 | Дун юань ХХК | Өмнөговь | Номгон |
| 22 | Жамп-Алт ХХК | Баянхонгор | Аймаг |
| | | Дорнод | Баяндун |
| 23 | Жей Кей Эм Кей ХХК | Төв | Аймаг |
| 24 | Зараяа Холдингс ХХК | Дорноговь | Өргөн |
| | | Дорноговь | Хөвсгөл |
| 25 | Капкорп Монголиа ХХК | Өвөрхангай | Төгрөг |
| 26 | Кожеговь ХХК | Дорноговь | Улаанбадрах |
| | | Сүхбаатар | Баяндэлгэр |
| | | Сүхбаатар | Онгон |
| | | Сүхбаатар | Дарьганга |
| 27 | Кью Жи Экс Монгол ХХК | Ховд | Алтай |
| 28 | Мон лаа ХХК | Дорноговь | Хатанбуга |
| 29 | Монгол Алт Мак ХХК | Дорнод | Баянтүмэн |
| | | Дорноговь | Баянжаргалан |
| 30 | Монголболгаргео ХХК | Баянхонгор | Аймаг |
| 31 | Монголрудпром ХХК | Хэнтий | Батноров |
| 32 | Мондулаан трейд ХХК | Төв | Заамар |
| 33 | МоЭнКо ХХК | Ховд | Дарви |
| | | Ховд | Мөст |
| | | Ховд | Булган |
| 34 | Нордвинд ХХК | Хэнтий | Галшар |
| 35 | Петро Матад ХХК | Дорнод | Аймаг |
| | | Дорнод | Матад |
| | | Сүхбаатар | Эрдэнэцагаан |
| 36 | Редхил монголиа ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| | | Сэлэнгэ | Цагаан нуур |

| | | | |
|---|---|---|---|
| 37 | Саусгоби сэндс ХХК | Өмнөговь | Аймаг |
| | | Өмнөговь | Гурван тэс |
| 38 | Сентерра гоулд Монголиа ХХК | Дорнод | Цагаан-Овоо |
| | | Сүхбаатар | Түвшинширээ |
| | | Сүхбаатар | Уулбаян |
| 39 | Сонор трейд ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 40 | Төгрөг нуурын энержи ХХК | Төв | Баян |
| 41 | Ханшижир ХХК | Дархан-Уул | Хонгор |
| 42 | Хар тарвагатай ХК | Увс | Тариалан |
| 43 | Хурай ХХК | Сэлэнгэ | Аймаг |
| 44 | Хургатай Хайрхан ХХК | Хөвсгөл | Аймаг |
| | | Хөвсгөл | Бүрэнтогтох |
| | | Хөвсгөл | Цэцэрлэг |
| 45 | Эрдэнэт үйлдвэр ХХК | Орхон | Аймаг |
| 46 | Эрдэс холдинг ХХК | Сэлэнгэ | Хүдэр |

## 2.8 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр | (48,232) | (413) | (48,645) | - |

***Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- “Сентерра гоулд Монголиа” ХХК нь анхны тайландаа тухайн татварт 1,762.0 мянган төгрөг төлсөн гэж ирүүлсэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрнгүй мэдээлэлдээ тухайн дүнг залруулж ирүүлсэнээр компанийн дүнгээс хасч тохируулсан.
- “Тэн хүн” ХХК анхны тайлангаа санаачлагын албанд гаргаж өгөөгүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж өгсөн тул зохих тохируулгыг хийж зөрүүг шийдвэрлэсэн.
- “Шанлун” ХХК нь санаачлагын албанд өгсөн тайландаа илүү тайлагнаж 48,070.2 мянган төгрөгийн анхны зөрүү үүсгэсэн ба нэгтгэл тайлангийн явцад гаргаж өгсөн дэлгэрэнгүй мэдээлэлдээ уг төлбөрийн дүнг хасч ирүүлсэн тул зохих тохируулыг хийсэн.

## 2.9 Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | (45,577) | 167,372 | 121,795 | - |

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн *анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- “Алтайн хүдэр” ХХК нь санаачлагын ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүйн улмаас 107,878.9 мянган төгрөгийн, “Баян-Эрч” ХХК нь 11,700.0 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн. Нэгтгэл тайлангийн явцад тус компани тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Бороо гоулд” ХХК-иас хүлээн авсан 187,299.2 мянган төгрөгийн төлбөрийг тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад ТЕГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тохируулсан.

- ЗГ нь анхны тайландаа “Шарын гол”ХК-иас хүлээн авсан 92,274.5 мянган төгрөгийн төлбөрийг илүү тусгаснаас зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад Татварын ерөнхий газраас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн хасч, тохируулсан.
- “Хотгор” ХХК нь санаачлагын албанд өгсөн тайландаа 35,835.2 мянган төгрөгийн “Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр”-ийг “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр” хэсэгт андуурч тайлагнаж анхны зөрүү үүсгэсэн байна. Нэгтгэл тайлангийн явцад

дэлгэрэнгүй мэдээлэлдээ залруулж өгсөн тул тохируулгыг хийсэн.

- “Си Өү Эй Эл” ХХК нь анхны тайландаа тухайн төлбөрт 10,000.0 мянган төгрөг төлсөн гэж тайлагнасан байсан ба нэгтгэл тайлангийн явцад уг төлбөрийг төлөөгүй гэж ирүүлсэнээр компанийн дүнг хасч тохируулсан.
- “Таван толгой” ХХК нь анхны тайлангаа санаачлагын албанд гаргаж өгөөгүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад тайланг дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.

### 2.10 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр-*(орон нутгийн төсөв)*

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү, цэвэр |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | (8,568,398) | 6,514,716 | (2,053,682) | - |

***Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон тохируулгаас дурьдвал:***

- ЗГ анхны тайландаа “Оюу толгой” ХХК-иас Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЗДТГ-т төлсөн 6,339,332.0 мянган төгрөгийн төлбөрийг нэтгээгүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЗДТГ-т албан бичиг илгээж, тус сумын ЗДТГ-аас хариу мэдээлэл авч, тохируулгыг хийсэн.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа улсын төсөвт төлсөн 1,511,577.3 мянган төгрөгийн төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн төлбөр хэсэгт давхардуулж тайлагнасан байна. Нэгтгэл тайлангийн явцад компаниас гаргаж ирүүлсэн мэдээллээр нотлогдсон тул хасч, тохируулсан.

### 3. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл

(мян.төг)

| Үзүүлэлт | Анхны нэгтгэлийн зөрүү | Тохируулга | | Шийдэгдээгүй зөрүү |
|---|---|---|---|---|
| | | ЗГ | Компани | |
| Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 12,113,459 | 1,981,964 | 13,925,799 | 169,623 |
| **Нийт** | **12,113,459** | **1,981,964** | **13,925,799** | **169,623** |

***Нийгмийн даатгалын шимтгэлийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:***

ЗГ анхны тайландаа орон нутгийн Нийгмийн даатгалын хэлтэст төлсөн шимтгэлийн дүнг тусгаагүй байна.

- ОҮИТБС-ын ажлын албанд тайлангаа гаргөж өгөөгүйн улмаас дараах компаниуд дээр зөрүү үүссэн байна. Тухайлбал: “АГМ майнинг” ХХК 25,128.6 мянган төгрөг, “Алтайн хүдэр” ХХК 2,991,264.0 мянган төгрөг, “Булгангангат” ХХК 85,175.9 мянган төгрөг, “Буман олз” ХХК 61,435.0 мянган төгрөг, “Гурвантөхөм” ХХК 52,504.6 мянган төгрөг, “Жей Кей Эм Кей” ХХК 79,944.2 мянган төгрөг, “Жи Энд Юу Голд” ХХК 12,440.3 мянган төгрөг“Коммод” ХХК 5,367.3 мянган төгрөг, “Тэн хун” ХХК 244,111.1 мянган төгрөг, “Эжбалей” ХХК 155,292.1 мянган төгрөгийн зөрүү тус тус үүссэн ба эдгээр компаниуд нь нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг, дэлгэрэнгүй мэдээллийн хамт гаргаж ирүүлсэн тул зохих тохируулгыг хийсэн.
- ОҮИТБС-ын ажлын албанд гаргаж өгсөн тайландаа “Адуунчулуун” ХК 188,186.1 мянган төгрөг, “Андын тэмүүлэл” ХХК 5,656.9 мянган төгрөгийн шимтгэлийг огт тусгаагүйгээс зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ нэмж тусгасан тул тохируулгыг хийсэн.
- ЗГ нь анхны тайландаа “Бүүргэнт” ХХК-иас төлсөн 12,498.9 мянган төгрөг, “Зараяа Холдингс” ХХК-иас төлсөн 68,129.0 мянган төгрөг, “Кожеговь” ХХК-иас төлсөн 608,101.1 мянган төгрөгийн шимтгэлийг тусгаагүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад НДЕГ-т хандаж, холбогдох мэдээллийг авч, тохируулсан.
